

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 03 дугаар сарын 28-ны өдөр, Мягмар гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-4</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>5-82</i>
<hr/>	
<i>1. Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл нарын 6 гишүүн 2022.08.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	<i>5-23</i>
<i>2. Эрүүл мэндийн даатгалын гүйцэтгэлийн санхүүжилтийн хэрэгжилтийн явц, эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудлын талаар Эрүүл мэндийн сайдын мэдээллийг сонсох</i>	<i>23-57</i>
<i>3. Байнгын хорооны 2022.04.12-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор байгуулагдсан Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг сонсох</i>	<i>57-79</i>
<i>4. “Чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл</i>	<i>79-82</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 03 дугаар  
сарын 28-ны өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны  
товч тэмдэглэл**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 12 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут, С.Ганбаатар, Ц.Сандаг-Очир.

**Нэг.Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл нарын 6 гишүүн 2022.08.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг дэмжих хэлтсийн дарга Б.Алтанбагана, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн судалгааны газрын дарга Л.Эрдэнэбаяр, Жендерийн үндэсний хорооны Нарийн бичгийн дарга, ажлын албаны дарга Т.Энхбаяр, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, мөн газрын Бодлого зохицуулалтын хэлтсийн дарга А.Гэрэлзаяа, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга Б.Мөнхзул, мөн зөвлөлийн гишүүн Р.Сансармаа, Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадвар судалгааны төвийн захирал Б.Лакшми, мөн төвийн судлаач Э.Тунгалаг, Хуульч Х.Баасанжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Б.Бейсен, Б.Жаргалмаа, Ж.Чинбүрэн, Ц.Идэрбат, Ц.Туваан нарын тавьсан асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Жендерийн үндэсний хорооны Нарийн бичгийн дарга, ажлын албаны дарга Т.Энхбаяр, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга Б.Мөнхзул, мөн зөвлөлийн гишүүн Р.Сансармаа, Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадвар судалгааны төвийн захирал Б.Лакшми, Хуульч Х.Баасанжаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат 14 цаг 36 минутаас 14 цаг 56 минутад хуралдааныг даргалав.

**П.Анужин:** Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 2  
Бүгд: 13  
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 15 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр. Эрүүл мэндийн даатгалын гүйцэтгэлийн санхүүжилтийн хэрэгжилтийн явц, эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудлын талаар Эрүүл мэндийн сайдын мэдээллийг сонсох***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн сайдын зөвлөх Ц.Эрдэмбилэг, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэр, мөн яамны Эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд, Бодлого төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Оюунцэцэг, мөн газрын Судалгаа төлөвлөлтийн хэлтсийн дарга Э.Оюунсүрэн, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Оюунчимэг, Санхүү эдийн засгийн газрын Санхүү, даатгалын хэлтсийн дарга Л.Мөнхцэцэг, мөн газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Т.Хонгорзул, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын дарга Л.Зэндмаа, мөн газрын Эм хангамжийн газрын дарга Г.Цэцэгсанаа, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Худалдан авалт, гэрээлэлтийн газрын дарга Б.Оюунцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, референт Г.Нямсүрэн, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Х.Хэрлэн нар байлцав.

Эрүүл мэндийн даатгалын гүйцэтгэлийн санхүүжилтийн хэрэгжилтийн явц, эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудлын талаар Эрүүл мэндийн сайд С.Чинзориг мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, М.Оюунчимэг, Б.Баярсайхан, Б.Жаргалмаа, Б.Бейсен, Ж.Чинбүрэн, Ц.Туваан, Д.Сарангэрэл нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн сайдын зөвлөх Ц.Эрдэмбилэг, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Эрүүл мэндийн даатгалын гүйцэтгэлийн санхүүжилтийн хэрэгжилтийн явц, эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудлын талаар Эрүүл мэндийн сайдын мэдээллийг сонсов.

Мэдээлэлтэй холбогдуулан Байнгын хорооны дарга П.Анужин Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай, Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх чиглэлийг өгөв.

*Уг асуудлыг 17 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав. Байнгын хорооны 2022.04.12-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор байгуулагдсан Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах чиг***

**үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг сонсох**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Д.Чинзориг, мөн яамны Гэр бүл бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Хүн амын хөгжлийн газрын дарга С.Булгантамир, Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Ж.Азжаргал, Соёлын дэд сайд М.Батбаяр, Соёлын яамны Соёлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Наранцэцэг, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Л.Нямгэрэл, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Э.Насанбаг, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Л.Нямдорж, Боловсрол шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын дарга Б.Гантулга, Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Хунан, Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Өлзийхутаг, мөн газрын Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ш.Чинбат, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын хөгжлийн газрын дарга Ө.Ган-Өлзий, Сүхбаатар дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн дарга Б.Бадамцэцэг, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, дэд хурандаа П.Болормаа, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Б.Батзориг, “Элтэй ертөнц” төрийн бус байгууллагын тэргүүн Т.Туяажаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, референт Г.Нямсүрэн, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Х.Хэрлэн нар байлцав.

Байнгын хорооны 2022.04.12-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор байгуулагдсан Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, М.Оюунчимэг, Ц.Туваан, Д.Сарангэрэл нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга П.Анужин, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Соёлын дэд сайд М.Батбаяр, Боловсрол шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын дарга Б.Гантулга, Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Л.Нямгэрэл нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Б.Баярсайхан нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны 2022.04.12-ны өдөр 09 дүгээр тогтоолоор байгуулагдсан Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хянах, шалгах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг сонсов.

*Уг асуудлыг 18 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв. “Чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, референт Г.Нямсүрэн нар байлцав.

Тогтоолын төслийн танилцуулгыг Байнгын хорооны дарга П.Анужин танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, М.Оюунчимэг нарын тавьсан асуултад Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан, Байнгын хорооны дарга П.Анужин нар хариулж, тайлбар хийв.

**П.Анужин:** “Чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 4

Бүгд: 12

66.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 4 цаг 51 минут үргэлжилж, 16 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 81.2 хувийн ирцтэйгээр 19 цаг 03 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

П.АНУЖИН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 03 дугаар сарын 28-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”  
танхим 14 цаг 12 минут

### НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**П.Анужин:** Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 56.2%-тай бүрдсэн тул Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хуралдаанд хүрэлцэн ирсэн болон ирээгүй гишүүдийг та бүхэндээ танилцуулъя. Анужин ирсэн. Баярсайхан гишүүн ирсэн байна. Бейсен гишүүн ирсэн. Жаргалмаа гишүүн ирсэн байна. Оюунчимэг гишүүн ирсэн байна. Сарангэрэл гишүүн ирсэн байна. Чинбүрэн гишүүн ирсэн байна. Чинзориг гишүүн ирсэн байна. Идэрбат нарын гишүүд хуралдаа хүрэлцэн ирсэн байна.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя. Хамгийн эхэнд Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл нарын гишүүдээс 2022 оны 8 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн ийм хуулийн төсөл байгаа. Энэ хуулийг хэлэлцэх эсэхийг бид нар өнөөдөр Байнгын хороогоор хэлэлцэнэ.

Дараагийн асуудал Эрүүл мэндийн даатгалын гүйцэтгэлийн санхүүжилтийн хэрэгжилтийн явц, эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудлын талаар эрүүл мэндийн сайдын мэдээллийг бид нар сонсох ёстой байгаа.

Дараа нь Байнгын хорооны 2022 оны 4 сарын 12-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор байгуулагдсан Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, Хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг сонсоно гэсэн ийм чухал хариуцлагатай асуудлууд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар орж ирж байгаа юм. Хэлэлцэх асуудалтай холбоотой өөр саналтай гишүүд байна уу. Санал байхгүй бол хэлэлцэх асуудал руугаа оръё.

**Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл нарын 6 гишүүн 2022.08.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хуулийн төслийн танилцуулгыг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл хийнэ. Сарангэрэл гишүүн Таныг микрофонд урьж байна.

**Д.Сарангэрэл:** Нийгмийн бодлогын байнгын хорооны эрхэм гишүүд та бүхнийхээ энэ өдрийн амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, А.Адьяасүрэн, П.Анужин, Б.Баярсайхан, Х.Булгантуяа, Б.Жаргалмаа, Г.Мөнхцэцэг, Ц.Мөнхцэцэг, С.Одонтуяа, М.Оюунчимэг, Д.Өнөрболор, Б.Саранчимэг, Ч.Ундрам нарын эмэгтэй

гишүүд бид 2022 оны 8 дугаар сарын 19-ний өдөр “Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай” хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Сүүлийн жилүүдэд дэлхий нийтээр жендерийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох үйл ажиллагаа улам эрчимтэй явагдаж байна. Дэлхийн олон улс оронд эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь бодит оролцоог нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлдэг сайн жишиг хэдийнээ тогтоод байна.

Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих эдийн засгийн хувьд чадавхжуулах нь улс орны бизнесийн орчныг бүхэлд нь эрчимжүүлээд зогсохгүй гэр бүлийн орлого өсгөх, амьдралын чанар сайжрах, хүүхдийн эрүүл мэнд, боловсролд оруулах хөрөнгө оруулалт 4 дахин нэмэгддэг тухай судалгаа байгаа нь нийгмийн олон асуудлыг цогцоор нь шийдвэрлэх чухал хөшүүрэг гэж үздэг.

Улмаар эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоо нэмэгдэх нь хүн амын өсөлт, улс орны ирээдүйн хөгжилд онцгой чухал үүрэгтэй.

Манай улс бизнес эрхлэгч эмэгтэйчүүдтэй холбоотой ангиллыг эрх зүйн хүрээнд албан ёсоор тодорхойлж төр бодлогоор дэмжих талаар нарийвчилсан эрх зүйн зохицуулалтгүй явсаар иржээ. Нэгдсэн Үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр болон холбогдох байгууллагуудын хийсэн судалгаагаар Монгол Улсад бизнес эрхлэгчдийн хүйсээр ангилсан тоон мэдээлэл дутмаг байна. Энэ нь эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байна. 2021 оны ААН-ийн тооллогоор нийт 147000 аж ахуйн нэгж бүртгэгдсэнээс 37 хувь нь эмэгтэй захиралтай байна.

Эдийн засгийн тэргүүлэх салбар болох уул уурхай, барилга, эрчим хүч, зам тээврийн салбарт эрэгтэй захирал 80-аас дээш хувь, худалдаа үйлчилгээ, хүнсний салбарт эмэгтэйчүүд давамгайлж байна. Нэгдсэн Үндэстний байгууллагын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тусгаснаар нийгмийн харилцааны бүхий л салбарт хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах нь тогтвортой хөгжлийн суурь болдог гэж үздэг.

Энэ хуулийн төслийг боловсруулах болсон хууль зүйн үндэслэл нь:

Нэг.Эмэгтэйчүүдийг алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенцын 11 дүгээр зүйлийн Эрэгтэй, эмэгтэйчүүдэд ажлын хувьд тэгш хандах, ажлын чанарыг адил үнэлүүлэх, банкны зээл авах, үл хөдлөх хөрөнгө барьцаалах болон бусад хэлбэрээр санхүүгийн зээл авах эрхээр хангах тухай олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлнэ.

Мөн алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.8-д нийгмийн амьдралын бүх хүрээнд эмэгтэйчүүд үр дүнтэй оролцох, манлайлан ажиллах, тэгш боломжоор хангагдах боломж үүсэх юм.

Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжсэн хуулийн ач холбогдол:

Хүйсээр ангилсан нэгдсэн мэдээллийн сан бий болж түүнд суурилсан бодлого, хөтөлбөр хэрэгжинэ. Бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийх замаар санхүүгийн хөшүүргүүд зорилтот бүлэгтээ хүрнэ. Олон улсын санхүүгийн төрөлжсөн үйлчилгээнүүдэд эмэгтэй бизнес эрхлэгчид хамрагдах боломж бүрдэнэ. Банк санхүүгийн байгууллагууд эмэгтэй

бизнес эрхлэгчдэд ээлтэй санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх хөшүүрэг болно. Жендерийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлт хэрэгжинэ. Ижил төрлийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүд хоршоолон хамтарч ажиллах боломжууд нэмэгдэнэ.

Өнөөдөр дэлхийн 35 орон эмэгтэй бизнес эрхлэгч хэн бэ гэдгийг тодорхойлсон хуультай байна Азийн хөгжлийн банкны судалгаагаар эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжсэнээр дотоодын нийт бүтээгдэхүүнээ 16.1%-аар өсгөх боломжтой байдаг ийм тоон үзүүлэлт байна. Тиймээс эмэгтэй гишүүд бид Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай анхдагч хуулийн төслийг танилцуулж байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг дэмжиж өгөхийг та бүхнээсээ хүсэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

**П.Анужин:** Хуулийн төслийг танилцуулсан Даваажанцангийн Сарангэрэл гишүүн танд баярлалаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан ирсэн ажлын хэсгийн гишүүдийг та бүхэндээ танилцуулъя. Эрдэнэсайхан Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга, Гэрэлзаяа Жижиг, дунд үйлдвэрийн газрын Бодлого зохицуулалтын хэлтсийн дарга, Зулнхар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд, Алтантулга Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлого хэрэгжилтийг зохицуулах газрын Хөдөлмөр эрхлэлт ажлын байрыг дэмжих хэлтсийн дарга, Эдийн засаг хөгжлийн яамнаас Эрдэнэбаяр Эдийн

засаг хөгжлийн яамны хөгжлийн судалгааны газрын дарга, Жендерийн үндэсний хорооноос хүрэлцэн ирсэн байгаа. Энхбаяр Жендерийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга, Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэх агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газраас ирсэн байгаа. Түрүүн Эрдэнэсайхан даргыг танилцуулсан. Гэрэлзаяа Жижиг, дунд үйлдвэрийн газрын Бодлого зохицуулалт хэлтсийн дарга.

Хуулийн төслийг боловсруулсан ажлын хэсгийн гишүүд хүрэлцэн ирсэн байгаа. Мөнхзул МҮХАҮТ-ын Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга, “Жүр Үр” хариуцлагатай компанийн захирал, Сансармаа МҮХАҮТ-ын Бизнес эрхлэгчийн эмэгтэйчүүдийн зөвлөлийн гишүүн “Траст трейд” компанийн захирал, Лакими Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадвар судалгааны төвийн захирал, Тунгалаг Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадвар судалгааны судлаач, Баасанжаргал Хуульч, Болормаа МҮХАҮТ-ийн тэнхимийн Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөлийн зөвлөх гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр хүрэлцэн ирсэн байна.

Хуулийн төсөлтэй холбоотойгоор асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя. Цагаанхүүгийн Идэрбат гишүүнээр асуулт асуух гишүүдийн нэрсийг тасалж байна. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна.

**М.Оюунчимэг:** Аж ахуй эрхлэгч, эмэгтэйчүүд, жижиг дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих нь өөрөө эдийн засагт ямар их ач холбогдолтой тухайн улсын хөгжилд ч ямар ач холбогдолтой үндэслэл шалтгааны талаар сая Сарангэрэл гишүүн маш тодорхой мэдээлэл өглөө. Яг Азийн хөгжлийн банкны судалгаагаар тэгж гарсан байдаг юм. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн оролцоо тэднийг дэмжиж чадвал тухайн улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 16 хувиар өсөх боломжтой гээд. Одоо яг



манай улсын жижиг, дунд худалдаа эрхлэгчдийн 53 хувийг нь эмэгтэйчүүд эзэлж байгаа юм. Тэгээд яагаад ийм хууль ингээд гарах болов, заавал эмэгтэйчүүд гэх шалтгаан юу байна гээд бас асууж байгаа. Тэгээд сая жишээлбэл Ковид цар тахлын амаргүй үед төр засгаас 10 их наядын тусгай хөтөлбөр гаргасан. Тэгээд бид нар судалгаа хийж үзсэн чинь эмэгтэй бизнес эрхлэгч эндээс хүртэх боломж маш бага, бараг хүртээгүй байсан. Энд бас манай бизнес эрхлэгч эмэгтэйчүүд маань бас хэлэх байх. Сарангэрэл дарга бид нар бүх аймгуудаар яваад та нарт энэ ковид цар тахлын үеийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлээс хүртсэн хүмүүс гараа өргө гэхэд ганцхан Дорнод аймгаас идэвхтэй 1 эмэгтэй би 50 сая төгрөг л хүртсэн. Бусад нь нөгөө үл хөдлөх хөрөнгө, баталгаа зэрэг шалгуурыг нь хангаж чадаагүйгээс хүртэж чадаагүй. Тэгээд бизнесээ хаахад хүрсэн гээд хэлж байсан л даа. Тийм учраас бид нар энэ зайлиггүй бусад улс орны нэгэн адилаар жижиг, дунд үйлдвэрлэл сайн хөгжсөн Бүгд Найрамдах Солонгос, Филиппин, Малайз гээд бусад улсууд яг иймэрхүү төрлийн бас тодорхой хууль гаргаж байж энэ улс хөгжсөн ийм бодит түүх байгаа учраас бид ийм хууль гаргах нь бас цаг үеийн хувьд чухал байна гэж бодоод ийм хуулийг санаачилсан юм. Тэгээд өнөөдөр би бас 1 зүйлийг талархаж хэлмээр байна. Сая надад яг түүрүүн би хэлсэн нөгөө жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн 53% нь эмэгтэйчүүд байгаа гээд жижиг худалдаа, 8 нэрийн бараа гээд над дээр 1 бичиг ирсэн. Бидний эрхийг хамгаалж бидэнд бас дэмжлэг туслалцаа үзүүлэх бололцоо байна уу хуучин Өргөдлийн байнгын хороонд ханддаг байсан одоо хаана хандах вэ гээд. Тэгээд яг энэ дагуу нь нэлээн асуудал нийгэмд өрнөсөн. Харин өчигдөр Си Ю гээд нөгөө сүлжээний дэлгүүр маань жижиг, дунд худалдаа эрхлэгчдийг бүх талаар дэмжихээ илэрхийлсэн ийм мэдэгдэл гаргасан байна лээ. Тийм учраас би бас маш их талархаж байгаа. Бидний

бас энд яригдаж байгаа зүйл бас үр дүнд хүрээд ингээд манай томоохон ийм франчайз оруулж байгаа сүлжээ дэлгүүрүүд бас ингээд нийгмийн ухамсраа ойлгоод энэнд бас гоё дэмжиж ажиллахаа илэрхийлж бас хамтын ажиллагааг өрнүүлж байгаад бас талархаж байна. Тэгээд би эндээс Жижиг, дунд үйлдвэрийн газрын даргаас асуулт асуух гэсэн юм.

Жишээлбэл 2020 оноос яг энэ ковид гарсны үед төр засгаас яг энэ бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр 1 нь 10 их наяд, нөгөө талаасаа бас Азийн хөгжлийн банк, Сангийн яамнаас жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг тэр дундаа эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй хэд хэдэн зээлүүд гарсан. Энийг бид Эдийн засгийн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор дэмжиж гарсан. Өнөөдөр үр дүнг нь тайлагнаагүй байгаа. Бид нар Монгол банкны мөнгөний бодлогыг хэлэлцэх үед бас л яг ийм тодорхойлолттой байдаг хэр нь судалгаа байхгүй хамрагдсан хүмүүс нь хэд нь мэдэхгүй, ямар ч байсан нөгөө хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр бид нар тэдэн хувийг нь хангасан. Энэ дотроо бол 17 хувь байгаа болов уу, үгүй юу гэх мэт бүдэг бадаг хариултауд өгөөд байгаа юм. Тэгэхээр энэ дээр та бүхэн маань яг энэ албаны хүмүүс маань сууж байна. Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга маань яг 2020 оноос хойших энэ зээлд хэчнээн эмэгтэй аж ахуй эрхлэгч хамрагдаж, үр дүн нь яаж гарав. Эсвэл хамрагдаж чадаагүй бол шалтгаан нь юу байсан талаар нь мэдээлэл өгнө үү. Бас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд маань сууж байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр жишээлбэл эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрт хэчнээн хамрагдаж, үр дүн, гүйцэтгэл нь ямар байгаа талаар мэдээлэл авахыг хүсэж байна. Баярлалаа.

**П.Анужин:** Оюунчимэг гишүүнд баярлалаа. Асуултад Эрдэнэсайхан дарга

хариулъя. 2 номерын микрофоныг өгөөрэй. 3 руу шилжээд хариултаа өгчих.

**Я.Эрдэнэсайхан:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Эрдэнэсайхан. Ер нь бол сүүлийн жилүүдэд Монгол Улсын Засгийн газраас жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдээ дэмжих чиглэлээр ялангуяа ковидын үед бол 10 их наяд гэх мэт нэлээн ажлуудыг зохион байгуулсан. Тодорхой үр дүнд хүрсэн. Энэ дундаа бас Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэдээ бас зээлийн эргэн төлөлтөөсөө нэлээдгүй зээлийг олгосон. 2019 онд нийтдээ 451 аж ахуйн нэгжид 47.4 тэрбум төгрөгийг олгосон. Үүний 234 буюу 52% нь эмэгтэй бизнес эрхлэгчид буюу өнөөдөр бид нар бол яг эмэгтэй бизнес эрхлэгч гэдгээ бол хараахан тодорхойлж чадаагүй. Бид нарын гаргаснаар бол эмэгтэй захиралтай эсвэл бодлогын шийдвэрийн гаргахад дийлэнх олонх нь эмэгтэйчүүд байгаа гэдэг энэ томъёоллоор бол эхний ээлжид эмэгтэй бизнес гэж ингэж өөрсдөө бол тооцоолол гаргасан. Энэ хүрээндээ бол 2019 онд гэхэд 52% нь, 2020 онд бол 249 төсөлд 22.8 тэрбум өгсний 107 нь буюу 43% нь бол эмэгтэй бизнес эрхлэгчдэд, 2022 онд бол 156 аж ахуйн нэгжид 19.2 тэрбум төгрөгийн зээл олгосон. Үүний 74 нь буюу 47% нь эмэгтэй бизнес эрхлэгчдэд өгсөн байгаа. Ингээд хараад үзэхээр 46, 47 орчим хувь нь эмэгтэй бизнес эрхлэгчдэд дэмжлэг олгож байгаа юм. Нөгөө талдаа эмэгтэй бизнес эрхлэгчид маань яг өнөөдрийн байдлаар томоохон аж ахуйн нэгжүүдэд бол бага хувь эзэлдэг. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн ихэнх хувь нь эмэгтэй захиралтай, эмэгтэй бизнес эрхлэгчид байгаа. Зээлийн эргэн төлөлт дээр хараад үзэхээр эмэгтэй бизнес эрхлэгчид маань харьцангуй ийм хариуцлагатай байдаг. Өнөөдөр бид нар Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас зээл авсан чанаргүй зээлийн хувьд анализ хийгээд үзэхээр нийт чанаргүй зээлийн дөнгөж 30% нь эмэгтэйчүүд, 70% нь эрэгтэй

бизнес эрэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүд байгаа. Тэгэхээр ер нь бол эмэгтэй бизнес эрхлэгчид илүү авсан зээлээ төлөх, илүү дараа нь төслийнхөө дагуу үйл ажиллагаа явуулах эд нар дээр бол илүү үр ашигтай ажилладаг гэж харагдаж байгаа. Баярлалаа.

**П.Анужин:** Оюунчимэг гишүүн тодруулах уу. Зулххар дэд сайд. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд.

**С.Зулххар:** Байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар дамжуулж бизнес эрхлэгчид, хувиараа бизнес эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл бусад хөтөлбөр хэрэгжүүлдэг. Өнгөрсөн 22 жилийн тоон мэдээллийг танд өгье. Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрт өнгөрсөн жил буюу 2022 онд 11.8 мянган иргэн хамрагдаж 21.3 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй болон зээл болон дэмжлэг үзүүлсэн байгаа юм. Эндээс бол 4377 ажлын байр бий болсон байна. Энэ хөтөлбөрт хамрагдсан хүмүүсийн 55% нь эмэгтэйчүүд байсан гэсэн ийм статистик байна. Тэрнээс гадна эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр тухайлсан хөтөлбөр хэрэгждэг. Энийг бол өнгөрсөн 2 жилд хэрэгжсэн тодорхой түвшинд бас үр дүнтэй болж байна гэдэг ийм мэдээлэл байгаа. 3482 иргэн хамрагдсан байгаа юм. Яг одоо эмэгтэйчүүд гэсэн үг. Энэ бол энэ хөтөлбөрт 618 сая төгрөг зарцуулсан байна.

Нөгөөтээгүүр арилжааны банкаар дамжуулж бага хүүтэй зээл олгох Дэлхийн банкны эх үүсвэртэй ийм зээлийг олгож эхэлсэн. Энэ зээлийн эх үүсвэр бол өөрөө 4.4-8.8%-ийн хүүтэй ийм зээлийн эх үүсвэр байсан. Энэ зээл бол бүрэн зарцуулагдсан байгаа юм. Энэ эх үүсвэр бол. 12.8 тэрбум 1439

иргэнд олгосон. Үүний 751 нь буюу 52.2% нь бол эмэгтэй бизнес эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч нар байсан байна гэдэг ийм тоо байгаа юм.

Нөгөөтээгүүр бид нар өнгөрсөн хугацаанд Байнгын хороон дээрээс Их Хурал дээрээс бидэнд байнга чиглэл болгож байсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг бол жендерийн тэгш байдлыг, жендерийн тэнцвэртэй байдлыг хангах чиглэлээр нэн ялангуяа жишээ нь жижиг зээл авч чаддаггүй, зээлд хамрагдаж чаддаггүй ийм иргэдийг түүн дотроо бол эмэгтэйчүүдийг дэмжих чиглэлээр бол та бүхэн анхаарч ажиллах ёстой гэсэн ийм чиглэл өгсөн. Үүний дагуу бол орон нутагт Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхийн газраас олгож байгаа үйл ажиллагаанд энийг анхаарч чиглэл болгож ажилласан.

**П.Анужин:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулъя.

**М.Оюунчимэг:** Дэд сайдын ярьж байгаагаар бол нөгөө Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийнх бол угаасаа бага байдаг шүү дээ. 5-10 сая хүртэлх л байдаг. Хэдийгээр та сая 50 гаруй хувь гэж байгаа ч гэсэн. Тэгээд энэ зээл олгохдоо бол бас амаргүй байж олгогддог. Тэгэхээр та нар манай хувийг өндөр яриад байна. Эрдэнэсайхан дарга та жишээ нь сая эхний 2019 онд 52, 2020 онд 43% нь эмэгтэй захиралтай компани хүртсэн гэж байгаа юм. Гэхдээ энэ дахиад л нөгөө 100-аас доош ихэнх нь 50, 30 сая байна лээ шүү дээ. Тэгэхээр та яг тэр 1 захиралд оногдсон хувь хэмжээн дээр хэлэхгүй юу. Тэрнээс 46-47% гэхээр өндөр сонсогдож байгаа ч гэсэн тэр нөгөө хүртээмж нь тоног төхөөрөмжөө тэр бизнесээ өргөжүүлэх дээр ямар ч бололцоо байдаггүй гэж бид нар судалгаагаар ч хэлж байна. Уулзсан эмэгтэй бизнес эрхлэгчид маань ч ярьж байгаа юм. Тэгэхээр та энэ дээр яг тэр хувь хэмжээ хэлээд өгөх үү. Дээрээс нь “Трастрейд”, “Жүр үр”-ийн захирлууд маань саяынхтай та нар санал нийлэх

үү. Яг ийм эмэгтэй бизнес эрхлэгч эмэгтэй захирлууд ийм өндөр хувиар зээл хүртээд байгаа нь яг бодит үнэн үү. Энэ дээр бас.../минут дуусав/

**П.Анужин:** Маш тодорхой асуулт асуулаа. 3 Номерын микрофонд Эрдэнэсайхан дарга.

**Я.Эрдэнэсайхан:** Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон зээлийн 1 аж ахуйн нэгжид эзэлж байгаа хувийн жин бол дунджаар 100 сая төгрөг байгаа. Бид нар яг энэ эмэгтэйгээ түүгээд одоо түрүүний хэлснээр 234-ийн дундаж нь хэд гэдэг тоог бол хараахан гаргаж чадаагүй байна. Тэгэхээр бид нар энэ тоог бас гаргаад танд хүргүүлье. Жишээлбэл 2019 онд бол 451-ээс 234 буюу аж ахуйн нэгжийн тоогоороо бол 52%, дундаж бодоод үзэх юм бол дунджаар 23 тэрбум төгрөг нь эмэгтэй бизнес эрхлэгчдэд оногдож байгаа юм. Тэр дотроо яг дунджаар 50 сая юм уу, 60 сая юм уу гэдэг тоог бол арай гаргаж амжаагүй байна. Гаргаад танд хүргүүлье.

**П.Анужин:** Буланы Бейсен гишүүн асуулт асууна. Тодруулах уу. Оюунчимэг гишүүний асуусан асуултад 2 бизнес эрхлэгч эмэгтэйчүүд маань хариулт өгье. 4 номерын микрофоныг өгье.

**Р.Сансармаа:** Эмэгтэй бизнес эрхлэгч ийм өндөр хувьтай зээл авдаг уу, энийг тодруулъя, үнэн үү гэж байна. Тэгэхээр энэ хуулийн үндсэн зорилго нь эмэгтэй бизнес эрхлэгч гэдгээ тодорхойлох зорилготой явж байгаа. Яг эмэгтэй бизнес гэж хэнийг ойлгох вэ гэдгээ яам, яаманд ч юм уу эсвэл төрийн бүх байгууллагууд тэр тусмаа гадаадын төсөл хөтөлбөрүүд ч гэсэн бүгд өөрөөр ойлгодог. Монголд яагаад гэвэл нэгдсэн тодорхойлолт байхгүй. Тэгэхээр энэ захирлаар нь ч гэдэг юм уу, жижиг бизнесийг эмэгтэй гээд түүгээд байгаа нь өөрөө буруу л байгаад байгаа. Тэгэхээр энэ хуулийн гол зорилт маань энэ

тодорхойлолтыг 1 тийш болгох байгаа. Баярлалаа.

**Б.Мөнхзул:** “Жүр үр” ХХК-ийн дэд захирал Мөнхзул. Ажлын хэсгийн гишүүн. Тэгэхээр энэ ажлын хэсгийн хүрээнд бид нар Монгол Улсад бизнесийн салбар дахь.../минут дуусав/

**П.Анужин:** 4 номерын микрофонд 1 минут нэмж өгье.

**Б.Мөнхзул:** Эмэгтэйчүүдийн оролцоо ямар байгаа юм бэ гэдэг энэ тоон судалгаа юу байна гэдгийг бол хамгийн эхлээд танилцаж үзсэн. Тэгэхэд бол 2 тоон судалгаа танилцуулсан. 1 нь бол жижиг, дунд үйлдвэрлэлийн газраас жендерт суурилсан судалгаа танилцуулсан боловч энэ нь бол захирлын хүйсээр ангилсан байсан. Нөгөөдөх нь болохоор Монгол банкнаас гаргасан судалгаа байсан. За энэ судалгаагаар болохоор өмчийн эзэмилээр нь жендерлэсэн байх жишээний. Жишээ нь 2 байгаа тоон судалгаа нь гэхэд 2 өөр сууриар хийгдсэн болохоор Монгол Улсад нэгдсэн ийм тодорхойлолт байхгүй болохоор энд яригдаад байгаа жендерт суурилсан тоонууд өөрөө нэгдмэл биш байгаад байгаа юм. Тэгэхээр энэ хуулийн гол зорилт бол эдгээрийг нэгдсэн тодорхойлолттой болгоод хэрэгжүүлэх ийм хууль, эрх зүйн суурь үндсийг нь бүрдүүлж байгаа маш том ач холбогдолтой юм.

**Ц.Идэрбат:** Оюунчимэг гишүүн тодруулж хариултаа авлаа. Одоо жагсаалтын дагуу Бейсен гишүүн асуултаа асууя.

**Б.Бейсен:** Энэ хуулийн төслийг үзэл баримтлалын хувьд зарчмын, хувьд дэмжиж байна. Эмэгтэй хүн хөдөлмөр эрхлэхийн хажуугаар бас үр хүүхдээ өсгөх, хүмүүжүүлэх, боловсрол, эрүүл мэндээ анхаарах цаг нь их байдаг. Ер нь гэр бүлийн хүрээнд ч гэсэн эмэгтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн хугацаа эрэгтэй хүнээс их байгаа. Гэтэл бизнесийн

салбарт эрэгтэй, эмэгтэй хүнийг бол хамаарна. Өрсөлдөөний зарчмаар ажиллана гэдгийг бид бүгд мэдэж байгаа. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн бодлогоор дэмжих шаардлага бол байна уу гэвэл байгаа. Үүний тулд бизнес эрхлэгч эмэгтэй гэж хэн бэ гэдэг тодорхойлолтыг бид нар гаргах ёстой. Гэхдээ аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засагтайгаа оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл Үндсэн хуулиар Жендерийн тэгш байдлын тухай хуулийг бас зөрчиж байна гээд харагдаж байгаа. Энэ дээр анхаарахгүй бол болохгүй нь ээ. Жишээлбэл Үндсэн хуулийн 14 дүгээр зүйл дээр Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна гээд заасан байгаа. Мөн 16 дугаар зүйлийн 16.4 дээр нь ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. 11 дээр нь улс төр, эдийн засгийн, нийгмийн соёлын, амьдрал, гэрлийн харьцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй гэх мэт заасан заалттай зөрчилдөж байгаа юм биш үү. Энийг бас анхаарах шаардлагатай. Тийм учраас энэ ажлын хэсэг бас гарах ёстой. Энийг бас зөрчиж байгаа тал дээр нь анхаарч ажиллана биз дээ.

Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль дээр ингэж заасан байна. 4.1.1 дээр жендер гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгмийн соёлын ба гэр бүлийн харьцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдэн нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдсан тогтсон түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт үзэл хандлагыг гээд байгаа. 4.1.2 дээр жендерийн тэгш байдал гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харьцаанд тэгш эрхтэй оролцож эдийн засаг, нийгэм, соёлын, хөгжлийн үр

шимээс тэгш хүртээж, хөгжил, эрх тэгш хувь нэмэр оруулснаар жендерийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг хэлнэ гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл жендерийн энэ хууль чинь эрэгтэй, эмэгтэй тэгш байх ёстой талаар ойлголт юм биш үү. Энийг бас анхаарна биз дээ. Энэтэй холбоотой хуулийн 1 дүгээр бүлгийн 4.1.6 дээр тэргүүн ээлжид гэх хэд хэдэн хуулийн этгээд гээд тухайлан хуулийн хууль тогтоомжийн шаардлага хангасан тохиолдолд тэдгээрээс сонголт хийж шаардлагатай үед аж ахуй эрхлэгч эмэгтэй бүхий хуулийн этгээдийг сонгох гээд заасан байна. 2 дугаар бүлгийн 6.1.5 дээр төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тэргүүн ээлжид хамруулах гээд заасан байна. 6.1.8-д зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх гээд энийг бас анхаарахгүй бол бас тендерт оролцож байгаа улсууд чинь бүгдээрээ гэр бүл, охид, эмэгтэйчүүд рүү компаниа шилжүүлэх асуудал гарах вий. Энийг бас энэ хуулийн зохицуулалт дээр нь сайн тааруулж ажлын хэсэг дээр яаж өгөхгүй бол Үндсэн хуулийг бас Жендерийн тэгш эрх байдлын тухай хуулийг бас зөрчиж байгаа юм байна. Энийг бас анхаараад ажлын хэсэг дээр хамтарч ажиллаад энийг шийдэх нь зөв байх гэсэн санал байна. Энийг яах вэ.

**Ц.Идэрбат:** Бейсен гишүүний асуултад хууль санаачлагчийн зүгээс Сарангэрэл гишүүн хариулна.

**Д.Сарангэрэл:** Ер нь эрэгтэйчүүд болон зарим Улсын Их Хурлын эрэгтэй гишүүдийн зүгээс бас Бейсен гишүүний хэлж байгаа саналыг хэлдэг юм. Тэгэхээр бид энэ хууль санаачлагчид болон ажлын хэсгийн гишүүд та бүхэнд танилцуулах 2 хуудас танилцуулга үндэслэл дээрээ нэлээн сайн гаргаж өгсөн байгаа. Өөрөөр хэлэх юм бол зөвхөн эмэгтэй бизнесийг эрхлэгчийг илүүтэй дэмжих тэдэнд давуу тал олгох тухай асуудал ерөөсөө огт хөндөгдөөгүй. Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын эвлэлдэн

нэгдсэн олон улсын гэрээ конвенцод эрэгтэй, эмэгтэй хүмүүс нийгмийн бүхий л салбарт, бүхий л харилцаанд тэгш оролцох тухай асуудал байгаа юм. Сая бид нар Азийн хөгжлийн банк, Азийн сан манай Монгол Улсын бас холбогдох байгууллагуудын судалгааны дүнг танилцуулсан нь энгийн хэрэг биш л дээ. Яагаад гэвэл эмэгтэй бизнес эрхлэгчдийн өнөөдрийн нөхцөл байдал дэмжигдэж байгаа байдал үндсэндээ тэр Үндсэн хуулиар болон бусад хууль тогтоомжоор олгогдсон тэгш эрхийн тэнцвэртэй байдлын асуудал хангагдаагүй байгаа юм. Энийг л хангая гэж байгаа болохоос биш эмэгтэй хүн илүү давуу байдал эдлэх тухай асуудлыг огт хөндөөгүй гэдгийг би та бүхэнд хэлье гэж бодож байгаа юм. Хэрвээ эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоо нэмэгдэх юм бол миний танилцуулгыг сайн анзаарсан бол олон талын ач холбогдолтой гэдгийг би та бүхэндээ хэлэхийг хүсэж байна. Энийг бол ажлын хэсэг юм уу би гаргаад хийчихсэн судалгаа биш. Азийн хөгжлийн банкны судалгаагаар тухайн улс орны эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоогоо нэмэгдүүлснээр 1 хүнд оногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 16.1%-аар нэмэгдсэн ийм баталгаа байж байгаа юм. Түүнээс гадна олон давуу талууд үүснэ. Эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурь, өрх гэрийн орлого, хүн амын өсөлт гээд олон давуу талыг би түрүүн та бүхэндээ 1 бүрчлэн танилцуулсан. Түүнээс илүүтэй би ажлын хэсгийн гишүүдийнхээ үгийг та бүхэнд хүргэе гэж бодож байгаа. Энд бол ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хуульчид байгаа, статистикчид, судалгаа судалгааныхан. Түүнээс гадна бизнес эрхлээд өөрийнхөө биеэр эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжихийн давуу тал яагаад дэмжигдэхгүй байгаа юм. Дэмжигдэхгүй байгаагаас өнөөдөр бас амсаж байгаа хохирол гээд бүгдийг нь бодитоор хэлэх ийм төлөөлөл байгаа учраас би ажлын хэсгийн гишүүдийгээ саяын Бейсен гишүүний асуултад бас нэмэлт хариулт өгөөч гэж бодож байгаа юм. Бидний өргөн барьсан хууль Үндсэн

хууль зөрчиж байгаа юм уу ийм ялгавартай байдлыг бий болгож байгаа юм уу? Хуульч Баасанжаргал хариулаад, бусад нь бас нэмээд явчихъя гэж бодож байна. Нийгэмд ер нь та бүхний маань үг Улсын Их Хурлын гишүүдийн үгнээс би илүү чухал хэрэгтэй байгаа гэж бодож байна. Түүнээс гадна микрофон шилжүүлэхийн өмнө би Эрдэнэсайхан даргад их талархаж байна. Өнөөдрийг хүртэл бид нар ийм хууль байхгүйгээс эмэгтэй бизнес эрхлэгч хэн бэ гэдгийг тодорхойлсон ийм хуульчилсан заалт байхгүй учраас өнөөдөр нэгдсэн бүртгэлийн сан байхгүй мэдээллийн сан байхгүй. Эмэгтэйчүүд ээ юун дээр үндэслэж хэрхэн яаж дэмжих вэ гэдэг төрийн бодлогыг тодорхойлох суурь нь өөрөө байхгүй байгаа учраас өнөөдөр энэ хуультай болох шаардлагатай гэдгийг Эрдэнэсайхан дарга маань бас олоод харчихсан байна. Надад бол энэ их тийм давуу тал санагдаж байна. Манай ажлын хэсгийнхэн нэмж хариулъя. Баасанжаргал Хуульч. Би шилжүүлчих үү дарга аа.

**Ц.Идэрбат:** Сарангэрэл гишүүний хариулт дээр нэмж хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн гишүүн хуульч Баасанжаргал 3 номерын микрофон.

**Х.Баасанжаргал:** Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Яах вэ би ялгаварлан гадуурхалт гэдэг дээр энэ бол ялгаварлан гадуурхалт биш. Бид нар ганцхан энэ удаа бизнес эрхлэгч төдийгүй улс төрийн оролцоонд ч гэсэндээ бас бид нар эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд квот тавьдаг. Тэгэхээр энэ бүхэн өөрөө цаанаа юу юм гэвэл олон улсын гэрээ конвенцын дагуу эмэгтэйчүүдийн оролцоо бага байгаа салбар дээр хэрэглэж байгаа тэр хөшүүргийг ялгаварлан гадуурхалт гэж үзэхгүй гэж олон улсын гэрээ конвенц дээр заасан байгаа. Тийм учраас энийг бол ялгаварлан гадуурхалт биш юм гэж харах хэрэгтэй.

Хоёрдугаарт гэвэл бас 1 тоог би хэлэхийг хүсэж байна. Ер нь бол дэлхий нийтээрээ жендерийн асуудалд яагаад анхаарал хандуулаад байгаа вэ гэвэл эрэгтэй болон эмэгтэйчүүдийн эдийн засгийн салбараас хүртэж байгаа тэр ялгаатай байдал нь яг энэ хурдаараа явбал 275 жилийн дараа бид нар ойртоно. Өөрөөр хэлбэл эмэгтэйчүүд өнөөдөр эдийн засгаас хүртэж байгаа баялгаа яг эрэгтэйчүүдтэй адилхан хүртэе гэвэл бид нар 275 жилийн дараа л яг адилхан түвшинд хүрнэ гэдэг ийм судалгааг НҮБ хийсэн байдаг. Тэгэхээр энэ бүхнийг хурдасгах тийм хэрэгцээ шаардлага бол байна. Үүнийг улс орон болгон өөрийнхөө бодлогоор зайлиггүй хэрэгжүүлэх үүрэгтэй гэдгийг бас бид нар олон улсын өмнө хүлээсэн байгаа гэдгийг бас нэмж хэлэх нь зүйтэй.

Тэгээд гуравдугаарт хамгийн сүүлд гол зүйл маань юу вэ гэвэл энэ зөвхөн жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан бодлого гэж ерөөсөө харж болохгүй. Сая бид нар статистикуудыг харахлаар яг нөгөө эмэгтэйчүүдэд ээлтэй байгаа юм шиг тоо та бүхэнд харагдсан байх. Гэхдээ эсрэгээрээ бид нар эдийн засгийн том салбар, уул уурхайн салбар, зам барилгын салбарыг хараад үзэх юм бол энд 80-аас дээш хувьд нь эрэгтэйчүүд захирал нь байгаа. Дээрээс нь 80-аас дээш хувьд нь эрэгтэйчүүд ашигийг нь хүртэж байгаа юм. Тэгэхээр бид нар зөвхөн захирал гэж харах юм бол хамгийн эцсийн өмчлөгч болох ашиг хүртэж байгаа тэр хүмүүс маань эмэгтэй хүн биш байх юм бол энэ эдийн засгийн баялаг тэгш шударгаар хуваарилагдаж байна гэж үзэх үндэслэлгүй. Тийм учраас энийг зөвхөн захирал гэдгээр хязгаарлаагүй шүү. Хувь эзэмшигч, хувьцаа, оролцоо гэдгээр нь бас нэлээн өргөн хүрээнд харж ингэж бичигдсэн хууль байгаа юм гэдгийг хэлэх гэсэн юм.

**Ц.Идэрбат:** Бейсен гишүүн тодруулга 1 минут.

**Б.Бейсен:** Энэ хуулийг үзэл баримтлалын хувьд ер нь зарчмын хувьд дэмжиж байгаа л даа. Сая та нөгөө квот эдийн засгийн оролцоо дээр 1 квот тогтоож өгнө. Тэгж тогтоож өгвөл энэ хууль бүрэн хэрэгжих боломжтой юм байна. Тэгэхдээ тэр ямар зарчмаар тогтоох вэ тэр маш зөв байна л даа. Тэгэхгүйгээр зүгээр ерөнхийдөө оруулчихаар чинь тэгээд л янз бүрийн улсууд орчихдог квотын асуудлыг яаж тогтоох вэ та ямар бодолтой байна энэ дээр.

**Ц.Идэрбат:** Тодруулга дээр ажлын хэсгээс хэн хариулах вэ. Жендерийн үндэсний хорооны ажлын албаны дарга Энхбаяр. 3 номерын микрофон.

**Т.Энхбаяр:** Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйл Бейсен гишүүний асуултад бас нэмэлт тодруулга өгье гэж бодож байна. Бид нар нөгөө тусгай арга хэмжээг авч хэрэгжүүлж болно гэдэг ийм хуулийн заалт байгаа. Тэр нь юу гэсэн үг вэ гэхээр эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн өмнө тулгамдаж байгаа жендерийн асуудлыг бид нар баланстай барихын тулд тодорхой урамшууллын буюу хөшүүргийн дэмжлэг арга хэмжээнүүдийг авч болох нь өөрөө Үндсэн хуульд заасан ялгаварлан гадуурхал биш юм гээд. Өнөөдөр энийг хэрэгжүүлж байгаа сонгодог жишээ бол нөгөө Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд заасан квот байгаа. Мөн Монгол Улсын Боловсролын Их сургуулиас энэ хөшүүргийг хэрэглээд сургуулийн өмнөх насны буюу цэцэрлэгийн багшаар эрэгтэй элсэгчид байхгүй байгаа. Тэгэхээр хэрвээ эрэгтэй элсэгчид орох юм бол сургалтын тодорхой төлбөрийг хөнгөвчилнө гэдэг ийм тусгай арга хэмжээнүүд авч хэрэглэж байгаа юм. Тэгэхээр өөрөөр хэлбэл эмэгтэй бизнес эрхлэгчдэд зайлшгүй нөгөө нийгэм, эдийн засаг, хууль зүйн хөшүүргүүдийг бид нар хийж

өгөхийн тулд энэ нөгөө хууль өөрөө.../минут дуусав/

**Ц.Идэрбат:** Дараагийн асуулт асуух гишүүн. Улсын Их Хурлын гишүүн Чинзориг.

**С.Чинзориг:** 2, 3 зүйл тодруулъя. Энэ хуулийнхаа нэрийг манай эмэгтэйчүүд юу гэж бодсон юм бол. Ингээд аж ахуйн хэрэглэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх гэсэн хуулийн төсөл бол өргөн барьсан байх. Би бодохдоо ерөөсөө эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай гэсэн ийм өргөн утгаар нь яагаад авч үзээгүй юм бэ? Энэ гол нь их чухал асуудал энэ шүү дээ. Тэгээд эмэгтэйчүүд дотор яагаад зөвхөн ялгаж байгаа ч гэх шиг. Зөвхөн аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог гэж ялгаж авч үзсэн юм. Харин нөгөө талаас аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих гэж байгаа бол заавал эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх гэдэг томъёоллоор биш, аж ахуй эрхлэгч, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих тухай гээд яагаад томъёолж болоогүй юм гэсэн ийм 1 асуулт байх юм. Би бол ойлголтын л асуудал яриад байна л даа.

Нөгөө талдаа энэ аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүд дотор чинь орж байна уу, үгүй юу. Манай эмэгтэйчүүдийн дийлэнх нь нөгөө орлого багатай хэсэгт худалдаа, нийтийн ахуй үйлчилгээ, эд нар гээд тийм одоо чиглэлд дийлэнх нь ажилладаг. Нөгөө талдаа энэ аж ахуй эрхэлж байгаа эмэгтэйчүүдийн чинь хөдөлмөр эрхэлж байгаа эмэгтэйчүүдийн чинь дийлэнх нь нөгөө албан бус секторт бас явдаг шүү дээ. Тэгэхээр энэ албан бус секторт хөдөлмөр эрхэлж буй эр эмэгтэйчүүд чинь энэ та бүхний энэ дотор орж байгаа юм уу, орохгүй байгаа юм уу. Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүд гэдэг дотроо та бүхэн албан бус секторт хөдөлмөр эрхэлж байгаа эмэгтэйчүүддээ оруулж тооцож байгаа юм уу, оруулахгүй байгаа юм уу. Хэрвээ

оруулахгүй байгаа бол яагаад одоо ингээд ялгаж байгаа юм бэ.

3 дахь асуудал. Хэрвээ энэ аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүд дотор чинь тэр би энэ хуулийн чинь бичвэрийг харахаар тэр албан бус секторт хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийн асуудал ер нь хөндөгдөөгүй юм шиг байх юм. Зөвхөн аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүд гээд явчихвал тэр албан бус секторт хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүд чинь орхигдох юм биш үү. Гол хөдөлмөр эрхэлж байгаа эмэгтэйчүүдийн гол масс нь тэнд явдаг шүү дээ.

3 дахь асуудал нь төр ер нь энэ аж ахуй эрхэлж байгаа, бизнес эрхэлж байгаа эмэгтэйчүүдийг ер нь яаж дэмжих юм бэ гэдгээ та бүхэн хэр оновчтой тодорхойлж чадсан юм бэ. Энийгээ маш тодорхой оновчтой тодорхойлж чадахгүй бол энэ чинь тэгээд хийсвэр 1 лоозонгийн өнгө аястай, хэрэгжүүлэхэд хэцүү хэрэгждэггүй 1 хуультай ийм юм болчих вий дээ. Энэ юмыг нь та бүхэн яаж тааруулсан юм. Би тэр төрөөс дэмжих гэж байгаа юмыг нь харлаа л даа. Их л ерөнхий л юмнууд байх. Лоозонгийн маягтай. Тэгээд төр ийм маягийн чиглэлээр дэмжлэг үзүүлнэ гэвэл энэ чинь ерөөсөө явахгүй байна шүү дээ. Нөгөө талдаа энэ аж ахуй эрхлэгч дотроо та бүхэн тэр албан бус секторт хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдээ оруулж тооцож байгаа юм уу, үгүй юм уу, оруулахгүй байгаа юм уу. Хэрэв оруулж байгаа бол тэр албан бус секторт хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийг яаж бид нар албажуулах юм бэ. Албан сектор руу оруулж ирэх юм бэ. Ямар дэмжлэг үзүүлэх юм бэ. Ядаж л нөгөө нийгмийн даатгалын шимтгэлийг нь төлдөг болгох эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь төлдөг болгох гээд өөр маш олон тийм нарийн жижиг сажиг гэхгүй зохицуулалтууд хэрэгтэй болох болов уу гэж бодоод байх юм. Энэ юмнуудыг яаж дэмжиж байгаа юм, шийдэж байгаа юм. Тэгээд тэр аж ахуйн нэгж байгууллагуудын оролцоо гэж юу

байх юм. Өөрөө өөрсдөө л юм хийх юм уу хаашаа юм. Аж ахуйн нэгж байгууллагуудын оролцоо гэдэг чинь тэгээд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих бодлого баримтлах гээд байгаа юм уу.

**Ц.Идэрбат:** Чинзориг гишүүний асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Сарангэрэл гишүүн хариулна.

**Д.Сарангэрэл:** Манай Чинзориг гишүүн аргагүй Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар ажиллаж байсан туршилагатай хүний хувьд маш нарийн асуудлуудыг харж байна. Хуулийн хамрах хүрээ бол бизнес эрхлэлтийн хэмжээгээрээ бол ялгаварлагдахгүй. Бүх эмэгтэйчүүд хамрагдана гэсэн үг. Хөдөө, орон нутагт ажиллаж байгаа манай малчин эмэгтэйчүүд хамрагдах ийм бүрэн боломжтой. Тэгээд бид нар бол зүгээр энэ аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх гэж энэ хуулийн төслөө нэрлэсний учир нь аж ахуй эрхэлж байж тодорхой хэмжээгээр энэ эдийн засагт оролцож чадна л гэж ингэж үзэж байгаа юм. Тэгээд ер нь бол магадгүй энэ хууль маань өөрөө бүх л эмэгтэйчүүдээ дэмжих ийм өргөн агуулгатай учраас ажлын хэсгийн түвшинд хуулийн төслийн нэршилээрээ бас бид эргэж харж ярих бололцоотой гэж бодож байна. Тэгэхдээ манай ажлын хэсгийнхэн Лакими болон манай ажлын хэсгийнхэн бүгд ер нь хэн нь ч байсан саналаа хэлэх бүрэн бололцоотой. Түүнээс гадна төр яаж дэмжих вэ гэдэг дээр бид нар бол энэ хуулийг дагалдан гарах бас хууль тогтоомж журам дээр нэлээн тодорхой заяа гэсэн ийм бодолтой бидний боловсруулсан энэ санаа нь болохоор зэрэг дэлхийн 35 оронд хэрэгжиж байгаа хамгийн түрүүнд ер нь бизнес эрхлэгч эмэгтэй гэж хэнийг хэлэх вэ гэдэг ийм хуулийн томъёололтой болох нь өөрөө төрийн бодлогыг тодорхойлох, олон улсын төсөл хөтөлбөрт хамрагдах, дэмжлэг авах, түүнээс гадна хамгийн гол



нь эмэгтэй бизнес эрхлэгчдийн болон ер нь Монголын бизнес эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн сантай болоод энэ мэдээллийн сан дээрээ суурилад төр бодлогоороо хэрхэн яаж бизнесийг дэмжих вэ гэдэг ийм өргөн боломжийг судалгаагаар харах энэ боломжийг энэ хуулиараа хамгийн түрүүнд нээж өгье гэж байгаа юм. Дэлхийн 35 оронд ингэж хийгдсэн. Тэгээд магадгүй Чинзориг гишүүний маань хэлээд байгаа тийм тодорхой зүйлүүдийг бас тусгахад болохгүй зүйл байхгүй. Энэ бол зөвхөн төслийн түвшинд явж байна. Ажлын хэсгийн түвшинд хэрвээ манай Улсын Их Хурлын гишүүд тодорхой заах ёстой гэсэн ийм шийдэлд хүрэх юм бол бид бас ажиллах боломжтой. Манай Лакими зөвлөх маань нэмж хариульга гэж байна. Хурлын дарга аа.

**Ц.Идэрбат:** Чинзориг гишүүний асуултад нэмэлт хариултыг Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадвар судалгааны төвийн захирал Лакими хариулна. 1 номерын микрофон.

**Б.Лакими:** Сайн байцаана уу. Эрхэм хүндэт гишүүддээ өнөөдрийн мэнд хүргэе. Хуулийн хүрээнд бол бас бид нар энэ аж ахуй эрхлэгч эмэгтэй гэж хэн байх вэ гэсэн яг энэ тодорхойлолтыг нэлээн оруулж өгсөн байгаа. Энэ тодорхойлолт дотроо болохоороо компанийн хэлбэртэй, дээрээс нь нөхөрлөл, хоршоо гэсэн бүхий л хэлбэрийн энэ аж ахуйн хэлбэрийн үйл ажиллагааг эрхэлж байгаа эмэгтэйчүүд орно гэж ингэж томъёолж өгсөн байгаа. Эх өргөнөөр тэгэхээрээ энэ дээр ялангуяа бас малчин эмэгтэйчүүд, малчин өрхүүд ч гэсэн хамтраад өөрсдөө хоршоолол гэдэг юм уу, нөхөрлөл байгуулаад ингээд явах юм бол үүнд хамрагдах боломж нь нээгдэж байгаа юм. Мэдээж бас яг албан бус эдийн засаг бол Монгол Улсын хувьд нэлээн томоохон салбарын нэлээн томоохон хэсгийг эзэлсэн байгаа. Тэгээд энэ хууль бас бий болсноороо бол яваандаа энэ албан руу шилжих боломж нь бүрдэнэ гэж бол бид нар харж байгаа

юм. Тэгээд мэдээж бас яг энэ хуулийн нэр томъёог дэмжээд хэлэлцэхийг та бүхэн бас дэмжвэл бид нар бас яг таны саналыг бас тодорхой зүйлүүдийг хүлээж аваад, тусгаад явах ийм боломжтой байгаа юм. Баярлалаа.

**Ц.Идэрбат:** 4 номерын микрофон хэн билээ. Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимын Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга, “Жүр Үр” компанийн захирал Мөнхзул хариулна. 4 номерын микрофон.

**Б.Мөнхзул:** Чинзориг сайд бол яг бид нарын энэ хууль дээр тусгасан хамгийн гол үндэслэлүүдийн нэгийг яг олж хараад бид нараас асуулаа. Ер нь бол бид нар энэ 30 жилийн хугацаанд эмэгтэйчүүдийн бизнес ямар байсан юм бэ гэвэл өнөөдрийн тоо баримтаас харахаар маш их тархай, бутархай ихэнх нь ер нь албан бус хөдөлмөр эрхлэлт рүү хэтэрхий их татагдан орсон ийм байдалтай байгаа. Тэгэхээр бид нар энүүгээрээ аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүд гэдгийг яагаад онцолсон бэ гэхээрээ нийлээч ээ, нэгдээч ээ, жалгын 1 бүгдээрээ ижил юм хийгээд байдаг: Бүгд л айл өрх бүхэн цагаан идээ боловсруулаад бүгдээрээ борлуулах гээд хичээгээд хамтардаг тэр хөшүүрэг их дутмаг байна гэж харж байгаа юм. Тэгэхээр хамтраад хоршоо, нөхөрлөл юу байдаг юм ямар нэгэн хэлбэрээр ил эдийн засгийн яг зөв эрүүл харилцаа руу та бүхэн ороод ирээч ээ. Тэгэх юм бол та нар энэ хуулийн хүрээнд хамрагдаад эдийн засгийн төрөл бүрийн төрийн бодлого, хөтөлбөр, төсөл энэ бүхнээр дамжаад та нар бизнесээ хөгжүүлж эдийн засгийнхаа боломжийг нэмэгдүүлэх ийм боломжийг нь нээж өгье гэдэг энэ үзэл санаа бол энэ хуулийн бас хамгийн чухал 1 хэсэг нь байгаа. Тэгээд гол нь энэ аж ахуй эрхлэгч эмэгтэй гэдгийг энэ тодорхойлсон хуульчилсан тодорхойлолттой болчих юм бол суурь судалгаатай болох. Энэ суурь судалгаа байж байж ямар бодлого хэрэгжих ёстой юм. Мөн гаднын төсөл

хөтөлбөрүүдэд хамрагдахад суурь тооцоолол, судалгаа л хамгийн чухал байгаад байгаа. Тэгээд ер нь бол албан аж ахуй эрхлэлт рүү бүгдийг нь уриалж байгаа ийм хууль. Баярлалаа.

**П.Анужин:** Чинзориг гишүүн тодруулах уу. Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууна.

**Б.Жаргалмаа:** Баярлалаа. Асуулт гэхээсээ илүүтэй үг хэлээд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдээ дэмжээд үг хэлээсэй гэж бодож байна. Тэгэхдээ Байнгын хорооны хурал дээр үг хэлж байгаа эрэгтэй гишүүд маань ерөнхийдөө бүгд ийм дэмжсэн санал хэлж байгаад бас талархлаа илэрхийлье гэж бодож байна. Ерөнхийдөө жендер гэдэг бол хүйсийн тэгш харилцаа. Ямар ч салбарт, ямар ч зүйл дээр бид эрэгтэй, эмэгтэй гэж ялгахгүй бүгдээрээ тэгш харьцаатай байх нь бол жендер. Тэгэхээр энэ үгийг бид нар бас бүрэн утгаар нь амьдралд хэрэгжүүлэх, олон улсын байгууллагуудаас хийсэн судалгаа мэдээллийг үндэслэх, алдаа оноогоо засах тэр боломж нь энэ хуульд тодорхой хэмжээнд байгаа шүү гэдгийг хэлэхийг хүсэж байна. Нөгөө талаар эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөрийн харьцаа гэх юм бол 2.6 дахин эрэгтэйчүүдээсээ их байгаа нь бидэнд энэ хууль шаардлагатай байгааг харуулж байгаа юм.

Өөрөөр хэлэх юм бол гэртээ хүүхдээ асарч байгаа нөхрийнхөө, хань ижлийнхээ хоолыг хийж байгаа, хүүхдээ өсгөж байгаа ээжүүдийн хөдөлмөр үнэлэгдэхгүй байгаагаас шалтгаалан бид өнөөдөр хөрөнгөгүй байгаад байгаа юм. Хөрөнгөгүй байгаагаасаа шалтгаалаад аливаа нэгэн зээлд хамрагдаж чадахгүй байгаа юм. Зээлд хамрагдаж чадахгүй байгаа учраас бид нар хийж байгаа үйлдвэрлэлээ гэдэг юм уу бизнесээ өргөжүүлэх тэр боломж байхгүй байгаад байгаа юм. Өнгөрсөн намар Төрийн ордонд зохион байгуулсан Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөгөөн дээр

эмэгтэйчүүд энэ зүйлийг маш ихээр онцолсон. Үнэхээр бидэнд үл хөдлөх хөрөнгө алга. Нөхөр маань бизнес эрхэлж байгаа, нөхөр маань ажил хөдөлмөр эрхэлж байгаа учраас надад ямар нэгэн үл хөдлөх хөрөнгө юм уу, хөрөнгө байхгүй барьцаанд тавих хөрөнгөгүйгээс шалтгаалан бид нар зээлд хамрагдаж чадахгүй байна. Энэ бүхэн дээр анхаараад хууль дээрээ бас нарийн заалт оруулж өгөөч гэдэг зүйлийг ярьж байсан. Нөгөө талаар сонгогчтойгоо сая уулзаад явж байсан. 20 дугаар хорооны иргэн надад бас хэлсэн. Гишүүн ээ, би зээл авах гэсэн чинь надад хөрөнгө байхгүй. Эндээс их зүйл шалтгаалж байна. Нөгөө талаар бид нэгэнт тэгш эрхтэй юм чинь квот зааж өгөөд энэ хууль дээрээ заалт оруулж өгөөч ээ. Засгаас олгогдож байгаа аливаа зээл тусламжийн хөнгөлөлттэй зээлийн тодорхой хувийг нь эмэгтэйчүүдэд олгоно гэсэн ийм заалт оруулж өгөх юм бол бид нар зээлд хамрагдах тэр боломжийг тодорхой хувиар дэмжих болно. Энэ заалтыг оруулж өгөөч гэдэг зүйлийг бас хэлсэн. Тэгэхлээр энэ зүйлийг би бас уламжилж онцгойлох гэсэн юм. Үнэхээр хуулийн төслийг боловсруулах явцад гэдэг юм уу бизнес эрхлэгч эмэгтэйчүүдтэй уулзаж байх явцад үнэхээр бидэнд зээл гэдэг юм уу бизнес эрхлэх тэр боломжийг нээхэд тодорхой хэмжээний хөрөнгө санхүүгийн дэмжлэг хэрэгтэй. Үүн дээр хуулийн тодорхой хэсгийн квот зааж өгөөч гэсэн. Сая Бейсен гишүүн маань хэлчихлээ. Үнэхээр ингээд хууль хэрэгжих бодит биелэлийг бий болгохын тулд энэ дээр квот зааж өгөх ёстой гэдэг зүйлийг хэлж байна. Ер нь сая гишүүд маань хэлээд байна. Ингэж ангилах ялгах шаардлагатай юм уу, үгүй юу гэж. Олон улсад хүлээн зөвшөөрсөн олон улсын нэгдэн орсон хууль, эрх зүй, конвенцод нэгдэн орсон конвенцынхоо үүргийг биелүүлэхийн тулд бид нар зайлшгүй шаардлагатай учраас энэ хуулийн төслийг өргөн барьсан байгаа. Тийм ч үүднээс бид нар зарим нэгэн зүйл дээр тодорхой хэмжээний квотыг энэ хуульдаа оруулж өгвөл ямар вэ гэдэг

саналыг хэлснийг би уламжлахыг хүссэн юм. Тэгээд дэмжиж байгаа бас гишүүддээ баярлалаа.

Ер нь яг өнөөдрийн байдлаар зүгээр жишээ аваад ярих юм бол би Билигт гишүүнээ бас энэ дээр хэлмээр байна. Хөгжлийн банкнаас авсан зээлээрээ өмнө нь байсан гишүүд маань зээл аваад яг бодитой үр дүнд хүрсэн гэвэл эмэгтэйчүүдийн сайн жишээнүүд бидэнд олон байгаа. Өнөөдөр зүгээр аливаа зүй сүүлийн хар мэдээллийг гэдэг юм уу хар зүйл дээр буруутгах гэх юм бол бас нийгэм тэр чигтээ эмэгтэйчүүд рүү буруутгасан ийм нөхцөл байдал үүсээд байгаа. Тэгвэл маш олон сайн жишээнүүд байгаа. Ноолуурын үйлдвэрүүд байна. Сайн явж байгаа. Өнөөдөр “Жүр үр” байна ямар сайн явж байгаа билээ. “Ханбогд Кашмер” гээд тэгэхээр олон сайн жишээнүүдийг бид нар өөрсдөө ярих ёстой юм шиг байгаа юм. Жендерийн үндэсний хороо ажлын алба Энхбаяр дарга аа. Ерөнхийдөө бид нар бас.../минут дуусав/

**П.Анужин:** Жаргалмаа гишүүн санал хэллээ. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууна.

**Ж.Чинбүрэн:** Хуулийн үзэл санааг бол дэмжиж байна. Мэдээж Монголын хамгийн их боловсролтой хэсгийг эмэгтэйчүүд эзэлж байна. Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж насыг аваад үзэх юм бол эрэгтэйчүүд нь 9.5 насаар бага настай байна. Тэгэхээр эмэгтэйчүүд маань бие даан эсвэл хань ижлээ алдан ганцаараа үр хүүхдээ юм уу, эсвэл ганцаараа амьдралаа авч явах ч гэдэг юм уу иймэрхүү байдалд орж байгаа нөхцөл байдал нь бид эмэгтэйчүүддээ илүү их анхаарч, эдийн засгийн боломжийг хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх тэр талын туслалцаа дэмжлэгийг бодлогоор хийх нь зүйтэй гэдгийг бол эндээс тоо ярилтгүйгээр бүгдэд нь ойлгомжтой байгаа байх.

Би зүгээр ганцхан зүйл дээр 1 юм тодруулж асуумаар санагдлаа. 6 дугаар зүйлийн 6.1.5-д төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад тэргүүн ээлжид хамруулах гэдэг заалт нь бүх компанийн захирлуудыг эмэгтэй захирал болгочих вий. Мэдээж та бүхэн хэллээ л дээ. Эмэгтэй бизнес эрхлэгч хэн бэ гэдгийн тодорхойлолтыг энэ хуулиараа бид гаргана гэж байна. Тийм ээ. Тэгэхлээр энэ чиглэлд ер нь өөрчлөлт хэр орох боломж магадлал бий вэ. Энэ тал дээр та хэд судалгаа хийж үзэв үү. Энэ талаар 1 хариулт өгөхгүй юу.

**П.Анужин:** Чинбүрэн гишүүний асуултад Сарангэрэл сайд хариулья.

**Д.Сарангэрэл:** Энэ хуулийн төсөл дээр асуулт асууж саналаа хэлж байгаа гишүүд маань бас хуулийн төсөлд ажил хэрэгч хандаж, тодорхой бодитой саналуудыг гаргаж байна. Тухайлбал манай Жаргалмаа гишүүний саяын гаргаж байгаа санал бас анхаарч үзүүштэй санагдлаа. Сая Улсын Их Хурлын чуулганы завсарлагаагаар Улсын Их Хурлын дарга Занданшатар Монгол банкны ерөнхийлөгч, ажлын хэсгийг хүлээж аваад бас олон улсын зээл, төсөл хөтөлбөрийн талаар ярилцсан. Ингээд олон улсын шугамаар хэрэгжих 80 сая долларын төслийн тодорхой хэсгийг жендерийн зээл хөтөлбөр болгох тэр саналыг гаргаж байна лээ. Тэгээд энэ бол бас л эмэгтэйчүүдийг дэмжиж байгаагийн 1 том илэрхийлэл гэж бодож байна. Үүнтэй нэгэн адил сая Чинбүрэн гишүүн маань хэлж байгаа бас л бодит дэмжлэгүүд, тодорхой деталиуд энэ хуульд суувал бас их зүгээр юм гэсэн саналыг гаргаж байна. Ингэхдээ хууль зөрчихгүйгээр тэгш байдал, балансыг барьсан тийм хандлагын заалтууд хуульд орвол илүү дэмжлэгтэй гэсэн ийм санааг хэлж байна. Би бас санал 1 байна. Энэ дээр түрүүн бид бас ярилцсан. Манай Баасанжаргал хуульч, дээр нь би Энхбаяр дарга 2 маань энэ дээр бас нэмэлт

мэдээлэл өгвөл зүгээр болов уу гэж бодож байна. Анужин дарга аа.

**П.Анужин:** 2 номерын микрофонд Энхбаяр дарга хариулт өгье. Жендерийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга. 3 номерын микрофонд хариулт өгье.

**Т.Энхбаяр:** Чинбүрэн гишүүний асуултыг болохоор ингэж ойлгож байна. Нөгөө яг бүх нөгөө эмэгтэй захирал болох марафон явчих вий дээ. Энэ талаар яг хийсэн тийм судалгаа байна уу гээд. Тэгэхээр яг үүний үр дагавар ямар байх вэ гэдэг судалгаа бол бид нарт байхгүй. Одоохондоо хараахан хийгдээгүй байна. Тэгэхээр ерөнхийдөө энэ дээр илүү нөгөө эмэгтэй удирдлага дээр тавиад хэлбэрийн төдий байдлаар нөгөө зээлд хамрагдах мэдээж тэр эрсдэл бас байгаа. Тэгэхээр энийг мэдээж хаасан зохицуулалтыг хууль маань хэлэлцэгдэхийг дэмжигдэх юм бол ажлын хэсгийн хүрээнд илүү нарийвчлаад орох бол бүрэн боломжтой байгаа гэж хариулъя.

**П.Анужин:** Баасанжаргал хуульч нэмэлт хариулт өгье.

**Х.Баасанжаргал:** Би нөгөө хуульчийнхаа хувьд нэмээд хариулах нь зөв байх. Тендерийн үйл ажиллагаа дээр бид нар яах вэ нөгөө эмэгтэй бизнес эрхлэгчийг ганцхан захирлаас нь гадна нэмэх нь 51%-ийг эзэмшиж байгаа бол эмэгтэй бизнес эрхлэгч. Хэрвээ захирал нь байх юм 33.4%-аас дээш хувийг эзэмшиж байж, өөрөөр хэлбэл энэ 2 нөхцөлийг хоёуланд нь хангаж байж эмэгтэй бизнес эрхлэгч юм гэдэг байдлаар хуулийн томъёолол өөрөө орж ирж байгаа юм. Тэгэхээр нөгөө та бүхний яриад байгаа нөгөө хэлбэрийн төдий ийм асуудал руу бас аль болох оруулахгүйн тулд илүү хамгийн эцсийн эзэмшигч нь эмэгтэй хүн байх гэдэг ийм агуулгаар энэ заалт маань нэгдүгээрт орж байгаа.

Хоёрдугаарт гэвэл яг нөгөө тендерийн тухай хууль дээр тэргүүн ээлжид хамруулах гэдэг нь хэрвээ үндэсний үйлдвэрлэл бол хэрвээ хог хаягдал ашиглаж, дахин боловсруулж байгаа бол гээд тендерийн хууль дээр тодорхой нөхцөлүүдэд нэмэлт оноо өгдөг ийм хуулийн заалт байгаа. Тендерийн хууль дээр. Тэр дээр нэмэх нь нөгөө бизнес эрхлэгч эмэгтэй гэдэг заалтыг оруулж байгаа. Сангийн яам тэрийг холбогдох журмаараа нарийвчлаад ямар оноо, ямар хөшүүргүүд байх вэ гэдэг нь дандаа журмаар зохицуулагдаад явчихдаг. Тэгэхээр илүү тэр рүү нь бас чиглүүлж байгаа гэдэг ийм зүйл хэлэх гэсэн юм.

**П.Анужин:** Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя.

**Ц.Идэрбат:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Сая Улсын Их Хурлын чуулганы завсарлагаагаар тойрогт ажиллах үед бол манай эмэгтэйчүүдээс эмэгтэйчүүдийг дэмжсэн, ялангуяа эдийн засгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа эмэгтэйчүүдийг дэмжсэн хууль хэзээ хэлэлцэгдэх вэ, яригдах вэ гэсэн асуултыг бас нэлээн асууж байна лээ.

Тэгээд өнөөдөр бол энэ хуулийг боловсруулсан ажлын хэсэг, санаачилсан гишүүдийг харахад бол бизнесийн салбарт нэлээн анхны жижиг бизнесээс эхлээд л өнөөдөр маш өндөр түвшинд явж байгаа. Мөн дээрээс нь улс орны эдийн засгийн нөхцөл байдлыг үнэлдэг, дүгнэдэг, судалдаг байгууллагын төлөөллүүд оролцсон байгаад бол би бас нэлээн талархалтай байна. Тэгэхээр нэлээн амьдралтай хууль гарах болов уу. Нөгөө талаасаа эмэгтэйчүүдийн нэлээн хүлээлттэй ийм хууль байгаа юм байна гэж ингэж харж байгаа юм. Хүлээлттэй байгаагийн хэрээр энэ хууль маань бас үр дүн маш их өндөр хүлээлттэй байгаа батлагдахаас гадна. Тийм учраас эхнээсээ энэ хууль ямар нэгэн байдлаар лоозонгийн шинжтэй биш, тунхаглалын

биш. Эргээд л яг бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд шууд тусахаар ийм л хууль болоосой. Тийм ч учраас манай гишүүдийн хувьд тодорхой саналуудыг бас оруулах нь зүйтэй гэсэн ийм зүйлийг хэлж байна гэж ингэж харж байгаа. Яах вэ миний хувьд ингээд хараад үзэхээр хуулийн янз янзын зөрчлүүд бас гарах вий гэдэг болгоомжлол байгаа.

Нэгдүгээрт нөгөө сая бол нэлээн хэдэн хүмүүс тайлбарлачихлаа л даа. Үндсэн хуулийн тэр суурь зарчим байх уу, үгүй юу.

Хоёрдугаарт дагалдах баахан хуулиуд өөрчлөгдөх байх. Би бол ганцхан юу гэдэг юм худалдан авалт буюу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль гэдэг энэ хуулийн зөвхөн 10.1.7 гэдэг энэ зүйл, заалтаас гадна өөр олон хуулиуд дээр өөрчлөлт орохгүй бол явахгүй байх гэж ингэж харж байгаа юм. Жишээ нь бидний өнөөдөр байгаа хууль, эрх зүйн орчин бол бодлогын хэмжээнд дэмжлэг үзүүлнэ гэсэн тэр өгүүлбэр ч урьд нь байдаг байсан бол тэр бол худлаа үг болж хувирсан шүү дээ. Яагаад гэвэл хэн нэгэнд давуу эрх олгосон байна гэдэг үндэслэл энэ цаана агуулагддаг болчихсон. Тийм учраас энэ бол бас өөр ганцхан тендерийн хууль гэж яригдаад байдаг энэ хуулиас гадна олон хуулиуд дээр би өөрчлөлт орох ёстой юм байна гэж харж байгаа юм.

Бид нар ингэж олон талаас нь харж энэ хуулийг саадгүй хэрэгжүүлэх бололцоог нь л бүрдүүлсэн хууль батлахгүй бол зүгээр л эмэгтэйчүүдэд 1 маш том хүлээлт үүсгээд л яг гараад л өнөө хуулиа хэрэгжүүлэх гэхээр тийм ч хууль нь болохгүй, ийм ч хууль нь болохгүй гэдэг юм руу орчих болов уу л гэсэн ийм болгоомжлол байгаа юм. Жишээ нь би Эрдэнэсайхан даргаас асуух гэж байна л даа. Яг ЖДҮ-ийн зээлийг олгоход өнөөдрийн өргөн барьсан төслийн хүрээнд дэмжих бололцоо яг байгаа юу. ЖДҮ-ийн зээл өгчихдөг,

материал өгчихдөг. Эмэгтэй хүн учраас надад бас хуулийн зарим 1 зохицуулалтууд үйлчлэх ёстой гээд хараад ирдэг. Тэгэхээр өргөн барьчихсан байгаа өнөөдрийн хуулийн түвшинд би зүгээр тодорхой жишээ асуух гээд байгаа юм. ЖДҮ-ийн зээл өгөх бололцоо байгаа юу. Иргэд яг энийг л хүсээд байгаа юм. Ганц хөдөө аж ахуйн ЖДҮ биш. Энэ чинь орон нутгийн хөгжлийн сан, худалдан авалтууд, жижиг дунд бизнесийг дэмжих сан гээд 3300 сум дээр байгаа шүү дээ. Тэгэхээр яг ийм бололцоо байгаа юу. Та ажлын хэсэгт орж ажилласан хүний хувьд яг таны өөрийн эрхэлсэн ажлын хүрээнд энэ хууль дээр тэр юуг оруулсан уу гэж би асуух гээд байгаа юм. Энийг жирийн бизнес эрхлэгч нар хүсээд байгаа юм.

**П.Анужин:** Эрдэнэсайхан дарга хариулъя. 3 номерын микрофон.

**Я.Эрдэнэсайхан:** Идэрбат гишүүний асуултад хариулъя. Би ажлын хэсэгт орж ажиллаагүй. Өнөөдөр Байнгын хорооноос дуудсан учраас ирээд бас холбогдолтой мэдээллүүдийг хүргүүлж байгаа. Тантай бол санал нэг байгаа. Би бас энэ хуулийн төслийг үзсэн. Хуулийн төслийг дагалдуулаад зөвхөн тендерийн хуульд л өөрчлөлт байгаа. Маш олон хуульд өөрчлөлт оруулж байж яг бодит амьдрал дээр хэрэгжинэ гэдэгтэй бол санал нэг байгаа. Жишээ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулж байж таны хэлдгээр ЖДҮХС-гаас зээл олгох дээр яг бодитой эмэгтэйчүүдийг нь тэргүүн ээлжид дэмжих гэдэг юм уу, илүү боломж олгох ийм нөхцөлийг оруулж өгөхгүй бол яг өнөөдрийн эрх зүйн хүрээнд бол бид нар энэ хууль яг ингэж батлагдлаа гээд бас шууд бодитойгоор эрэгтэй, эмэгтэй 2 өрсөлдөж байхад эмэгтэйг нь шууд дэмж гэдэг ийм зохицуулалт бол орж хараахан чадаагүй байгаа. Бид нар бас судалж үзлээ. Тэгэхээр Засгийн газрын баталсан журам байдаг. ЖДҮХС-гаас зээл олгох, эргэн төлүүлэх, хяналт тавих журам

гээж. Энэ журам дээрээ Засгийн газраар оруулаад, өөрчлөлт оруулаад хийчих боломжтой юм уу гэж харсан. Гэтэл энэ нь дахиад Засгийн газрын тусгай сангийн хууль руугаа ороод, тусгай сангийн хууль дээр ямар эх үүсвэрээс бүрдсэн тохиолдолд ЖДҮХС-аас зээл олгох вэ гэдэг юм руугаа орчхож байгаа юм. Тэгэнгүүт улсын төсөв гаднын буцалтгүй тусламж, зээлийн эргэн төлөлт хүүгийн төлөлтөөс л болж байгаа юм. Тэгэхээр бид нар Азийн сангаас тодорхой хөрөнгийг оруулаад эмэгтэйчүүдээ зөвхөн гаргадаг ийм бүтээгдэхүүн гаргаад явъя гээд Булгантуяа сайдтай ингээд ярьж үзэхээр Засгийн газрын тусгай сангийн хууль дээрээ донор байгууллагуудын зээл гэдэг юм тусгай сангийн хууль дээр байхгүй. Тэгэхээр тусгай сангийн хууль дээр тийм өөрчлөлт оруулсан тохиолдолд бол бид нар ЖДҮХС-аас өнөөдрийн олгож байгаа журмаараа тусгайлсан эмэгтэйчүүдэд зориулсан бүтээгдэхүүн гаргаад зөвхөн эмэгтэй бизнес эрхлэгчдэд олгодог ийм бүтээгдэхүүн гаргаад явах боломж бол харагдаж байгаа. Баярлалаа.

**П.Анужин:** Идэрбат гишүүн тодруулъя.

**Ц.Идэрбат:** Тийм яг ийм байгаа юм. Тэгэхээр бид нар хууль нөгөө лоозонгийн шинж чанартай биш, нөгөө хэрэгждэггүй хуулийн нэг биш, яг бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд батлагдсан цагаасаа үйлчлээд явах үр өгөөжөө өгөх ийм л хууль болоосой л гэж би зориуд асуусан юм. Амьдрал дээр бол тэгээд бол журмаар бүх юмыг зохицуулаа ч гэлээ гэсэн хуулиас давсан журам байхгүй гэдэг ийм утгаараа бас хэрэгжихгүй байх бололцоотой. Тэгэхээр хууль маань өөрөө их тодорхой гарахгүй бол энийг хэрэгжүүлдэг төрийн албан хаагч нар журам биш хуулиа бариад л явчихна. Ийм байгаа шүү гэж бас нэгдүгээрт хэлмээр байгаа юм. Маши их зах зээл байгаа. Жишээ нь яг амьдрал дээр хараад байхад ногоо тарьдаг эмэгтэйчүүдийн асуудал байна. Үдийн хоолны асуудлууд байна.

Маши их хэмжээний мөнгө төгрөг тэнд эргэлддэг. Одоо би нэг санал хэлэх гээд байгаа нь юу гэхээр яг Улсын Их Хурал дээр төрийн өмчийн тендерийн хууль маань хэлэлцэгдэж байгаа энэ цаг үеийг бас ашиглаад.../минут дуусав/

**П.Анужин:** Цэвэгдоржийн Туваан гишүүн та санал хэлэх юм уу, асуулт асуух уу. Туваан гишүүнийг асуулт асуух гишүүдийн нэрсийн дараалалд оруулаад Туваан гишүүн асуулт асууя.

**Ц.Туваан:** Ганцхан асуулт би хоцорч ирж сууж байсан юу ингээд аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүд гээд бас яг нөгөө тодорхойлолт оруулж ирээд зааж байна л даа. Тэгээд энэ дээр яах вэ 1 зүйл тодруулах юм нь болохоор эмэгтэйчүүдийн маш их төлөөлөл хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа. Малчид, малчин эмэгтэйчүүд. Дээрээс нь газар тариалангийн салбар тэр дундаа хүнсний ногоон дээр маш их хүмүүс ажиллаж байгаа. Тэгэхээр энэ эмэгтэйчүүд маань яг энэ хууль батлагдвал эд нар руу яаж очих вэ. Бас нэг арга замыг нь юу гэж харсан юм бол. Малчид нийлээд хоршоо байгуулах юм уу. Эсвэл хүнсний ногоо тарьдаг хүмүүс нийлээд хоршоо байгуулах юм уу яаж очно гэж та хэд ингээж харсан бэ гэдгийг тодруулчихъя.

Хоёрдугаарт бас хэрвээ энэ хууль батлагдаад ажиллавал малчид дээр ялангуяа өрх толгойлсон эмэгтэй малчид, эмэгтэйчүүд бас байгаа шүү дээ. Энэ хүмүүс дээр хуулийн этгээдийн гэрчилгээ авчихсан бас тамгатай, энийгээ яаж эргэлтэд оруулах вэ гээд ингээд хүлээж байгаа бас нэлээн ийм хүмүүс байгаа тэгэхээр энэ тал руу та хэдийн санаачилсан хууль батлагдвал ямар дөхөм, ямар дэм болох вэ л гэдэг асуулт асууя.

**П.Анужин:** 3 номерын микрофонд хариулт өгье.

**Х.Баасанжаргал:** Өмнө нь асуусан бас гишүүний асуулттай нийлүүлээд Туваан гишүүний асуултад хариулъя гэж бодож байна. Нэгдүгээрт энэ хууль анхдагч хуулийн төсөл. Өөрөөр хэлбэл энэ төрлийн харилцааг зохицуулж байсан хууль өмнө нь бид нарт байгаагүй. Тэгэхээр энэ хууль маань тодорхой хэмжээгээр хэрэгжээд Хууль тогтоомжийн тухай хуулиараа 3-5 жилдээ үр дүнгийн судалгаа зайлиггүй хийгдэнэ. Үр дагаврын судалгаа хийгдэнэ гэсэн үг. Тэгэхээр тэр нөгөө бид нарын хүсээд байгаа нөгөө аж ахуй эрхлэгч эмэгтэй гэдэг чинь хэн юм, нөхцөл байдал ямар байгаа юм бэ гэдэг тоотой бид нар дор хаяж 2-3 жилийн дараа нөхцөл байдалтайгаа бид нар яг нүүр тулах юм. Ингэсний дараа бид нар илүү энэ хуулийг нарийвчлах өөр бусад салбарын хуулиуд руу оруулах бүр сайн нарийн ярих юм бол бүр зарим тохиолдолд технологийн хуулиуд руу хүртэл ингэж ордог тохиолдлууд бусад улс орнуудад байдаг. Эмэгтэйчүүдийг тэр салбарт оруулахын тулд. Тэгэхээр бид нар анхдагч хуулийн төсөл гэдэг бас агуулгаар нь илүү өргөн цар хүрээтэй харж байгаа.

Хоёрдугаарт гэвэл бид нар албан аж ахуй эрхлэгч буюу албан бизнес эрхлэлтийг илүү түлхүү энэ хуулиараа бас дэмжиж илүү албан бизнесийн суурийг бид нар өргөсгөх гээд байгаа гэсэн үг. Нөгөө татварын суурь маань бас 1 талаараа нэмэгдэнэ гэсэн үг.

Гуравдугаарт гэвэл орон нутагт ялангуяа Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль, Улаанбаатар хотын нийслэлийн тухай хууль гээд шинэ 2 хуультай холбоотой орон нутаг руу бас нэлээн эрх хэмжээнүүд шилжсэн байгаа. Зөвхөн Засгийн газар гэлтгүй. Тэгэхээр тухайн орон нутаг өөрийнхөө нутаг дэвсгэрт явж байгаа үйл ажиллагаа бизнес эрхлэгчдийг дэмжих бодлогыг өөрөө бас гаргаж ирэх хэрэгжүүлэх ийм чухал бүрэн эрх шилжчихсэн байгаа. Тэгэхээр энэ бүрэн эрхийнхээ хүрээнд орон

нутгийнхаа бизнес эрхлэгчдийг дэмжих тохиолдолд бас хуульд заасны дагуу илүү дэмжлэг үзүүлэх илүү эмэгтэй бизнес эрхлэгчид рүүгээ чиглэсэн бодлогыг заавал тодорхойлно гэсэн ийм чиг үүргийг хүлээлгэсэн байгаа. Ингээд хамгийн сүүлд нь бас аж ахуйн нэгж буюу томоохон нөгөө компани, аж ахуйн нэгжүүд дээр жишээ нь Оюутолгой ч гэдэг юм уу, Энержи Ресурс ч гэдэг юм уу ингээд том хэмжээний компаниуд худалдан авалт болон бусад бодлого дээрээ бас бизнес эрхлэгчдийг дэмжсэн, эмэгтэйчүүдийг дэмжсэн ийм бодлогыг бас тодорхойлж гаргаж ирээч гэдэг ийм салбар, салбар руу бодлогын ерөнхий суурь зарчмыг нэвтрүүлж байгаа ийм хууль тогтоомж бас байгаа юм гэдгийг хэлэх нь зүйтэй байх.

**П.Анужин:** Хуулийн төсөлтэй холбоотойгоор гишүүд асуулт асууж дууслаа. Хуулийн төсөлтэй холбоотойгоор санал хэлэх гишүүдийн нэрсийг авъя. Санал хэлэх гишүүд байхгүй байна.

Улсын Их Хурлын гишүүн Даваажанцаны Сарангэрэл нарын гишүүдээс 2022 оны 8 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Уг саналыг Байнгын хороодын нийт гишүүдийн 84.6% дэмжлээ.

Байнгын хорооны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэгийг томилж байна.

Хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа. Сарангэрэл гишүүн

чинь хуулийн танилцуулгаа хийнэ шүү дээ. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн танилцуулна.

15.19 цаг.

**Эрүүл мэндийн даатгалын  
гүйцэтгэлийн санхүүжилтийн  
хэрэгжилтийн явц, эрүүл мэндийн  
салбарт тулгамдаж буй асуудлын  
талаар Эрүүл мэндийн сайдын  
мэдээллийг сонсох**

Мэдээллийг Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг хийнэ.

**С.Чинзориг:** Байнгын хорооны гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая.

Өнгөрсөн 5 дахь өдөр гишүүний асуулгад хариулахдаа бас гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой эрүүл мэндийн салбарын тулгамдаж байгаа асуудалтай холбоотойгоор бас өөрийн байр суурийг илэрхийлж хариулт өгсөн. Тийм учраас өнөөдөр бас та бүхэнд гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой асуудал, салбарын хууль, эрх зүйн орчныг шинэчлэхтэй холбоотой асуудлаар санал бодлоо хуваалцаж мэдээлэл өгье гэж бодож байна.

Тэгээд гүйцэтгэлийн санхүүжилт гээд бид нар анх энэ гүйцэтгэлийн санхүүжилтийг 2 жилийн өмнө хэрэгжүүлж эхэлсэн. Одоо 3 дахь жил рүүгээ бол орж байгаа. Тийм учраас анх бол энэ хуулийг хэрэгжүүлж эхлэхдээ бид нар дараах 6 зорилт бол дэвшүүлсэн гэж үздэг. Хөнгөлөлттэй эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх гэсэн ийм зорилтыг бид бас энэ зорилтын хүрээнд өгсөн. Одоо бид 33 тэрбум төгрөг байсан бол хөнгөлөлттэй үнийн төсөв бол нэмэгдээд 88, 89 орчим тэрбум төгрөг болчихсон байгаа. Эмийн төвлөрсөн худалдан авалт хийх зохицуулалт хийх гэсэн ийм зорилт бол дэвшүүлж байсан. Гэхдээ энэ эмийн үнэ өссөн асуудал хэвээрээ. Чанарын асуудал бас хэвээрээ байгаа. Эмийн төвлөрсөн

худалдан авалтыг хийх ийм зохицуулалтыг бид бас хийж чадаагүй байгаа гэж үзэж байгаа. Тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах хяналтын тогтолцоог бэхжүүлэх гэсэн ийм зорилт бол дэвшүүлсэн. Бид нөгөө чуулган дээр ч яриад байсан тэр их олонлогоор хянаж байгаа гээд. Нийт нэхэмжлэлийн 15 орчим хувийг хянаж байгаа. Үүгээр бас бид хяналтын тогтолцоог бэхжүүлэх талаар нэлээн дорвитой арга хэмжээ хийх ёстой гэж үзэж байна.

Нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжүүлж давхардлыг арилгана гэсэн ийм зорилт дэвшүүлсэн. Өнөөдөр бид салангид байсан эх үүсвэрийг нэгтгэсэн. Нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээний санхүүжилтүүдийг хийх, нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа гэсэн ийм асуудалтай байгаа. Эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын гүйцэтгэлтэй уялдсан цалингийн тогтолцоог бий болгоно гэсэн ийм зорилт дэвшүүлж ажигласан. Гүйцэтгэлд үндэслэн цалин, урамшууллыг тогтоох бодлого үе шаттай хэрэгжиж байгаа. Гэхдээ эрх зүйн орчныг нь сайжруулах, ялангуяа анхан шатын эрүүл мэндийн байгууллагуудын эмч, ажилтны үндсэн цалинг нэмэгдүүлэх шаардлага байгаа гэж үзэж байгаа.

Эрүүл мэндийн даатгалын санхүүгийн хамгаалалтыг нэмэгдүүлэх гэсэн ийм 6 үндсэн зорилт дэвшүүлсэн байгаа юм. Гэтэл одоо бидэнд ямар асуудал тулгамдаж буй асуудлууд үүсээд байна вэ гэж бид үзэж байна. Тэгэхээр лавлагаа шатын тухайд ийм хэд хэдэн асуудал байна. Программ хангамжийн ачаалал өндөр. Хэрэгтэй мэдээллийг бүртгэж чадахгүй байх ийм асуудлууд байна. Шаардлагагүй хэвтэлт өндөр хэвээр байна гэж үзэж байгаа. Нөөцийн илүүдэл нь эмнэлгийн үр ашгийг бууруулж байгаа асуудлууд байна. Тэгээд өртгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Яаралтай тусламж, жирэмсний



хяналт, өдрийн мэс заслын журмууд нэлээн хоорондоо зөрчилтэйгөөс шалтгаалаад нэлээн асуудал үүсдэг гэсэн ийм асуудлууд байна. Бид энэ лавлагаа шатанд ямар асуудал шийдэх ёстой шийдэл нь юу гэж үзэж байна вэ гэхээр яаралтай тусламж үйлчилгээний эрэмбийг нэлээн тодорхой болгоё. Одоо бол бид ногоон, улаан, хөх гээд 3 өнгөөр яаралтай тусламж, үйлчилгээг ялгаж байгаа юм байна лээ. Тэгээд энийгээ нарийн ялгаж чаддаггүй дандаа улаанаар нь нэхэмжлэл ирдэг. Ингээд асуудлууд нэлээн хүндэрч байгаа гэдэг асуудлууд байгаа юм. Эрчимт эмчилгээний тусламж үйлчилгээ эрүүл мэндийн байгууллагуудад шатлалын зөрөөтэйгөөр нэхэмжлэх тохируулга хийх зайлиггүй шаардлагатай байна гэж үзэж байгаа. Ер нь энэ лавлагаа шатад аймгийн эмнэлэг, дүүргийн эмнэлэг, төрөлжсөн эмнэлгүүдийг шилжүүлснээс шалтгаалаад тусламж үйлчилгээ нь асар их давхардал бий болсон байна гэж бид үзэж байгаа. Энийг засах ёстой гэж үзэж байгаа. Зарим оношны хамааралтай бүлгийн өртгийг дахин тооцоолох, бууруулах саналтай байгаа. Шаардлагагүй хэвтэлтийг бууруулах. Ер нь би тав дахь өдөр хэлсэн дээ. Одоо манайд 42000 ор байна. Монгол Улсад 42000 ор. Ингээд үзэх юм бол дэлхийн дунджаас 4 дахин, өндөр хөгжилтэй орнуудаас бид 2 дахин их ортой байна гэсэн судалгаа байгаа. Гэхдээ яах вэ нөгөө газар нутаг томтой, засаг захиргааны нэгж олонтойгоос шалтгаалаад төв суурин газар улирлын томуу, томуу төст өвчнүүдийн ор хүрэхгүй байна гээд асуудал гардаг. Гэхдээ нийт улсын хэмжээгээр орны илүүдэл байгаа гэдэг ийм асуудлууд яригдаад байгаа юм. Тийм учраас орны тоог бууруулах шаардлагатай. Эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандартыг шинэчлэх ёстой гэсэн. Лавлагаа шатанд бид нарт ийм 6 хүндрэл байна. Ийм 5, 6 орчим шийдлийг арга хэмжээг шинээр авах зайлиггүй шаардлагатай гэж үзэж байгаа юм.

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд дээр тулгамдаж байгаа асуудлууд юу байна гэхээр хүн ам цөөн сумуудад урьд нь зардал өндөр байсан сум дундын эмнэлгийн тусламж үйлчилгээний гүйцэтгэл хангалтгүй байсны улмаас санхүүгийн нэлээн хүндрэлд орсон ийм асуудлууд байна. Тусламж үйлчилгээний төрөл жагсаалт нэлээн тодорхойгүй гэсэн ийм үг хэл асар ихтэй. Программ хангамжийн хөгжүүлэлт анхан шатад тохироогүй зохиомол ачаалал маш их үүсгэсэн. Одоо манай анхан шат ялангуяа сумын эрүүл мэнд, өрхийн эрүүл мэндэд ашиглаж байгаа программ маань хүн төвтэй программ хийгдээгүй юм байна лээ. Үйлчилгээ төвтэй программ хийгдсэн. Тухайлбал сумын эмнэлэг дээр, өрхийн эмнэлэг дээр би нөгөө 4 төрлийн эмчилгээгээ тусламж авахад Чинзориг гээд регистрийн дугаараа ороход нөгөө 4 тусламж үйлчилгээ 4-үүлээ гараад ирдэггүй. Эсрэгээрээ гэрийн эргэлт, нөгөө жирэмсний нярайн хяналт гэдэг тусламж төрөл бүрээрээ орж байж дахиж нэр, регистрийн дугаарыг хийж байж программ шивдэг ийм үйлчилгээ төвтэй программ хийчихсэн учраас ачаалал асар ихтэй ийм үг хэлтэй асуудлууд байгаа юм гэж.

Тэгэхээр бид нар ямар зохицуулалт хийх шаардлагатай байна гэж үзэж байна гэхлээр зарим сумдад бид эрүүл мэндийн төвд коэффициентээр тохируулга хийе. Ялангуяа газар нутгийн хэмжээ алслагдсан байдлаас нь хамааруулаад коэффициент гаргаж коэффициентээр санхүүжилтийн тохируулга хийх замаар анхан шатын сумдын эрүүл мэндийн төвүүдийг дэмжих ийм зайлиггүй шаардлагатай байна. Ийм замаар эмнэлгийн тусламжийн гүйцэтгэл хангалтгүй байгаа нэг хэсгийг нэг иргэний тарифаар нөхөн олгох ийм арга хэмжээ авахаас зайлиггүй шаардлагатай байна гэж үзэж байгаа.

Өрх, сумын эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж үйлчилгээний жагсаалтыг шинэчлэх ялангуяа сумын төвд эрүүл мэндийн төвүүд даатгалаас санхүүжилт авдаг, гүйцэтгэл гардаг тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж зайлиггүй шаардлагатай байна. Анхан шатны программ хангамжийг илүү оновчтой, тодорхой хүн төвтэй ийм программ хийх ийм зайлиггүй шаардлагатай байна. Энэ программ цахим болно гэдэг чинь хүний ажлыг хөнгөвчилж байгаа болохоос биш чирэгдэл учруулдаг, ачаалал их нэмэгдүүлдэг байж болохгүй гэсэн ийм байр суурьтай байгаа. Энэнээсээ шалтгаалаад манай өрхийн эмч нар, сумдын эмнэлгүүдийн эмч нар орой үдшийн цагаар, хагас, бүтэн сайн өдөр асар их ажилладаг ачаалалтай гэдэг ийм үг хэл асар их гарч байгаа. Эрүүл мэндийн даатгалын сан дээр асуудлууд байна. Тулгамдаж байгаа асуудал нь Эрүүл мэндийн даатгалын сангийн тэнцэл сүүлийн жилүүдэд алдагдах шатдаа явсан. 2017 оны эцсээр Эрүүл мэндийн даатгалын сан, Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжихэд чөлөөт үлдэгдэл нь 600 орчим тэрбум төгрөг байсан. Үндсэндээ одоо чөлөөт үлдэгдэл бараг л ч 0 болох чиглэл рүүгээ явчихсан ийм байдалтай байна. Эрүүл мэндийн даатгал, хяналт хийхэд шаардлагатай маягтуудыг өөрчлөөгүйн улмаас маягтаас үүдэлтэй нэхэмжлэлийг бүрэн хянаж чадахгүй байгаа асуудлууд асар их гарч байгаа. Шаардлагагүй хэвтэлтүүд буурахгүй байгаатай холбоотой асуудал байна. Өвчний түүх цахимжаагүйгээс улбаатай хяналтыг сайн хийж чадахгүй байгаа ийм хүндрэлүүд байна. Энэ хүрээнд бид нар ямар асуудал шинээр зайлиггүй хийх шаардлагатай байна гэж үзэж байна гэхээр өвчний түүхийг зайлиггүй цахимжуулах хэрэгтэй байна. Өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээний маягтуудын загварыг шинээр баталж мөрдүүлэх зайлиггүй шаардлагатай. Зарим оношийн хамааралтай бүлгийн өртгийг дахин тооцоолох, бууруулах

сангийн тэнцлийг хангах зайлиггүй шаардлагатай. Нэмэлт сонгон шалгаруулалт хийх эсэх гэдгийг нэг мөсөн шийдэх ёстой гэсэн ийм байр суурьтай байна. Анхан шатны тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудал нэлээдгүй байна. Та бүхэн энэ слайд дээр харж байгаа. Асуудал юу байна вэ гэхээр цөөн хүн амтай сумын эрүүл мэндийн төвийн эмнэлгийн тусламж үйлчилгээний гүйцэтгэл хангалтгүйн улмаас хүндрэл нэлээн орж байгаа.

Хоёрдугаарт нэг иргэнээ тооцсон аргад газар зүйн коэффициентээ тохируулга хийсэн ч эмнэлгийн тусламж, үйлчилгээ хангалтгүй байгаа ийм асуудлууд байна. Сумын эрүүл мэндийн төвийн ачаалал, ажилчдын цалин салбарын ажилчдын дундаж цалингаас доогуур байгаа. Хангалттай санхүүжилттэй хэдий ч цалингаа нэмэх эрх зүйн орчин бүрдээгүй байна. Өрхийн эрүүл мэндийн байгууллагуудад олгож байсан санхүүжилт 2020 оныхоос үндсэндээ 3 дахин нэмэгдчихээд байгаа юм. Өнөөдөр бол. Сумын эрүүл мэндийн байгууллагад олгож байгаа санхүүжилт бол үндсэндээ 2 дахин нэмэгдсэн байгаа юм. Тэгсэн атлаа л бас санхүүжилт хүрэхгүй байна. Үйл ажиллагаа хэвийн явуулахад боломжгүй цалин хөлс бага байна гэдэг ийм асуудлууд гараад байна. Тийм учраас бид нар ямар шинэчлэл өөрчлөлт хийх вэ гэж үзэж байгаа гэхээр санхүүжилт хүндэрч байгаа 26 сумын эрүүл мэндийн төвийн асуудлыг шийдэхдээ 5.6 тэрбум төгрөг нэмж тохируулга хийж, нэмэлт эх үүсвэр гаргаж шийдэх зайлиггүй шаардлагатай. Сумын эрүүл мэндийн төвийн ажилчдын цалинг нэмэгдүүлж, салбарын ажилчдын дундаж цалингаас дээш болгоход 40 тэрбум төгрөгийн нэмэлт эх үүсвэр шаардлагатай байгаа. Ийм замаар тохируулга хийе гэж.

Хоёрдугаарт манай дээр Засгийн газрын тогтоол гаргасан хуулиудыг хэрэгжүүлэхгүй байгаа ийм асуудлууд байгаа юм байна. Тухайлбал Засгийн

газрын тогтоол гаргаад салбарын онцлог, гүйцэтгэлд суурилсан үр дүнг харгалзан үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалин хөлс гэж цалингийн доод хэмжээнээс нэмэгдүүлэх асуудлыг тухайн жилийн батлагдсан төсвийн багцынхаа хүрээнд зохицуулж, шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг Төсвийн холбогдох ерөнхийлөн захирагч нарт даалгасугай гэсэн ийм Засгийн газрын 2022 оны тогтоол гарсан юм байна лээ. Энэ хүрээндээ эрүүл мэндийн салбар төсвийн ерөнхийлөн захирагч нь салбарынхаа багцдаа багтаагаад цалингийн доод жишигийг нэмэгдүүлэх ийм арга хэмжээ аваагүй. Үүнээс шалтгаалаад үндсэн цалингийн доод жишиг нэлээн доогуур байгаа ийм асуудлууд байгаа. Энийг ойрын хугацаанд шийдэх шаардлагатай байна.

Хоёрдугаарт төсвийн хуульд зайлиггүй өөрчлөлт оруулах шаардлага байгаа. Ямар өөрчлөлт оруулах шаардлагатай байна вэ гэхээр сум, тосгоны эрүүл мэндийн төвийн дансны үлдэгдлийг татан төвлөрүүлэхгүй байх чиглэлээр Төсвийн тухай хуульд яаралтай өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа гэж үзэж байгаа. Энэ шийдэгдээгүйн улмаас төсвийн тухайн жилдээ зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ гэсэн ийм Төсвийн тухай хууль мөрдөгдөж байгаа. Энэ бол лавлагаа шатны эмнэлгүүд дээр болж байгаа юм. Анхан шатны сум, тосгоны эрүүл мэндийн байгууллагууд дээр энэ бол болохгүй байгаа юм. Тийм учраас сум, тосгоны эрүүл мэндийн төвийн дансны үлдэгдлийг татан төвлөрүүлэхгүй байх чиглэлээр Төсвийн хуульд бид нар зайлиггүй өөрчлөлт оруулах шаардлагатай болчихоод байгаа гэдгийг хэлье ээ.

Энэ слайд их сонин слайд байгаа. Би 5 дахь өдөр яриад байсан. Ер нь бол манай сумын эрүүл мэндийн байгууллага яагаад гүйцэтгэлийн санхүүжилт

болохгүй байна вэ гэж хэлэв. Би ч өмнө нь зөндөө ярьдаг л байсан. Болохгүй байгаа юм гэж. Өмнө нь бол төсвийнхөө 85, 86 орчим хувийг сумын эрүүл мэндийн байгууллага улсын төсвөөс санхүүжилт авдаг. Үлдэж байгаа 13 орчим хувийн санхүүжилтээ даатгалаас санхүүжилт авдаг байсан юм. Тэгээд 2022 онд бид нар ярьж байгаад энэ болохгүй байна гэж байгаад сумын эрүүл мэндийн байгууллага, өрхийн эрүүл мэндийн байгууллагуудад олгох 1 иргэнээр тооцож олгох санхүүжилтийг 2 дахин нэмчихсэн. Энэтэй холбоотойгоор одоо улсын төсвөөс өрхийн эмнэлэг даатгалын сангаас төсвийнхөө долоохон хувийг өрхийн эрүүл мэндийн төв авч байна. Сумын эрүүл мэндийн төв бол нийт төсвийнхөө 4 орчим хувийг л Эрүүл мэндийн даатгалын сангаас авч байна. Өөрөөр хэлбэл төсвийнхөө 93-96 хувийг улсын төсвөөс авдаг хэвээрээ байгаа байхгүй юу. Өрхийн эмнэлэг сумын эмнэлгүүд. Тэгээд ийм төсвийн бүтэцтэй газруудыг Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүжнэ гэдэг арга руу шилжчихээр ингээд төсвийнхөө бүтцээс шалтгаалаад болохгүй байгаа юм гээд миний үглээд байгаа энэ л дээ. Хуучин 12, 13% байсан юм. Одоо ингээд 1 иргэнээр тооцож авах санхүүжилтийн хэмжээг нь 2 дахин нэмсэн чинь даатгалын сангаас авах санхүүжилтийн хэмжээ нь буураад төсвөөс авдаг санхүүжилт нь асар их болчихсон. Тийм учраас энийг цаашидаа би бол ер нь энэ өрхийн эмнэлэг, сумын эрүүл мэндийн байгууллагууд бараг л 100 хувь улсын төсвөөсөө санхүүжилт аваад явдаг байх энэ тогтолцоо руу л орохгүй бол ийм төсвийн бүтэцтэй байхад даатгалын сангаас гүйцэтгэлийн санхүүжилт авна гэдэг үнэхээр хэцүү. Тийм учраас би сая арга ядахдаа баахан тохируулга хийе гээд юм яриад байгаа юм. Энийг манай гишүүд нэлээн зөв, сайн ойлгох хэрэгтэй байх.

2 дахь асуудал энэ. Энэ их сонин слайд байна лээ. Тэр ертөнцийн зүгээр

хойд талд байгаа нь олон улсад жишгээрээ нийгмийн эрүүл мэнд болоод анхан шатын тусламж үйлчилгээг аль шатдаа их голлодог явуулдаг юм бэ гэж. Олон улсын туршилтаас харах юм бол үндсэндээ 21-100% нь тэр нийгмийн эрүүл мэнд болоод анхан шатын тусламж үйлчилгээ нь голлодог юм байна лээ. Тэгээд дараагийн тэр хөх нь нийгмийн эрүүл мэнд болоод анхан шатын тусламж, үйлчилгээндээ санхүүгийнхээ нөөцийн 50%-ийг нь олон улсад бол нийгмийн эрүүл мэнд, анхан шатны тусламж үйлчилгээнд олгодог. Гэтэл манайхан эсрэгээрээ болчихсон. Нийгмийн эрүүл мэнд болоод анхан шатны тусламж үйлчилгээндээ санхүүгийнхээ ерөөсөө 19.5 хувийг нь манайх хуваарилж байна гэж. Тэгэхээр энэ олон улсын жишгээс бол манай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ уруугаа харчихсан. Санхүүжилт нь ч уруугаа харчихсан. Тэгэхээр бид нар энийг засахаас өөр үггүй байна. Тийм учраас ер нь бид нар цаашидаа нийгмийн эрүүл мэндийн тухай суурь анхдагч хуультай болох тэгээд анхан шатдаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зонхилж үзүүлдэг байх өвчилсөн хойно нь эмчлэх гэж араас нь хөөх биш хөөгөөд ч гүйцэхгүй юм шиг байгаа юм. Тийм учраас урьдчилан сэргийлэх анхан шатны тусламж, үйлчилгээг нэмэгдүүлэх уруугаа харчихсан байгаа санхүүжилтийнхээ тэр 19.5%-ийг нэмэгдүүлэх ийм чиглэл рүү бид нар нэлээд тийм бодлогын шинэчлэлт хийхгүй бол манайх олон улсын жишгээс зөрчихсөн, уруу харчихсан ийм асуудлууд байгаа гэсэн ийм асуудлууд байна.

Дараагийн асуудал би түрүүн ерөнхийдөө товч дурдаад явчихсан. Төсвийн нөлөө ихтэй өртгийг нь бууруулах боломжтой оношны хамааралтай бүлгүүдэд тохируулга хийе гээд. Шаардлагагүй хэвтэлтийн тоо төрийн эмнэлгүүдэд буурахгүй байна гэдэг асуудал байгаад байгаа юм. Яаралтай тусламж үйлчилгээнд онош ахиулах хандлага аймаг, дүүрэг болгонд

лавлагаа шатлалуудад маш их өндөр байна. Ялангуяа лавлагаа шатад 1 шатад шилжсэнээс болоод дүүрэг, аймгийн эмнэлэг, төрөлжсөн эмнэлгүүдэд бол тусламж үйлчилгээ нь асар өндөр тусламж, үйлчилгээ нь давхардалтай болчихсон. Онош ахиулалт өндөртэй холбоотойгоор санхүүжилт олгох тасалдлын хувь өндөр болж байгаа. Хувийн эмнэлгүүд илүү үнэтэй онош руу хөрвүүлэх зөрчил өндөр байгаа. Би 5 дахь өдөр хэлсэн. Ер нь хувийн эмнэлгүүд бол өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ хувийн эмнэлгүүдэд үзүүлсэн 2 хүн тутмын 1 нь өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээ рүү яваад байгаа юм байна лээ. Тэгэхээр нөгөө шаардлагатай, үл шаардлагатайгаасаа хамаараад л хувийн эмнэлэгт үзүүлсэн хүн бол үндсэндээ л тэгээд 2 хүний 1 нь өндөр өртөгтэй оношилгоо руу яваад байгаа юм. Гэхдээ 100% явж байна гэж хэлэхэд хэцүү. Хувийн эмнэлэг болгон өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээ хийдэг мр, компьютер томограф байхгүй учраас тийм тоног төхөөрөмж байхгүй. Эмнэлэгт үзүүлсэн хүмүүс хувийн эмнэлэгт үзүүлдэг мр, компьютер томографт хамрагддаг байх. Гэхдээ л 2 хүний 1 нь өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээнд хамрагдаж байна гэдэг бол бас л өндөр байгаа юм. Тийм учраас зайлиггүй шаардлагатай бол тэр өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээнд хамрагддаг ийм зохицуулалт хийхээс зайлиггүй шаардлагатай асуудлууд байна. Тийм учраас яаралтай тусламж эмийн эмчилгээний оношны өртгийг бууруулах асуудлыг эргэж харъя.

Сувилуудын үзүүлж буй уламжлалтын оношны бүлгийг хааж сувиллаас үзүүлэх оношны хамааралтай бүлэг үүсэх асуудлыг эргэж харъя. Тоо хэмжээ нь илт өссөн. Зарим тусламж үйлчилгээг эргэж харъя гэсэн ийм асуудлууд байна. Хувийн хэвшилтэй холбоотой асуудал дээр сонирхолтой тоонууд байгаа юм байна лээ. Тэгээд гишүүд нэлээн анзаарч ярилцана биз дээ.

Бид хувийн хэвшлийг маш их дэмжиж байгаа. Та бүхэн энэ слайд дээр харж байгаа. Хувийн хэвшилд олгож байгаа санхүүжилтийн хэмжээ бол 3 дахин өсчихсөн байгаа юм. 3 дахин өсчихсөн байгаа юм. Гэхдээ тэр хойд талын тэр шугам дээр нь хараарай. Тэр улаан нь бол нийт эмнэлгийн байгууллагуудын тоон дотор хувийн хэвшлийн эмнэлгийн байгууллагуудын тооны эзлэх хувь нь байгаа юм 56.% гээд өндөр байгаа юм. Тэгээд олгох санхүүжилт нь 3 дахин өсчихсөн. Дүүргийн эмнэлгүүдтэй ижилхэн 200 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт авч байгаа атлаа тусламж, үйлчилгээнээс ачаалал ерөөсөө 7-хон хувийг л үүрээд байгаа юм. 7-хон хувийг. Тэгэхээр цаашидаа энэ хувийн хэвшилдээ санхүүжилт нэм гэхээсээ илүүтэйгээр ачааллыг яаж жигдлэх вэ. Энэ бол шулуухан хэлэхэд аль болохоор нөгөө өртөг өндөртэй, зардал багатай тусламж үйлчилгээг хувийнхан авч тусламж үйлчилгээ үзүүлэх сонголттой байна гэж би тэгж ойлгоод байгаа юм. Тийм учраас дүүргийн эмнэлгүүдтэй ижил хэмжээний санхүүжилт өгөөд байхад тэр дүүргийн эмнэлгүүдээсээ 4 дахин ачаалал үүрнэ гэдэг тэнд сонголт байна гэж. Тийм учраас ачааллыг яаж жигдлэх вэ гэдэг асуудлыг бид нэлээн сайн ярих байх. Хувийн хэвшлийнхэнтэй уулзахаар та бүхэн хамтын төлбөрийг л шийдэж өг л гээд байдаг юм. Тэгээд хамтын төлбөрийг шийдэхээр иргэн хүний халаас руу тэмтрэх асуудал руу орчихно. Зүгээр олгож байгаа санхүүжилтийн хэмжээг нэмэхгүйгээр ачааллыг нь нэмэгдүүлэх ямар арга зам байна вэ. Ийм арга зам хайя л гэсэн ийм бодолтой байгаа гэдгийг та бүхэнд хэлье.

Эмийн хөнгөлөлттэй холбоотой слайдыг гаргачхаарай. Бид нар эмийн хөнгөлөлтийн санхүүжилтийн хэмжээ нэлээн их нэмэгдсэн. Үндсэндээ 3 жилийн өмнөхөөс 3 дахин өсчихсөн юм байна лээ. Сарангэрэл сайдын үед эмийн хөнгөлөлтийн санхүүжилт 30 орчим л байсан. 33 орчим байсан юм байна лээ.

Одоо бол 88, 89 тэрбум болчихсон. Тэгсэн атлаа эмийн чанар муу байна, хүртээмж муу байна гэдэг бол асар их асуудалтай. Тэр эхний слайд дээр харагдаж байгаа нь жаахан хөдөөгийн иргэдтэй уулзахаар та бүхнийг очихоор уулзахаар ярьж л байгаа байх. 50%-ийн хөнгөлөлттэй байсан эм 261 төрлийн эм 50%-ийн хөнгөлөлттэй байсан юм байна лээ. Энийг нь 69 болгоод хөнгөлөлтийг нь бууруулаад 35 хувь болгочихсон. 70%-ийн хөнгөлөлттэй эм 277 байсныг нь хөнгөлөлт бууруулчихсан. Тэгэхээр би буцаагаад энэ хөнгөлөлтүүдийг нь 50%-ийн хөнгөлөлттэй байсан эмийг 50 хувьд нь, 70%-ийн хөнгөлөлттэй байсан эмийг 70 хувьд нь хүргэж нэмэгдүүлье гэсэн ийм чиглэл өгөөд ажиллаж байгаа. Харин тэр новардсын хөтөлбөрийн хүрээнд олгогдож байгаа эмийг яг тэр эмтэй адилхан үйлчилгээ үзүүлдэг эм байгаа бол тэрийг заавал эмийн хөнгөлөлтийн жагсаалтад оруулж сонголттой байлгаад яах вэ. Тэгээд новардсынхаа эмийг олго. Яг энэ эмтэй адилхан чанартай үйлчилгээ үзүүлдэг эмийг энэ эмийнхээ хөнгөлөлтөөсөө хасчихвал яасан юм бэ гээд үндсэндээ бараг л намайг очихоос өмнө хасчихсан байсан юм байна лээ. Тэгээд ийм чиглэлээр явж байгаа. Цаашидаа эмийн хөнгөлөлтийг 50%, 70 хувийнх нь хөнгөлөлттэй өгч байсан эмийг нь олгоод явж байя. Зүгээр 3 сарын 1-ээс 1 өөрчлөлт оруулсан юм нь 5 дахь өдөр ч ярьсан. Хөдөөгийн сумын багийн малчин хөгишин заавал сар болгон сумын төв орж хурууны хээ уншуулж байж энэ хөнгөлөлттэй эмээ авдаг байсныг энэ чирэгдлээ боль гээд заавал багийнхаа эмчээрээ харин жороо бичүүлээд л. Тэгээд хүүхэд нь юм уу, ах дүү нь, хажуу айл нь ч юм уу тэр жороор нь очоод сумын төв ороод эмийг нь авч өгдөг байх ийм боломжийг нь олго гээд. Тэгэхдээ яах вэ 60-аас дээш насны хүн дээр нь ийм боломжийг нь олгоод явуулж байгаа гэдгийг та бүхэнд хэлье.

Тэгээд ийм чиглэлийн өөрчлөлт хийе гэж би ярьж байгаа юм. Миний дүү эргээд тэр цалингийн 2 слайд байсныг

харуулаадах даа боломж байна уу. Би түрүүн хойшлуулаад аваад хаячихсан шүү дээ. Цалин дээр 2 юм би шийдэх ёстой гэж бодож байгаа. Тэр Засгийн газрын тогтоолын дагуу төсвийн багцдаа багтаагаад төсвийн ерөнхийлөн захирагч цалингийнхаа хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг шийдье гэсэн Засгийн газрын 2022 оны 3 сард гарсан 107 дугаар тогтоолын дагуу би бол үндсэн цалинг нь нэмэгдүүлэн тогтоох боломж байгаа юм байна гэж харж байгаа юм.

Хоёрдугаарт тэр Төсвийн тухай хуульд түрүүний хэлдэг сум тосгоны эрүүл мэндийн төсвийн байгууллагуудын дансны үлдэгдлийг буцаан татдаггүй байх чиглэлээр Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулчих юм бол үлдэгдэлтэй гарсан сумууд нь өөрсдөө захиран зарцуулах, цалин хөлсөө нэмэгдүүлэх ийм боломж гарах юм байна лээ. Ийм арга хэмжээг авахгүй байгаа үүднээс одоо манай дээр ямар асуудал үүсээд байна гэхээр эмч нартай уулзахлаар үндсэн цалин бага л гээд байгаа юм. Тэгэхээр үндсэн цалин бага гэдэг нь энэ 107 дугаар тогтоолоор бид нар төсвийн ерөнхийлөн захирагч үндсэн цалинг нь шинэчлэн тогтоож өгөөгүй учраас эх үүсвэр байсан ч гэсэн үндсэн цалингаа нэмэгдүүлэхгүй нэмэгдэл урамууллыг нь нэмээд яваад байгаа юм байна лээ. Тэгэхээр эмч нарын сонирхол болохоор өөрсдийнхөө үндсэн цалинг нэмэгдүүлэх ийм сонирхолтой байгаад байгаа. Тийм учраас ийм арга хэмжээ авъя гэсэн ийм бодолтой байгаа. Энэ дээр яах вэ Та бүхэн цалингийн юуг харж байна. Манайхан энэ дээр одоо яг хэн нь ямар цалин авч байгаа гэдэг яг харагдаж байгаа юм. Аймгийн нэгдсэн эмнэлэг, амаржих газар, дүүргийн эмнэлгүүд, сумын эрүүл мэндийн төв, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг гээд. Энэ дээр харахаар цалин хөлс нь хөөрхөн өсчихсөн юм байна лээ. Бас чамлахаар чанга атга гэж хөөрхөн өсчихсөн. Үндсэн цалин нь бага хэвээрээ байгаад байгаа юм. Энэ нөгөө 107 дугаар тогтоолоор үндсэн цалинг нь

нэмэгдүүлэх арга хэмжээг төсвийн ерөнхийлөн захирагч шийдвэр гаргаагүй учраас үндсэн цалин нь бага хэвээрээ байгаад байгаа. Цалин хөлс гэдэг утгаараа ч гэж хөөрхөн энэ дээр харахаар хөөрхөн өсчихсөн. Сумын их эмчийн цалин гэхэд л одоо 1 сая 900 мянган төгрөг байгаа юм байна лээ шүү дээ. Цалин, хөлс гэдэг утгаараа. Үндсэн цалин нь болохоор бага байгаа юм. Тэр 2 дахь бор шар. Тэгэхээр бид нар 107 дугаар тогтоолын дагуу ийм арга хэмжээ авна. Ингээд цалинг нь нэмэгдүүлэх арга хэмжээ авна.

Хоёрдугаарт манай салбар дээр 1 хийгдээгүй байгаа юм. Ур чадварыг нэмэгдэл олгох журам гарах ёстой. Тэр журам гаргаагүй байгаа юм байна лээ. Тэр журмыг нь би ойрын хугацаанд гаргаж өгье гээд Хөдөлмөрийн, нийгмийн хамгааллын яамтай яриад ажлын хэсэг ажиллаж байгаа. Ийм зүйлийг гүйцэтгэлийн санхүүжилттэй холбогдуулж та бүхэнд хэлье. Гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой асуудалд ингээд ийм өөрчлөлт орохоор нэлээн хэд хэдэн хууль, тогтоомжид өөрчлөлт орох шаардлагатай юм байна лээ. Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлага байгаа. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлага байгаа. Тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа. Мөн олон эрүүл мэндийн сайдын тушаал, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн олон тогтоолуудад өөрчлөлт оруулах шаардлагатай. Ингэж байж бидний саяын хэлээд байгаа тулгамдаж байгаа асуудлуудыг шийдэх гарц гаргалгааг 1 талд нь шийдээд, асуудлыг жаахан цэгцтэй болгох юм болов уу гэсэн ийм бодолтой байна.

Хоёр дахь та бүхэнд өгөх мэдээлэл товчхон эмтэй холбоотой асуудлууд байна. Эмийн асуудал, үнийн асуудал өндөр өссөн, чанар маш муу гэдэг асуудлууд байна. Энэ дээр тэр гол манай зах зээл дээр голлох хэрэглэгддэг 10 нэр

төрлийн эмийг аваад үзэхэд сүүлийн 3 жил 13-114%-аар эмийн үнэ өссөн. Дээд тал нь 114%-аар өссөн. Зөвхөн 10 төрлийн эм дээр аваад үзэхэд. Энэ юун дээрээ гол өсөлт гарч байгаа гэхээр түүхий эдийн үнийн өсөлт, сав баглаа боодлын үнийн өсөлт, валютын хани, тээвэр хадгалалтын зардал дээр голлож гарч байгаа гэсэн ийм асуудлууд байна. Би Шадар сайдтай хамтарсан тушаал гаргаад Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, манай яам, эмийн агентлаг хамтарсан шалгалт эхлүүлсэн. Эхлээд 7 хонож байна. Энэ хамтарсан шалгалтаар эмийн үнэтэй холбоотой, чанартай холбоотой асуудал дээр хаана нь зөрчил их гарч байна вэ бид юун дээр нь алдаж байна вэ. Аль бөөний худалдааны шатад нь уу эсвэл жижиглэн худалдааны шатанд нь чанарын асуудал их доголдож байна уу, үнэ их нэмэгдэж байна уу гэдэг асуудал нэлээн гарах болов уу гэж найдаж байгаа. Тэгээд энэ асуудал гарахаар Байнгын хороонд танилцуулж дараагийн арга хэмжээ авахдаа ийм арга хэмжээ авна гэж бодож байгаа.

Хоёрдугаарт би Татварын Ерөнхий Газар, Гаалийн ерөнхий газартай хамтраад эмийн үнэтэй холбоотой асуудлаар нэлээн судалгаа хийж үзэж байгаа. Нарийн тоог одоохондоо дэлгэрэнгүй ярих боломжгүй. Яагаад вэ гэхээр санхүүгийн тайлагналт и-баримтаас нэлээн мэдээлэл авчихсан учраас нэлээн тийм өндөр өсөлттэй тоонууд байгаа. Тэгэхээр тэр и-баримтад гарсан материалууд нэлээн шүүж үзэж байж, нэлээн нягталж байж Байнгын хороонд гишүүдэд ойлгох мэдээлэл өгье гэсэн ийм бодолтой байгаа. Ийм 2 чиглэлийн хяналт, шалгалтын ажил хийж байгаа. Одоо бол тэр урьдчилсан байдлаар хэлэхэд эм ханган нийлүүлэлтийн бөөний эмийн худалдаа хийх 200 гаруй 20 орчим тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байна. 10 аж ахуйн нэгж л импортын эмийн чинь 85%-ийг нь оруулж ирж байгаа юм байна лээ шүү дээ. 10 аж ахуйн нэгж. Тэгэхээр

энэ жаахан тийм монопол байна уу гэсэн асуудлууд байгаа.

Хоёрдугаарт эмийн импортын ханган нийлүүлэлт эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд хоорондоо асар их худалдаа, солилцоо хийдэг асуудлууд. 462 тэрбум төгрөгийн эмийн борлуулалт орж ирж байна гэсэн ийм судалгаа байгаа юм. Тэгсэн атлаа үүнийхээ 263 тэрбум төгрөгийн эмийг хоорондоо импортлох, эм импортлох зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагууд 263 тэрбум төгрөгийн эмийг хоорондоо худалддаг, солилцдог ийм үйл ажиллагаа яваад байгаа юм. Энэ бол нөгөө өртгийг өсгөж байгаа 1 шат дамжлага байж магадгүй гэж би жаахан бодоод, хардаад байгаа. Нэлээн гүнзгийрч үзье гэсэн ийм нэлээн асуудлууд байна. Эмийн агентлагтай холбоотой асуудал байна. Эмийн агентлагтай болсон нь сайн хэрэг. Гэхдээ өөрийн гэсэн байр байхгүй, хууль ёсны дагуу томилогдсон дарга байхгүй. Өмнөх дарга нь шүүхийн шатанд явж байгаа. Тэгээд дараагийн даргыг нь сонгон шалгаруулаад даргатай болгоё гэхээр өмнөх дарга нь шүүхийн шатанд маргаан үүсгэчихсэн гээд даргыг нь томилж чаддаггүй ийм хэцүү, сонин газартай. Яг одоо зээл дээр борлогдож байгаа эм дээр нь чанарт баталгаажуулалт, хяналт хийж чадаж байна уу гэхээр тоног төхөөрөмж муутай, боловсон хүчин муутай гээд. Одоо слайд дээр харагдаж байгаа тэр 5 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж шаардлагатай. Энийг ишийдээд өгчихвөл бид нар бүрэн хэмжээний хяналт, баталгаажуулалт хийж чадна гэдэг ийм юм ярьдаг сонин газартай. Тэгэхдээ бас нэг агентлагтай байгаа нь их юм. Сайн хэрэг. Гэхдээ нэлээн асуудал байна гэдгийг та бүхэндээ хэлж байна.

Дараагийн та бүхний сонорт хүргэх асуудал эрүүл мэндийн цахимын асуудал байна. Цахимын асуудал бол нэлээн хүндрэлтэй. 2016 оноос хойш Дэлхийн банкттай хамтраад Цахим эрүүл мэнд хөтөлбөр хэрэгжүүлсэн. 2016 онд

хэрэгжээд 2019 онд дуусах байсан хөтөлбөр сунжирч, сунжирч 2020 оны 8 сард анх эхэлсэн юм байна лээ. Тэгээд түүнээс хойш явж байгаад 2022 оны 9 сард Дэлхийн банкны шинжээч ирээд хангалтгүй, 29 хувийн хэрэгжилттэй төсөл байна, төслөө зогсоолоо гээд явчихсан. Сая намайг сайдаар томилогдож очсоны дараахан 2 сарын эхээр Дэлхийн банкны Монголыг хариуцсан захирлаас энэ санхүүжилт төсөл хэрэгжилт нь муу удаашралтай байгаа. 29%-тай гэж манай шинжээчийн баг дүгнэсэн учраас санхүүжилтээ татна гэсэн ийм бичиг ирүүлчихсэн. Засгийн газарт танилцуулсан. Засгийн газар тэмдэглэл гаргасан. Тогтоол гаргаад тэр гүйцэтгэх компанид олгосон 1.7 сая доллароо буцаан татаж төвлөрүүлэх ийм үүрэг өгсөн. Ингээд энэ төсөл маань үндсэндээ ингээд зогсчихсон. Одоо хамгийн хүндрэлтэй асуудал нь төслийг гүйцэтгэгч компанийн боловсруулсан e-hospital программыг 500 эрүүл мэндийн байгууллагууд, сумын эрүүл мэндийн байгууллага, өрхийн эрүүл мэндийн байгууллагууд ашиглаж байгаа. Тэгээд энэ компани нь заргалдахаар энд та нар ашиглаж байгаа гээд эргээд намайг шүүхэд өгөх юм байна лээ. Түрүүний миний хэлээд байгаа үйлчилгээ төвтэй биш хүн төвтэй программ хийчихсэн асар их ачаалал нэмэгдүүлж байгаа гэж яриад байсан программ чинь энэ e-hospital гээд программ. Энэ маань ингээд зогсох шатандаа орчихсон. Хэрвээ энэ зогслоо гэвэл тэгээд цахим эрүүл мэнд гацах, төлбөр санхүүжилт үйлчилгээ авч чадахгүй зогсох нөгөө бидний явуулсан эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгийн дүн мэдээ авч чадахгүй байх гээд маш хүндрэлтэй юм руу орох юм байна лээ. Тэгэхдээ бид арга ядахдаа Цахим хөгжлийн яамтай яриад манай Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын программыг ашиглаад анхан шатын эрүүл мэндийн байгууллагууд үйл ажиллагааг хэвийн явуулах ийм нөхцөл бүрдүүлье гээд ажиллаж байгаа. Цахимын асуудал нэлээн хүндрэлтэй

байна. Цаашидаа би гишүүдийнхээ саналыг сонсож байгаа. Ер нь Засгийн газарт асуудал оруулъя гэсэн ийм бодолтой байна. Ер нь манай эрүүл мэндийн байгууллагад 4000 гаруй нэгж үйл ажиллагаа явуулж байна. Тийм учраас бид бие даасан эрүүл мэндийн мэдээлэл, технологийн төв байгуулах асуудлыг яаралтай шийдэхээс өөр арга алга. Төр, хувь хэвилийн нийлсэн 4000 гаруй эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа. Эдгээр байгууллагуудын цахимын үйл ажиллагаа аюулгүй байдлыг зохицуулах эрүүл мэндийн мэдээллийн төв байгуулах зайлшгүй шаардлагатай байна гэсэн ийм төсөвт үйлдвэрийн газар байгуулах зайлшгүй шаардлага байна.

Боловсролын яам яг манайх шиг ийм бүтэц байгуулаад ажиллуулж байгаа юм байна лээ. Маш сайн ажиллаж байгаа юм байна лээ. Би Цахимын хөгжлийн сайдтай ярьсан. Танайх яам байгуулагдсан. Бие даасан үйлчилгээний төв байгуулчихсан гээд манай энийг эсэргүүцэж болохгүй шүү гэсэн. Би эсэргүүцэхгүй танайхыг дэмжээд танайх бие даасан төвтэй болоод явахаас өөр үггүй. Манайх наадхыг чинь оролцоод, хариуцаад явна гэдэг тийм боломж байхгүй. Харин төсөвт үйлдвэрийн газар гэсэн статустай Засаг руу оруулж ирвэл би дэмжинэ гэдгээ Учрал сайд ярьж байгаа. Тэгээд ийм бүтэцтэй болох асуудлыг яаралтай оруулъя гэсэн ийм бодолтой байгаа. Гишүүд дэмжиж өгвөл их сайн байна.

Ингээд төгсгөлд нь товчхон эрүүл мэндийн эрх зүйн орчныг боловсронгуй болгохтой холбоотой хэд хэдэн асуудал дээр анхаарч байгаа. Ялангуяа бид Нийгмийн эрүүл мэндийн анхдагч хуулийг боловсруулж оруулах хэрэгтэй байна. Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлыг яаралтай оруулахаар ажиллаж байна. Энэ электрон тамхи гээд залуучуудын дунд, хүүхдүүдийн дунд асар их хэрэглээтэй



болчихсон байна. Тийм учраас ядаж утаат тамхитай адилхан худалдан борлуулдаг нөхцөлтэй болгох, ядаж утаат тамхитай нь адилхан онцгой татвартай болох ийм тухай асуудлыг оруулж шийдэх зайлиггүй шаардлага байна. Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах зайлиггүй шаардлагатай байна. Манайх 2017 онд Эрүүл мэндийн сайдын тушаал гараад дотооддоо оношилж, эмчилж чадахгүй байна гээд 26 нэр төрлийн өвчний жагсаалт гаргачихсан юм байдаг юм байна. Тэгсэн атлаа энэ 26 нэр төрлийн өвчнөөр шаналж, өвдөж байгаа иргэддээ үзүүлдэг тодорхойлолтын бодитой туслалцаа, дэмжлэг алга. Тийм учраас дотооддоо оношилж, эмчилж чадахгүй байгаа 26 төрлийн өвчнийг дотооддоо шинэ технологи нутагшуулбал тэр зардлыг нь Эрүүл мэндийг дэмжих сангаас олгодог байх ийм чиглэлээр хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай. Гэхдээ би зөвхөн Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөд найдахгүй байгаа. Шинжлэх ухаан технологийн сангаас дотооддоо оношилж, эмчилж чадахгүй байна. Өвчнийг анагаах оношилдог шинэ технологи нэвтрүүлэхэд төсөл бичиж Шинжлэх ухаан технологийн сангаас санхүүгийн дэмжлэг авах ийм боломж байна гээд харьяа эмнэлгийн даргад үүрэг өгөөд энэ жил бид нар ШУТС-д 10 өвчнийг дотооддоо оношилж эмчилдэг байх технологи нэвтрүүлэх төсөл бичээд Шинжлэх ухаан, боловсролын сайдад хүргүүлсэн. Энийг дэмжиж өгөөрэй гээд нэлээн хөөцөлдөж байна.

Дархлаажуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулна. Тодорхой 3 төрлийн вакциныг товлолд вакцинд оруулах гэсэн ийм чиглэлээр хуулиудад өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулиудад өөрчлөлт оруулахаар ажиллаж байгаа. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг

чадвал хаврын чуулганаар оруулах бодолтой байна. Одоо бол бид малын эм, хүний эмийг нэг хуулиар зохицуулж байгааг өөрчлөөд зөвхөн хүнийхээ эмийн харилцааг зохицуулсан, бие даасан хуультай болгоё гээд хөдөө аж ахуйн сайдад яриад манайх бие даасан хуультай болгохоор хуулийн төсөл бичиж байгаа юм. Ингээд хаврын чуулганд оруулна. Хамгийн гол нь бид эмийн чанар, үнийг нэлээн зохицуулах тийм зохицуулалт хийх хэрэгтэй. Ер нь нэгдсэн ерөнхий нэгдсэн худалдан авалтын тогтолцоо руу шилжихээс өөр арга алга гэсэн ийм бодолтой байна. Ийм бусад орнууд ч гэсэн нэгдсэн худалдан авалт хийдэг ийм тогтолцоо байна. Тийм учраас нэгдсэн худалдан авалтын тогтолцоо руу шилжье. Манай эмийн тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүд нөгөө эмийнхээ үйлдвэрүүдтэй дан дангаараа очиж гэрээ хийдэг учраас хэмжээ, зах зээл нь бага, хэмжээ нь бага гээд ингээд үнэ нь буурдаггүй өөрчлөлт ордоггүй ийм асуудлууд байх шиг байна. Тийм учраас энэ хуулийн гол өөрчлөлт нь бид нар тодорхой хэмжээгээр ерөнхий худалдан авалтын гэрээ хийдэг байх, худалдан авалт хийдэг байх ийм тогтолцоо руу оръё. Шаардлагатай бол төрийн худалдан авалтын бүтэц бий болох ч бас асуудал байж магадгүй гэж бодож байгаа. Ядаж л онцгой нөхцөл байдал үүссэн үед улсын нөөцийн эм тарианы нөөц ч байхгүй асуудал.

Төгсгөлд нь би нэг зүйл хэлэхэд эм бол үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудал стратегийн бүтээгдэхүүн. Тэгсэн атлаа бид нар эмийн чанар муу байна, эмийн үнэ өндөр байна гэж шүүмжлээд байдаг атлаа яг энэ эмийн ханган нийлүүлэлт хийж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудад төрөөс үзүүлдэг бодитой туслалцаа дэмжлэг алга. Бид улаан буудайны туслалцаа дэмжлэг үзүүлдэг, хөнгөлөлттэй хүүтэй зээл өгдөг, гааль татвараас чөлөөлдөг, түлш шатахуун дээр хөнгөлөлт үзүүлдэг, хүү багатай зээл олгодог энэ эмийн ханган нийлүүлэлт

хийж байгаа аж ахуйн нэгжүүдэд төрөөс үзүүлдэг ямар нэгэн тусалцаа дэмжлэг алга. Тийм учраас цаашидаа стратегийн бүтээгдэхүүн болж байгаа эмийн ханган нийлүүлэлтээр ч гэсэн төрийн тодорхой хэмжээний дэмжлэг бий болгох чиглэлээр нэлээн яам, Байнгын хороо хамтарч ажиллах ийм зайлиггүй шаардлагатай байна гэсэн ийм бодолтой байгаа гэдгээ хэлье. Ингээд би мэдээллийн үгээр өндөрлөе. Тав дахь өдөр нэлээн ярьчихсан.

**П.Анужин:** Эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотойгоор эрүүл мэндийн сайд Чинзориг маш дэлгэрэнгүй мэдээллийг хийлээ. Бид нар эрүүл мэндийн салбарыг гүйцэтгэлийн гүйцэтгэлээрээ санхүүждэг тогтолцоонд шилжсэнээс хойш анхан шат болоод шат бүрийн эмнэлгүүдэд тодорхой асуудал гарсаар байгаа. Гишүүд ч гэсэн орон нутаг болоод өөрсдийнхөө сонгогдсон тойрогт энэ асуудлыг шийдэхгүй болохгүй талаар удаа дараа Нийгмийн бодлогын байнгын хороонд асуудал тавьж, бид цаг тухайд нь Нийгмийн бодлогын байнгын хороон дээр хэлэлцэж байсан. Мөн эрүүл мэндийн гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотойгоор бид нар ажлын хэсэг Нийгмийн бодлогын байнгын хорооны дэргэд байгуулж Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн ахлан ажиллаж байгаа. Цаашидаа мөн энэ санхүүжилтийг сая эрүүл мэндийн сайдын дэвшүүлсэн гарц гаргалгааны тал дээр ажлын хэсгийн ахлагч Оюунчимэг гишүүн тэгээд Ажлын хэсэг Эрүүл мэндийн яамтай хамтраад эрчимтэй ажиллаж яг саяын дэвшүүлсэн гарц гаргалгаануудын хэрэгжилтийн талаар Байнгын хороон дээр мэдээлэл тавихыг хүсэж байна. Эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотойгоор тавьсан мэдээлэлтэй холбоотой асуулт, санал тусдаа явна. Асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Нэрс авахын өмнө өнөөдөр ажлын хэсгийн гишүүд хүрэлцэн ирсэн байгаа.

Та бүхэндээ танилцуулъя. Төгсдөлгөр Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Эрдэмбилэг Эрүүл мэндийн сайдын зөвлөх, Оюунчимэг Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж үйлчилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Оюунсүрэн Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Судалгаа, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Хонгорзул Эрүүл мэндийн яамны Санхүү эдийн засгийн газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Зэндмаа Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын дарга, Цэцэнсанаа Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эм хангамжийн газрын дарга, Оюунцэцэг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Худалдан авалт, гэрээлэлтийн газрын дарга, Янжиндолгор Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Тусламж үйлчилгээний багц зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ирсэн байна. Сайдын мэдээлэлтэй холбоотойгоор асуулт асуух гишүүдийн нэрсийг авсан байна. Идэрбат гишүүн асуулт асууна. Гишүүд зарчмын санал гаргаж байна. Сайдын мэдээлэлтэй холбоотой асуулт хариултыг хамт явуулъя гэсэн зарчмын санал гаргасан. Асуулт, саналыг хамт явуулъя. Асуулт асуух гишүүдийн нэрсийн дараалалд Туваан гишүүн кноп дарсан боловч нэр ороогүй байна гэж байна. Мөн Саранчимэг гишүүний нэр ороогүй байна. Өөр Сарангэрэл гишүүний нэр ороогүй байна. Гишүүдийн нэр бүрэн орсон байна. Идэрбат гишүүн асуулт асууя.

**Ц.Идэрбат:** Эрүүл мэндийн сайдын танилцуулгыг сонслоо. Эрүүл мэндийн салбар дээр ялангуяа 2 жилийн өмнөөс хэрэгжиж эхэлсэн гүйцэтгэлийн санхүүжилт дээр хүндрэлтэй асуудлууд байгаа. Ялангуяа сумын эрүүл мэндийн төвүүд дээр маш олон ойлгомжгүй ийм байдлууд үүссэн. Энд бол болж байгаа гээд л бид бүхэнд танилцуулагдаад л ярьж байсан. Яг ингээд тойрогтоо очоод

уулзахаар эрүүл мэндийн төвийнхний хувьд ялангуяа сумдынхан бол энэ дээр нэлээн шүүмжлэлтэй, хүндрэлүүдийн асуудлууд яригдаж байсан юм. Тэгээд өнгөрсөн чуулганы завсарлагаагаар орон нутагт очиж Хэнтий аймгийн Эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн салбарынхантай уулзаж бүх л зовлон, жаргалыг нь сонсож уулзсан. Сайд өнөөдөр Байнгын хороонд эрүүл мэндийн салбар дээр тулгамдаж байгаа асуудлууд юу байна. Мөн гарц гаргалгаатай нь танилцуулж байгаа нь зүйтэй байна. Гүйцэтгэлийн санхүүжилт дээр өнөөдөр би сайдаас нэг лавлах гээд байгаа зүйл бас энэ бүүр 100 хувь буруу явчихсан ч юм биш юм байгаа юм. Зарим томоохон эмнэлгүүддээ сайн байгаад байдаг, анхан шатдаа болохгүй байгаад байдаг. Тэгэхээр гүйцэтгэлийн санхүүжилтийн асуудлыг эргэж харахдаа аймгийн эрүүл мэндийн нэгдсэн эмнэлгээс дээшээ арай өөр зохицуулалттай, доод сумууд руугаа арай өөр зохицуулалттай ийм зүйл рүү орох зүйлийг та сая танилцуулав уу гэдгийг нэгдүгээрт асуумаар байна.

Хоёрдугаарт ажилчдын цалин хөлсний асуудлыг бид шийдэхгүй бол сувилагчгүй боллоо. Үнэхээр мэргэжилдээ хайртай тулдаа л ажиллаж байна. 2 жилийн дараа тэтгэвэртээ гарна. Манай тасагт 3 хүн зэрэг гарна. Ард нь хоёрхон хүн үлдэнэ гээд л ингээд л ярьж байх жишээтэй. Тэгэхээр энэ боловсон хүчний бодлого, цалин хөлсний асуудлыг яаж уялдуулахаар байгаа вэ гэдгийг асууя.

Дараагийн нэг асуудал бол эмийн асуудал. Эмийн асуудал дээр Чинзориг сайдаас харин их зөв зүйтэй санал гарч ирж байна гэж би харж байна. Иргэд бол эмийн чанар, үнэ дээр мэдээж хүн болгон, гишүүн болгон л мэдэж байгаа. Асуудлууд их байгаа. Гэхдээ өнөөдрийг хүртэл эмийн салбарыг авч явсан энэ салбарынхантайгаа хамтраад асуудлаа шийдээд явъя гэсэн ийм томъёоллыг оруулж ирж байгаа юм байна. Энэ нь нөгөө төр хувийн хэвшлийн хамтын

ажиллагаа энэ тал дээрээ нийцтэй байх гэж харж байна.

Нэг тодорхой асуулт байгаа юм. Энэ бол Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүн болж орж ирсэн цагаас хойш Жаргалмаа гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг гарч, өнгөрсөн жил очиж танилцсан. Геронтологийн төв буюу ахмадын эмнэлгийн асуудал. Үнэхээр 100 айлд байгаа ахмадын эмнэлэг дээр геронтологийн үндэсний төв дээр очиж танилцана гээд очсон. Үнэндээ өнөөдөр тийм өрхийн эмнэлэг ч байхгүй юм байна лээ. Яг үнэндээ бол маш хүнд нөхцөлд ажиллаж байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ олон тэрбум төгрөгийн эмнэлгийн хөрөнгийн асуудлууд ямархуу шатандаа яваа юм. Хэзээ шийдэгдэх юм. Хэзээ Монголын ахмадууд геронтологийн төвтэй болох ийм хандлагатай байгаа юм бэ гэсэн ийм зүйлийг би асууж тодруулъя гэж ингэж бодож байна.

**П.Анужсин:** Эрүүл мэндийн сайд Чинзориг хариулъя.

**С.Чинзориг:** Би зарим асуултад хариулъя. Мэргэжлийн байнгын хороо дээр ярьж байгаа учраас яг тэр нарийн тодорхой юмнуудыг манай мэргэжлийн хүмүүс хариулах нь зүйтэй болов уу гэж бодож байна. Цалинтай холбоотой асуудал дээр тодорхой шийдэл гаргана. Ялангуяа миний саяын яриад байгаа энэ тохируулга, зарим өртгийг дахин тооцоолох тарифыг нь нэмэгдүүлэх замаар ялангуяа тэр хүн ам цөөтэй сумуудад газар зүйн коэффициент гаргаж санхүүжилтийг нь, эх үүсвэрийг нь нэмэгдүүлж өгье гэж байгаа юм. Энэ хүрээндээ сумын эрүүл мэндийн байгууллагуудын цалин хөлсийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.

Хоёрдугаарт Засгийн газрын өнгөрсөн онд би түрүүн яриад байсан тэр 107 дугаар тогтоолоор төсвийн ерөнхийлөн захирагчид ийм төсвийнхөө багцтай нь багтааж цалингийн доод хэмжээнд нэмэгдүүлэх асуудлыг шийдэх

эрхийг нь өгчихсөн юм байна лээ. Энэ хүрээндээ шийдэх эрх нь төсвийн ерөнхийлөн захирагч сайдад байна гэж бодож байгаа.

Хоёрдугаарт би түрүүн хэлснээр тэр нь төсвийн тухай хуульд бас нэг яаралтай өөрчлөлт оруулмаар байгаа юм. Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн нөгөө дансны үлдэгдлийг нь төвлөрүүлэн татдаг энэ хуулийн заалт нь хэвээрээ. Лавлагаа шатны эмнэлгүүд дээр бол энэ хуулийн заалтыг нь өөрчилчихсөн юм байна лээ. Сум, тосгоны эрүүл мэндийн байгууллагууд дээр энэ нь үлдчихсэн байгаа учраас Төсвийн тухай хуульд яаралтай өөрчлөлт оруулж, үлдэгдэлтэй гарсан сумууд өөрийн энэ үлдэгдэл мөнгөө зарцуулах тэр эрхийг нь яаралтай олгох арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай байгаа.

2 дахь асуудал нь би түрүүн хэлсэн. Эрүүл мэнд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтраад ажлын хэсэг гаргаад ажиллаж байгаа. Эрүүл мэндийн салбарт цалин, хөлс нийгмийн баталгаатай холбоотой асуудлыг судалж, санал боловсруулах гээд энэ хүрээндээ бид нар тэр ур чадварын нэмэгдэл олгох журмыг нь батлаад яаралтай тэр шалгуур үзүүлэлтийг нь тодорхой болгоод, тэгээд ядаж ур чадварын нэмэгдэл авдаг байх орчин боломжийг нь яаралтай бүрдүүлж өгье гэсэн ийм чиглэлийн асуудлууд байна. Лавлагаа шаттай холбоотой асуудал дээр бол ялгавартай хандах юмнууд бий. Суман дээр бол тодорхой хэмжээгээр бид нар тэр газар зүйн коэффициентоор төсвийг нь жоохон нэмэгдүүлж өгье. Ялангуяа төрөлжсөн эмнэлгүүдээс жаахан зарим нэг хэвтэн эмчлүүлэлтийг нь бууруулах зарим бас өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ, тусламж үйлчилгээний зардлыг жаахан эргэж харах замаар жаахан өөрчлөлт хийе гэдэг. Тэгэхээр энэ бол ялгавартай янз янз өөр шат шатынхаа онцлогийг нь тусгасан ийм арга хэмжээ авъя гэсэн ийм бодолтой байгаа. Тэр геронтологитой холбоотой асуудлыг

манайхан хэлээрэй. Урьд нэг байр бол шийдэж өгсөн юм байна лээ. Тэгээд тэр дарга нь надтай нэг уулзсан. Тэгээд тэр байрыгаа багтаамж багатай, жижиг гээд яриад л байгаа юм байна лээ. Гэхдээ өмнө нь бас энэ чинь хөөрхөн засвар гарчихсан. Санхүүжилт нэлээн гарчихсан юм байна лээ. Тэгээд үр дүнгүй нөгөө олон жил явчихсан ийм асуудлууд байгаа. Тэгээд манай Хонгорзул дарга, Эрдэнэбилиг дарга нэмээд хариулчхаарай.

**П.Анужин:** Нэмэлт хариулт өгье. Эрүүл мэндийн сайдын зөвлөх Эрдэмбилэг дарга хариулт өгнө.

**Ц.Эрдэмбилэг:** Нийгмийн бодлын байнгын хорооны гишүүдэд та бүгдэд өдрийн мэндийг хүргэе. Идэрбат гишүүний 3 дахь асуултад хариулъя. Геронтологи төвийн барилгын хувьд та бүхэн асуудлыг маш сайн мэдэж байгаа. Өмнөх барилгыг гүйцэтгэгч компани бол их олон жилийн туршид энэ барилга гацсан байдалтай байгаа. Бид бүхэн өмнөх Засгийн газраар хэлэлцээд 2022 ондоо Геронтологийн үндэсний төвийг яг тэр төлөвлөсөн байгаа тэр Геронтологийн барилгынх нь хажуухан талд нь Хан-Уул дүүргийн 10 дугаар хороонд сэргээн засах зориулалттай, 36 ортой, 5 давхар эмнэлгийн барилга баригдаж байгаа. Тэр байр руугаа шилжүүлбэ гэсэн ийм шийдвэр гарган ажилласан. Энэ 36 ортой эмнэлгийн барилга нь энэ 2023 оны 6 сард бүрэн ашиглалтад оруулахаар тухайн гүйцэтгэгч байгууллагууд нь барилгынхаа материалаа татчихсан, ингээд барилгын ажил дулаараад үргэлжлээд явж байгаа. Ер нт бол одоо яг байгаа Геронтологийн Үндэсний төв маань эмнэлгийн нэг жигүүрт, 1 давхарт, 8 кабинетад ажиллаж байгаа. Энийг бол ортой болгоод 36 ортой 5 давхар ийм эмнэлэг болгож бид нар 6 сардаа багтаагаад ашиглалтад оруулахаар шахаж ажиллаж байна.

**П.Анужин:** Идэрбат гишүүн тодруулж асууя.

**Ц.Идэрбат:** Би тэр сүүлийн таны тайлбарыг сонссон. Тэр тийм хувилбар явж байгаа. Миний асуугаад байгаа юм бол тэр 10 жил болж байгаа геронтологийн эмнэлгийн барилга яах юм бэ. “Ариус” компанийн барьж байсан. Би энд ажлын хэсэгт орж ажиллаж байсан учраас, нэлээн юмыг нь тодорхой мэдсэн учраас цаашидаа ямар гаргалгаа байгаа юм бэ гэдэг нэг ийм зүйл байгаа юм.

Хоёрдугаарт би сая нэг зүйлийг эрүүл мэндийн цахим шилжилтийн асуудал дээр нь e-hospital, e-help гэдэг энэ 2 программ уг нь их аятайхан явчихвал олон эрүүл мэндийн байгууллагын мөн үйлчлүүлэгчдийн цаг зав, цаас хамаг юмыг хэмнэсэн ийм л юм болно. Гэтэл энэ маань жосоохон тааруухан байгаа юм. Тэгэхээр энэ дээр цаашидаа ямар гаргалгаа байх вэ. Ямар дэмжлэг байх ёстой юм. Би мэргэжлийн Байнгын хороо энэ дээр дэмжиж, энэ цахим эрүүл мэндийн шилжилтийг төгс болгож дуусгахын төлөө Байнгын хороо ч гэсэн анхаарах байх л гэж бодож байна.

**П.Анужин:** Нэмэлт асуултад Эрдэмбилэг дарга хариулах уу. 3 номерын микрофонд Эрдэмбилэг дарга хариулна.

**Ц.Эрдэмбилэг:** Идэрбат гишүүний асуултад хариулъя. Тэгэхлээр хуучин барилга “Ариус интернэйшнл” компанийн барьж байгаа хуучин барилгын асуудал дээр бид бүхэн Барилгын хөгжлийн төв болон Үндэсний аудитын газрын шинжээч нараар шалгуулсан. Энэ дээр бол тухайн барилга дээр нь очоод бүтцийг нь үзээд, чанарыг нь үзээд энэ 2 байгууллагаас хоёулынхаас нь шаардлага хангахгүй байна гэсэн ийм дүгнэлт гарсан.д Дээрээс нь тухайн үед энэ барилгыг барьж байхдаа олгосон санхүүжилт нь барилгынхаа гүйцэтгэлтэйгээ уялдахгүй, гүйцэтгэлээсээ илүү давуулаад ийм санхүүжилт олгосон байгаа ийм зүйл аудитын шалгалтаар гарсан. Ийм учраас барилгын асуудлыг АТГ луу хууль хяналтын байгууллагаар шалгуулах нь зүйтэй гэсэн ийм дүгнэлт гаргаад тэнд

хандчихсан байгаа. Яг одоогоор шалгалт нь ямар шатад байгаа талаар манайд албан ёсны мэдээлэл ирээгүй байгаа.

**П.Анужин:** Эрүүл мэндийн сайд Чинзориг нэмж хариулна.

**С.Чинзориг:** Одоо энэ цахим эрүүл мэнд төслийг цаашидаа үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зайлиггүй шаардлага байгаа юм. Гэхдээ одоогийн Дэлхийн эрүүл мэндийн байгууллага нэгэнт өөрөө шинжээчийн дүгнэлт гараад 29 хувийн хэрэгжилттэй байна. Зогсоож байна. Санхүүжилт олгохоо болилоо гээд одоогийн байгаа төслийг явуулах ямар ч боломжгүй. Шинээр төсөл боловсруулаад, шинэ эх үүсвэр хайж олох л асуудал хэрэгтэй болох байх. Одоо бидэнд яг юу тулгамдаж байна гэхээр эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудад ашиглаж байгаа программыг төгс боловсронгуй сайжруулах шаардлагатай байна.

Хоёрдугаарт цахим эрүүл мэнд төсөл хэрэгжилтийн хүрээнд манайд нэлээн нэвтрүүлэх тоног төхөөрөмж, серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх гээд асар их хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага байгаа юм. Одоо бид нар тэр 13А маягтыг цахим болго л гээд.../минут дуусав/

**П.Анужин:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна.

**М.Оюунчимэг:** Манай Чинзориг сайд маань 2016 оноос хойш яг Нийгмийн бодлогын байнгын хорооныхоо гишүүний хувьд маш хариуцлагатай, энэ салбарт оролцож явж байсан хүний хувьд өнөөдөр эрүүл мэндийн салбарт үүссэн нөхцөл байдал дээр маш бодит оношилгоо хийж орж ирсэн байна. Үнэхээр энэ нь бид нар яриад л байдаг, яриад л байдаг, хэрэгжихгүй байгаад байгаа. Гэтэл 2017 оноос эхлээд эрүүл мэндийн салбар дахь Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг бид 1.4 их наяд хүртэл өөрөөр хэлбэл

дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ 3-аас хэтэрдэггүй байсныг өнөөдөр бид 7 болгоод илүү цаашаа энийг явуулья гэдэг. Гэтэл нэмэгдээд байгаа хэр нь харин нөгөө яг тусламж үйлчилгээ маань уруугаа харчихсан, эм маань эмийн мафитай жсоохон ингээд баригдчихсан. Тэгээд яг энэний бодлогын эмийн агентлаг байгуулаад өгөнгүүт тэр нь зогсчихсон. Тэгээд цахим болгоё гэхээр энэ нь унтчихсан гээд үнэнийг хэлэхэд асуудал энэ салбарт маш их байна. Яг ийм учраас нөгөө төсөв хэлэлцэх болгонд эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт нь гацаад ороод ирдэг. Яг бодит зүйлүүд л хэлж байна л даа. Тусламж үйлчилгээ уруугаа харчихсан. Хувийн эмнэлэг, төрийн эмнэлэг 2 гэхэд санхүүжилт нь хувийн эмнэлэгт 3 дахин нэмэгдсэн хэр нь харин ачаалал үүрэх нь 7 хувьтай. Тийм учраас л эмнэлгүүдийн дэргэд баахан хувийн эмнэлгүүд бий болоод сая Өргөө төрөх дээр юу болов. Тэгээд бид нар 2 дугаар эмнэлэг дээр яг ажлын хэсэг гараад ахлаад очиход, эмнэлгүүд яг дамжин өнгөрөх бааз болоод эмч нар хөөрхий ёстой нэг хөдөлмөрөө үнэлүүлж чадахгүй ажиллаж байгаа ийм хүмүүс байна гэж яриад байгаа байхгүй юу. Тийм учраас би Чинзориг сайдыг одоо яг нэгэнт ийм оношилгоо гаргасан дээрээ яаралтай энэ арга хэмжээнүүдийг авах хэрэгтэй байна. Зөв тохиргоонууд хийж явахгүй бид ингээд л оношлоод гаргаад ирдэг. Тэгээд энэ нь цаашаа явахгүй. Яг хуулиуд маань орж ирдэггүй. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль гацчихсан. Бид хэд бараг 3 жил нэхэж байна. Яагаад ингэчихдэг юм. Та бүхнээс минь шалтгаалахгүйгээр цаана нь байгаад байна шүү дээ. Энхболд сайд жишээлбэл цахим дээр би мафийнхандаа бууж өгч байна. Би дийлэхгүй байна гээд өөрөө бүр тэр жишээ нь цахим дээр хэчнээн тендер орж ирэв би дийлэхгүй байна гэж хэлж байсан. Тэгэхэд Чинзориг сайд та энэнтэйгээ тэмцэхгүй бол өнөөдөр та оношилгоо ороод ирээд тэгээд цаашид энийг бас эмчлэхэд хэцүү. Би Нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар

ажиллаж байхдаа яг энэ эм дээр үнэхээр ач холбогдол өгөөд, эмийн үнэ, чанар 2 бол Монголд үнэхээр биш байна. Энд 500 орчим, 500 гаруй тэрбум төгрөг эргэлдээд байгаа хэр нь 8-10 аж ахуйн нэгжийн дунд байдаг. Хоорондоо худалддаг, тэгээд дэлхийн зах зээлээс ёстой 100-114 гэдэг нь үнэн. Илүү үнэтэй. Тэгэхдээ чанар үйлчилгээ муу байна гэдгийг гүйцэтгэлийн аудитаар энийг баталгаатай ингээд гаргаад ирчихсэн. Одоо бид нар энэ дээр зүгээр ажиллах хэрэгтэй байгаад байгаа байхгүй юу. Тэрнээс манай Эрүүл мэндийн яамныхан, манай эрүүл мэндийн салбарынхан эмч, ажилтнууд бол хөөрхий ёстой бор зүрхээрээ ажиллаад байдаг. Гэтэл бидний олгоод байгаа санхүүжилт, бидний энд эргэлдэж байгаа мөнгө маань харин өөр урсгал руу орчхоод байгаа учраас энэ асуудлууд шийдэгдэхгүй байна л даа. Жишээлбэл бид нар нэг зүйл хэлье. Хавдар гэхээд Эрүүл мэндийн даатгалын сангаас хавдрын өвчлөлд олгогдож байгаа тэр эм, тарианы тариф маш өндөр байгаа шүү дээ. Гэсэн хэр нь яагаад хавдрын өвчлөл буурахгүй байгаад байна. Яагаад тэнд ачаалал нь асар их байгаад байна. Яагаад нас баралт улам нэмэгдээд байна. Тэгэхээр л энд бас нэг өөр юм байгаад байгаа биз. Тэгэхээр бид нар энэ санхүүжилтийг олон өөр эмнэлгүүдэд өгөх үү. Жишээ нь 1 дүгээр эмнэлэг, 2 дугаар эмнэлэг, 3 яг жишээ нь зүрхнийхээ хавдраар гэдэг юм уу, манайд тэр тарифыг нь өгөөд бид нар эмчлээд явчихвал ачааллыг бууруулах бололцоо байна гээд бид нарыг очиход ярьж байсан. Үнэхээр тийм байна уу, үгүй байна уу. Энэ дээр Чинзориг сайд хараад зөв тохируулга хийхгүйгээр эрүүл мэндийн салбартаа бид мөнгө ингээд л өгөөд байдаг. Эсвэл танагдаад байдаг. Цаашаа явахгүй байгаад байна. Тэгээд энэ дээр бид нар маш анхааралтай ажиллахгүй болох байхгүй байна. 2-т нь Чинзориг сайд аа, энэ дээр бичсэн байна л даа. Нөгөө жишээ нь эмийн үнийг инфляцтай уялдуулж доод босгыг нь нэмэгдүүлэх гэхчхэн байх юм. Энийг

жишээ нь юу гэж ойлгох вэ. Дахиад эмийн үнэ өсгөх гэж байгаа гэж ойлгох уу. Инфляцтай уялдана гэхийгээр долларын ханштай уялдуулна гэж ойлгох уу. Нэгдүгээрт энд хариулт.../минут дуусав/

**П.Анужин:** Эрдэмбилэг дарга 3 номерын микрофонд хариулъя.

**Ц.Эрдэмбилэг:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр бид нар одоо яг эмийн үнийг судлаад үзэх юм бол даатгалын сангаас олгож байгаа санхүүжилтээр 2022 оны 7 сард бас эмийн үнийн тохируулга хийхэд тэр 7 сард оруулсан өөрчлөлтөөр 3.6 хувийн инфляц эм дээр байна. Харин 2020 онд тогтоосон эмийн үнэ дээр бол 26 орчим хувийн тохируулга хийх шаардлагатай байгаа. Өөрөөр хэлбэл зарим эм дээр үнийг нь нэмж даатгалаас олгох санхүүжилтээр үнийг нь нэмэхгүй бол 2020 оныхоо тарифаараа явж байгаа гэсэн санаа байгаа. Тэгэхээр энэ 2022 онд байгаа тэр тарифынхаа эмүүдийнхээ үнийг нэмж санхүүжилтээ даатгалаас олгох санхүүжилт дээрээ тусгахгүй бол нөгөө даатгалаас олгож байгаа санхүүжилт нь бага, тэгээд нөгөө чанартай эм маань орж ирэхгүй байгаа юм. Тэгээд энийг хэлсэн санаа байгаа юм.

**П.Анужин:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодотгож асууя.

**М.Оюунчимэг:** Тэгэхээр Чинзориг сайд та тохируулгыг одоо яг энэ оношлоод ороод ирчихсэн байна. Тэгээд гаргалгаатай нь ирсэн байна. Энийг хийх бололцоо танай яг яам дээр систем дээр чинь харагдаж байна уу. Яагаад гэвэл бид нар энийг 2017 оноос хойш яриад, гаргаж тавиад, тэгсэн хэр нь хэрэгжилт үнэхээр гацаад одоо энэ хууль нь хүртэл гацчихаад байгаа байхгүй юу. Тэгэхээр яах вэ гэдэг дээр та 1-д хариулт өгөөч. 2-т нь манай Учрал гишүүнээр ахлуулаад нөгөө эмийн түр хорооны ажлын хэсэг Эм шинжлэх лаборатори дээр очсон. Би үнэхээр өрөвдсөн. Тэнд хүмүүс чин

сэтгэлээсээ ажиллаж байна лээ. Гэтэл Монголын цорын ганц энэ лабораторид нь тавхан тэрбумын төгрөгийн тэр шинэчлэлийн техник технологийг нь хийж чадахгүйгээс тэр эм үнэхээр найрлага муу байна уу, хулхи байна уу, тэрийгээ гаргахад хэцүү байна гээд ярьж байгаа. Одоо ярьж байна шүү дээ. Хүний амаар ордог хоёрхон зүйл байдаг. Хүнс, эм 2. Тийм учраас бусад улсад Food and drug agency гээд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийнхөө дэргэд энэ нь байдаг. Манайд хүнсээ өнөөдөр Монгол Улсын Ерөнхийлөгч санаачилга гаргаад явж байна. Эм нь ингээд хаягдчихсан. Тэгэхээр энэ дээр та хариулт өгөөч. Энийг.../минут дуусав/

**П.Анужин:** Эрдэмбилэг дарга хариулъя. 3 номерын микрофон. Эрүүл мэндийн сайд Чинзориг хариулъя.

**С.Чинзориг:** Өөрчлөлт хийх гээд л ажиллаж байгаа юм л даа. Тэгээд ямар ч байсан Байнгын хорооныхоо гишүүдэд мэдээлэл өгье, саналыг нь сонсьё гээд. Тэгээд бид нар энэ арга хэмжээ тохируулгуудыг 5 сарын 1-ээс мөрдүүлэхээр бид төлөвлөж байгаа. Яагаад вэ гэхээр Байнгын хорооны хуралд танилцуулаад, Байнгын хорооны гишүүдийн саналыг сонсьё.

Хоёрдугаарт энэ чинь нөгөө журмаараа нийтээр дагаж мөрдөх хэмжээ тогтоосон акт гаргахаар зайлиггүй л нөгөө сарын өмнө мэдээллийн санд байришиж, олон нийтэд байршуулж санал авсан байх ёстой гэж үзэж байгаа. Тийм учраас бид нар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын сайт дээр тохируулга хийх гэж байгаа саналуудаа байршуулчихсан байгаа. Ингээд 5 сарын 1-ээс энэ арга хэмжээнүүдийг аваад ийм тохируулга хийгээд явна гэсэн ийм бодолтой байгаа. Энэ хүрээнд зарим хуулиуд өөрчлөлт оруулах, сайдын тушаалд өөрчлөлт оруулах, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн хэд хэдэн.../минут дуусав/

**П.Анужин:** Чинзориг сайдад нэмэлт 1 минут өгье.

**С.Чинзориг:** Тэгээд урьдчилаад арга хэмжээ авахынхаа өмнөөс Байнгын хороондоо мэдээлэл өгөөд, гишүүд маань ядаж Байнгын хорооны гишүүд ядаж нэгдсэн нэг ойлголттой болбол бас асуудал хэрэгжээд явах нэлээн бодитой болох болов уу гэж бодож байна.

Хоёрдугаарт эмийн хуулийг бид нар яаралтай оруулж ирнэ. Тохируулга хийдэг өөрчлөлт хийх нэгдсэн худалдан авалтын тогтолцоо руу шилжих ийм чиглэлээр өөрчлөлт хийнэ.

Хоёрдугаарт тэр лабораторийн тоног төхөөрөмжтэй холбоотой асуудлыг шийдэхэд хэцүү байгаа. Засгийн газар дээр танилцуулсан. Энэ жилийн төсөв дээр гишүүд минь эрүүл мэндийн салбарт их засварын болоод тоног төхөөрөмжийн 1 ч төгрөг тавиагүй юм байна лээ. Яагаад Сангийн сайдыг ингээд гарыг нь мухарлачихсан юм бэ гэсэн чинь 2 жил ковид гээд хамаг мөнгөө эрүүл мэндийн салбарт өгсөн учраас энэ жил тавиагүй гээд их засварын 1 төгрөг ч байхгүй, тоног төхөөрөмжийн 1 төгрөг ч байхгүй. Байдал бол ийм байгаа. Тэгээд яах вэ, Бид нар Засгийн газар дээр танилцуулсан. Ерөнхий сайд бол авлига албан тушаалын хэргээс улсыг хохиролгүй болж байгаа хөрөнгийг эрүүл мэндийн.../минут дуусав/

**П.Анужин:** Балжиннямын Баярсайхан гишүүн асуулт асууна.

**Б.Баярсайхан:** Баярлалаа. Юуны өмнө Чинзориг сайдад эрүүл мэндийн салбарын төсвийн гүйцэтгэлийг танилцуулж байх явцдаа яг өөрийнх нь салбарын 2 гол зорилгын нэг болох нийгмийн эрүүл мэндийг дэмжих тал дээр бас гаргалгаа ямар ч байсан асуудал байх ёстой юм байна гэдгийг ойлгож оруулж ирж байгаад баяртай байна. Тэгээд Чинзориг сайд аа, танаас 3 зүйлийг асууя. Нийгмийн эрүүл мэндийг

дэмжих, иргэдэд таргалалт, хавдрын, халдварын бус өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилт Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тавигдаад явсан. Та одоо сайдаар очоод ажиллахад яг энд хэдэн төгрөгийн төсөв байгаа юм бэ. Таны өмнөх сайд бол энэ ажлаа бараг 100 хувь биелсэн гэж үзээд байгаа байхгүй юу. Энэ ажлаа биелсэн гэж үзэхдээ юутай холбоод байна гэхээр тэр эрт илрүүлэг гэдгээ нэгдүгээрт хэлээд байна. Хоёрдугаарт тэр оношилгооны төв 21 аймагт хийсэн. Энэ чинь ерөөсөө нийгмийн эрүүл мэндийг дэмжих ажил биш байхгүй юу. Энэ чинь хүмүүсээ мэдлэгжүүлэх, соён гэгээрүүлэх, амьдралынх нь хэв маягийг өөрчлөх л ийм асуудал байгаа шүү дээ. Таны тэр гадаад орны туршилага гээд сая ярьсан энэ асуудал. Тэгэхлээр энэ дээр та яг одоо бид нарт хэрэгжүүлэх төсөв үлдсэн юм уу, байгаа юм уу гэдэг энэ асуултад хариулт өгөөч.

Хоёрдугаарт та сая хувийн эмнэлгүүдэд өгөх санхүүжилт 3 дахин өссөн боловч төрийн ачаанаас эмнэлгийн салбарын ачаанаас үүрэлцэх хувь нь 7 хувь л байна гэж байна шүү дээ. Тэгэхээр эрт илрүүлэгд хувийн эмнэлгүүд маш их орж байгаа. Чанартай ч явагдаж байгаа байх, чанаргүй ч явагдаж байгаа байх. Тэгээд энэ асуудал дээр хувийн эмнэлгүүд чинь эрүүл мэндийн даатгалаас санхүүжээд орж ирж байгаа энэ эрт илрүүлэг гэдэг ажил чинь яг ямар хэмжээнд явж байгаа юм. Ер нь энэ эрүүл мэндийн даатгалаас мөнгө аваад дахиад оношилгоо хийх нь зөв юм уу, буруу юм уу. Би энийг буруу гэж хараад байгаа шүү дээ. Энэ асуултад хариулт авъя.

Гуравдугаарт хэчнээн бид нар эрүүл мэндийн салбараа дэмжээд, дэмжээд өнөөдөр эмнэлэгт эмчилгээ хийлгэж байгаа хүмүүс маань өөрсдөө гаднаас тариа, эмээ худалдаж аваад ингээд байна. Энэ асуудал ерөөсөө зогсохгүй байна. Яаж бид нар хэрвээ эмнэлэгт хэвтэх юм эм, тариагаа



өөрсдөө худалдан авахгүй байх вэ. Энэ асуудал яг хэзээ шийдэгдэх юм бэ. Өөрсдөө эмээ худалдаж авч байвал сувилгач дуудаад гэртээ бараг тэгээд л эмчилгээгээ хийлгэж баймаар байх юм. Тэгээд энэ 3 асуултад тодорхой хариулт авъя. Баярлалаа.

**П.Анужин:** Баярсайхан гишүүний асуусан асуулттай холбогдуулаад тэр эмнэлэгт ар гэрээс нь байнгын эм, тариа авчирч байгаа асуудал үнэхээрийн хаа сайгүй байгаа асуудал. Энэ дээр яг тодорхой хариулт хүсэж байна. Балжиннямын Баярсайхан гишүүний асуултад Чинзориг сайд хариулна.

**С.Чинзориг:** Бид нийгмийн эрүүл мэндийн асуудлыг нэлээн орхигдуулж явсан юм байна гэж бодож байгаа. Эрүүл мэндийн тухай хуулиар ч гэсэн эрүүл мэндийг дэмжих гэдэг маань 2 талтайгаар хуульчлагдсан байдаг. Нэг тал нь нийгмийн эрүүл мэнд нөгөө тал нь эмнэлгийн тусламж үйлчилгээ. Бид эмнэлгийн тусламж үйлчилгээгээ голлоод олон жил явсан. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ гэсэн нэг талыг нь орхигдуулж ирсэн юм байна гэж бодож байгаа. Тийм учраас Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай анхдагч хуультай болохыг зорьж байна. Хууль зүйн сайдтай хамтраад үзэл баримтлалыг нь батлуулчихсан, яамдаас санал авахаар хүргүүлж байгаа. Ингээд хаврын чуулганаар Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийг оруулж ирнэ. Тэгээд энэтэй холбоотойгоор таны амьдралын зөв хэв маягтай болохтой асуудал, буруу дадал зуриллаас салахтай холбоотой тэгээд л таргалалттай холбоотой гээд л бүх л асуудлууд нийгмийн эрүүл мэндийн асуудал, орчны эрүүл ахуйн асуудал ч гэсэн бас л нийгмийн эрүүл мэндийн асуудал руу л орох л асуудлууд шиг байгаа юм. Ийм чиглэлээр хуультай болгоно.

2 дахь асуудал нь бид ер нь иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дэмжих чиглэлээр нэлээн ажил

зохиомоор юм байна лээ. Ер нь бол эмнэлгийн эмч судлаачидтай уулзахлаар чинь иргэн хүний эрүүл мэндийн асуудлыг чинь 12-13 орчим хувь нь л эрүүл мэндийн байгууллагатай холбоотой. Үлдэж байгаа хувь нь иргэн, хувь хүнээсээ өөрөөс нь шалтгаалдаг гэж ярьдаг тийм судалгаа байдаг гэж ярьдаг юм байна лээ. Тийм учраас иргэний эрүүл мэндийн боловсролыг дэмжих чиглэлийн асуудлыг Боловсролын яам, Хөдөлмөр хамгааллын яам, Спортын яам, манай яам хамтарч хэрэгжүүлдэг. Батлан хамгаалах яам оролцоотой иргэний эрүүл мэндийн боловсролыг дэмжих, төлөвлөгөө стратеги яаралтай батлах хэрэгтэй гэж ажиллаж байгаа.

Хоёрдугаарт. Би Үндэсний радио телевизтэй хамтраад 7 хоног болгон иргэний эрүүл мэндийн боловсролыг дэмжих чиглэлээр 20-30 минутын цагтай болгох асуудлаар гэрээ байгуулаад, үндсэндээ энэ 7 хоногоос энэ ажил эхэлнэ. Ийм чиглэлээр бас Байнгын хороо, гишүүд ч гэсэн нэлээн идэвхтэй оролцож ажиллах болов уу гэж бодож байна. Ер нь бол нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудлыг тэр тусгай сангийн хуулиар зохицуулагдаж байгаа Эрүүл мэндийг дэмжих сангийн хүрээнд бид нар явуулж байгаа. Ер нь нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн асуудал, урьдчилан сэргийлэхтэй холбоотой асуудлууд. Яг хуулиараа бол бид энэ сандаа жилд 11-12 тэрбум төгрөг төвлөрүүлэх ёстой боловч 2-3 тэрбум төгрөг Сангийн яам хуваарилж өгдөг юм байна лээ. Би Сангийн сайдтай ярьж байгаа. Энэ мөнгийг 100 хувь эрүүл мэндийг дэмжих санд нь өг. Нэг хэсгийг нь би нийгэм, эрүүл мэндийн асуудалд зарцуулж, нэг хэсгийг нь тэр дотооддоо оношилж, эмчилж чадахгүй байгаа өвчнийг шинэ технологи нэвтрүүлэх чиглэлээр санхүүжилтийг нь олгодог больё гээд ийм чиглэлээр ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Эрт илрүүлэгтэй холбоотой асуудал дээр хүн амын маань 26 хувь нь буюу 846 мянган хүн хамрагдсан гэсэн ийм судалгаа байгаа. Хувийн хэвшлийн эмнэлгийн байгууллагууд нэлээн оролцсон. Тарифтай холбоотой асуудал хувийн хэвшлийн эмнэлгүүдэд нэлээн ярьж байгаа. Хэрвээ тариф чинь бага байна. Тарифыг нь нэмэгдүүлэхгүй бол хувийн хэвшлийн эмнэлгийн байгууллагууд эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт орох боломжгүй байна гэдэг асуудал ярьж байгаа. Саяын тэр гүйцэтгэлийн санхүүжилтэд өөрчлөлт оруулах хүрээнд бас эрт илрүүлэгтэй холбоотойгоор тарифыг шинэчлэх ийм асуудал яригдаж байгаа. Энийг шийднэ.

Тэр гаднаас эм тариатай холбоотой асуудал дээр манайхан хариулах уу. Хэн Эрдэмбилэг дарга хариулчих уу.

**П.Анужин:** 3 номерын микрофонд Эрдэмбилэг дарга хариулъя.

**Ц.Эрдэмбилэг:** Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Гүйцэтгэлийн гэж хэлээд байгаа яг одоо бол эдийн засгийн нэр томъёогоор бол чанар, үр дүнд суурилсан санхүүжилт буюу оношны хамааралтай бүлгийн санхүүжилт гэж нэрлээд байгаа юм. Үүгээр бол эмнэлгүүдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан иргэдийн санхүүжилтийг нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжиж байгаа. Ингэж санхүүжилт олгохдоо бид нар олон улсад 190-ээд оронд хүлээн зөвшөөрөгдөж нэвтэрсэн *Up To date* гэдэг платформыг ашиглаад, энэхүү платформд тухайн оношны хамааралтай бүлэг дээр ямар тусламж үйлчилгээ үзүүлэх вэ, ямар эмчилгээ хийх вэ гэдгийг нь удирдамжид заасан. Үүний дагуу тусламж, үйлчилгээ үзүүлсэн үү, үгүй юу үүнийх нь дагуу санхүүжилтийг нь олгоод явж байгаа. Эмнэлгүүд өөрсдөө даатгалаас ирж байгаа санхүүжилтээ аваад, өөрсдөө эмийнхээ тендерээ зарлаад, тэр зарласан

тендерийнхээ дагуу эмээ худалдаж аваад эмчилгээндээ ашиглаж байгаа. Тийм учраас өнөөдрийн байдлаар 2022 оны статистик үзүүлэлтээр үндсэндээ 26 байгууллага, ер нь ихэнх нь анхан шатны буюу сумын эмнэлгүүдэд хүн амын тоо цөөн, гүйцэтгэл бага гэдэг утгаар санхүүжилтийн асуудал үүсэж байгаа. Бүх лавлагаа шатлалын эмнэлгүүдэд нэг аймгийн БОЭТ-өөс тооцвол ихэнх нь дансандаа үлдэгдэлтэй ийм байгаа. Тэгэхлээр энэ эмнэлгүүд тэр эмээ заавал авч, тусламж үйлчилгээ үзүүлж иргэн даатгуулагчаас гэрээс нь эм авах ёсгүй юм байгаа юм. Үнэхээр тухайн худалдан авалт, тендерийнх нь асуудал нь удааширнаас болоод хэрэвзээ эмнэлгийн эм хангамж нь саатсан байх юм бол тухайн иргэн даатгуулагч гэрээсээ эмчилгээнийхээ эм танг авсан тохиолдолд эрүүл мэндийн даатгалд заасан ийм зохицуулалт байгаа. Авсан эмийнхээ төлбөрийг нь тухайн эмийн сангууд дээр зах зээлийн үнэ ямар байна, тэр эмийг төлбөрийг нь эрүүл мэндийн байгууллагаас иргэн даатгуулагчдаа олгодог ийм зохицуулалт Эрүүл мэндийн даатгалын хуульд байгаа.

Тэгэхээр гэрээсээ мөнгө зарцуулж авсан эмээ хэрвээ яг өөрсдөө тухайн тусламж үйлчилгээнд шаардлагатай эм байсан бол эмнэлэгтээ хандаад эмнэлгээсээ тэр нөхөн олговор төлбөрөө буцааж авах ийм зохицуулалт нь байгаа.

**П.Анужин:** Баярсайхан гишүүн тодруулъя.

**Б.Баярсайхан:** Тэгвэл нэгдүгээрт яг ингэж хангаж чадахгүй байгаа эмнэлгүүд дээрээ та нар яг ямар арга хэмжээ авч байгаа юм. Үйлчлүүлэгчдийг чирэгдүүлээд байгаа, өөрсдийнхөө үйл ажиллагааны доголдоос болоод өвчтөнөөр өөрсдийнх нь эм, тариаг авхуулаад байгаа эмнэлгүүдтэйгээ та нар ямар хариуцлага тооцож байгаа юм. Эсвэл чиглүүлж юм өгч байгаа юм уу.

Хоёрдугаарт энэ хууль дээр байгаа асуудлыг, энэ зохицуулалтыг иргэд яг хэр мэдэж байгаа юм бэ. Өнөөдөр Монгол улсад эмнэлэг хүнээр дүүрэн байна. Хаана ч очсон. Тэгээд өөрсдөө эм тариагаа авчихсан бол бид нар эмнэлэгтээ хэлээд, энийгээ буцаагаад эрүүл мэндийн даатгалаасаа бид нар мөнгөө авчхаж болно гэдэг зохицуулалтыг би бол анх удаа сонсож байна. Тэгэхлээр энэ тал дээр та нар маань яамаараа дамжуулаад маш сайн мэдээллээ өгөөд соён гэгээрүүлээд өгөөч. Эсвэл эмнэлгүүдийн хана дээр байдаг юм уу сувлагчийн өрөөнд байдаг юм уу эсвэл тэр эргэлтийн хаалга дээр байдаг юм уу энэ мэдээллээ сайн тавьж өгч түгээж өгөөч гэж хүсэж байна. Тийм биз дээ. Тэртээ тэргүй зохицуулалт нь байгаа л юм байна шүү дээ.

**П.Анужин:** Сайд Чинзориг хариулт өгье.

**С.Чинзориг:** Уг нь бол гүйцэтгэлийн санхүүжилтийн чинь гол утга учир, зарчим нь бол чанартай л үр тусламж үйлчилгээ үзүүлсэн бол санхүүжилт авах л ийм л арга шүү дээ. Тэгээд энийгээ бид хаана хаанаа энэ жилдээ сайн ойлгох. Эмнэлгийн удирдлагууд менежментийн сайжруулах ийм тийм юм хиймээр байгаа юм.

2 дахь асуудал нь бид энэ очер дараалалтай холбоотой асуудал дээр бид бодмоор байгаа юм. Тогтолцоо маань жаахан асуудал үүсгээд байна. Би түрүүн ч ярьж л байсан. Дүүргийн эмнэлэг, аймгийн эмнэлэг төрөлжсөн 1, 2, 3 дугаар эмнэлгүүдийг чинь бүгдийг нь нэг шатлалын эмнэлэг болгочихсон. Лавлагаа шатны эмнэлэг болгочихсон. Тэгээд энэнээс чинь үүдээд ерөөсөө хүн дүүргийнхээ эмнэлэг рүү үзүүлэх биш бүгдээрээ 1, 2, 3 руу очиж үзүүлэх гээд ингээд асар их хэмжээний очер дараалал үүсгээд байгаа юм. 1 дэх асуудал.

2 дахь асуудал нь ер нь иргэн эмнэлгээ сонгож үйлчлүүлнэ гэдэг хуулийн заалттай. Яг манайд өнөөдөр

зохицож байгаа заалт уу, үгүй юу. Тэгээд энэнээс чинь.../минут дуусах/

**П.Анужин:** Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууя.

**Б.Жаргалмаа:** Баярлалаа. Өнөөдөр 3 дугаар сарын 28-ны өдөр. Дэлхийн эмч нарын өдөр тохиож байгаа. Бүх эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эмч мэргэжилтнүүд, цагаан нөмрөгт баатрууддаа нэн тэргүүнд баярлалаа гэдгээ хэлээд баярын мэнд хүргэе. Тэгээд сая нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр Баярсайхан гишүүн маань ч ярьчихлаа. Түрүүн Чинзориг сайд маань ч гэсэн хэлсэн. Ерөнхийдөө бол энэ чиглэл рүү хандсан үйл ажиллагааг идэвхжүүлэх зайлшгүй шаардлага байгаа. Өрхийн эрүүл мэндийн төвийн гол үйл ажиллагаа бол нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн боловсрол олгох энэ үйл ажиллагаа явуулдаг. Гэсэн хэдий ч бас энэ маань зөвхөн Эрхийн эрүүл мэндийн төв дээр ирсэн үйлчлүүлэгчдээ үзүүлж байгаа болохоос бус нийтийг хамарсан тэр чиглэл рүү өөрөөр хэлэх юм бол олон нийтийг хамруулсан эрүүл мэндийн нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах дээр учир дутагдалтай байгаа шүү гэдгийг хэлэхийг хүсэж байна. Зүгээр магадгүй үүнийг нь нөгөө оношны хамааралтай ч гэдэг юм уу. Болж өгвөл гүйцэтгэлээр санхүүжих юманд нь оруулаад, төлбөрийг нь гэдэг юм уу гүйцэтгэлийн санхүүжилт дээр нэмэх тэр боломж нь хэр байгаа вэ гэдэг ийм асуулт байна.

Хоёрдугаарт эмийн асуудал түрүүн ярилаа. Даатгалаар олгогдож байгаа эмийн жагсаалт бол 596 гэсэн жагсаалтыг би харсан санаж байна. Тэгээд нэгэнт төр энийг даатгалын хөнгөлөлт үзүүлээд, эм оруулж ирж байгаа компаниудтайгаа хамтарч ажиллаж байгаа энэ тохиолдолд эм оруулж ирж байгаа компаниудтайгаа хариуцлагатай байвал яасан юм бэ. Нэг эмийн сан дээр очоод нэг эм авна. Нэг нь даатгалаар олгогдож байгаа боловч өөр

үнэтэй, дахиад нэг өөр газар очоод дахиад л нөгөөдөх эмээ авах гэхээр дахиад өөр үнэтэй байх жишээний. Тэгвэл тогтсон үнийг тогтоох эрхийг ЭМДҮЗ юм уу Эрүүл мэндийн яам, сайд мэдэж зохицуулалт хийдэг болбол ямар вэ гэдэг энэ саналыг хэлж байна. Яагаад гэвэл эм чинь өөр өөр үнэтэй байна шүү дээ. Даатгалаар авч байгаа шүү дээ гэдэг ийм асуулыг иргэд, олон нийт маань асууж байна.

**Гуравдугаарт** Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв дээр бид нар очиж ажилласан. Нийгмийн бодлогын байнгын хороо, Ануужин гишүүн, Туваан гишүүн бид нар очиж ажилласан. Энэ дээр шийдвэрлэх маш олон асуудал байна. Хэдийгээр 2 дахь шатлалыг эмнэлэг гэдэг статустай болов чиг төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэг статустай. Гэтэл даатгалаар олгогддог урсгал зардал байхгүй. Даатгалаараа урсгал зардлаа нөхөөд бараг цалингаа тавиад явдаг. Эрүүл мэндийн даатгалаараа. Энэ зохицуулалтын 3 яамны дунд яг одоогоор 2 яамны дунд орхигдчихоод байгаа байхгүй юу. Би энийг Эрүүл мэндийн сайдтай уулзаж ярилцсан байгаа. Энэ дээр ямар шийдвэр гаргахаар зохицуулалт хийгдэж байгаа вэ. Даатгалаараа санхүүжчихдэг, гэтэл эрүүл мэндийн даатгалаараа болохоороо 7-14 хоног хэвтэн эмчлүүлж байгаа хүмүүсээс шалтгаалаад даатгал нь олгогдчихдог. Гэтэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд чинь 7 байтугай 2 сараар бараг насаараа эмчилгээ авч байгаа хүмүүс байдаг. Тэгэхээр энэ дээр даатгал санхүүжилт нь гацчихдаг. Энэ асуудлыг хэрхэн яаж зохицуулах юм бэ. Энэ дээр хүн хохироод байна. Бид хэн нэгэн иргэнээ хохироох ёсгүй. Өвчлөлөөс шалтгаалаад олон хоног эмчлүүлж байгаа бараг насаараа эмчлүүлж байгаа хүмүүс байгаад байгаа. Энэ дээр ямар зохицуулалт хийх болж байна вэ. Энийг тайлбарлаж өгөөч ээ.

Сонирхоод асуух юм бол улсын эмнэлэгт ажилладаг болов чиг хувийн эмнэлэгтэй нийт хэчнээн эмч байдаг юм. Яг энэ дээр байгаад байна л даа. Хувийн эмнэлгүүд өндөр үнэтэй оношнууд руу хөрвүүлэх зөрчил нь өндөр байна гээд. Яг л энэ чинь яваад байгаа байхгүй юу. Улсын эмнэлэгт очоод үзүүлдэг тэр дээр очоод тийм оношилгоо хий, ийм MRI, CT хийлгээд ир гэдэг. Тэгээд энэ нөхцөл байдлыг зохицуулахын тулд яах ёстой юмэ Энэ дээр нэг хариулт өгөөч ээ. Нөгөөтээгүүр Хүүхэд хөгжлийн төв дээр тэнд байгаа өвдсөн хүүхдүүд маань хамаарах эзэнгүй, өөрөөр хэлэх юм бол харьяалах эцэг эхгүй хүүхдүүд маань 18 нас хүртэл тэндээ эмчлүүлж хяналтад байчхаад, эргээд хаана очих вэ гэдэг асуудал шийдвэрлэгдэж чаддаггүй. Тэнд 18 настай нэг хүүхэд байна. Нийслэлээс 18 хүнийг энэ төв дээр аваач гэдэг хүсэлт тавиад байдаг. Гэтэл тэд нарын хүмүүс нь 18 нас хүрчихсэн байгаа байхгүй юу.

**П.Ануужин:** Эрүүл мэндийн сайд хариулах уу.

**С.Чинзориг:** Яах вэ, бид нар энэ эмтэй холбоотой асуудал дээр нэлээн ажиллаж байгаа. Жаргалмаа гишүүн ээ, би түрүүн хэлсэн Шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөө газартай хамтраад ажлын хэсэг ажиллуулж байна. Би өөрөө Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газрынхантай 2 ч удаа уулзсан. Мэдээлэл солилцсон. Нэлээн материал цуглуулж байгаа. Тэгээд эмийн үнийг оновчтой тогтоох, тэгээд ялангуяа даатгалын сангаас хөнгөлөлттэй үнээр олгож байгаа эм бол ижил ойролцоо үнэтэй байх гээд асуудлыг нэлээн судалж, нэг тийш нь шийдэх нь зүйтэй байх гэж бодож байна. Нэлээн өөрчлөлт хийхээр хичээж байгаа. Тэгээд хуулийн нэлээн зохицуулалт оруулах шаардлагууд байгаа юм байна лээ. Төрөөс ч гэсэн бас стратегийн бүтээгдэхүүн учраас онцгой анхаарал үзүүлдэг байх, дэмжлэг туслалцаа байх ийм асуудлыг ч гэсэн бид ярих зайлиггүй шаардлагатай. Ний нуугүй

хэлэхэд 30 жил энэ эмийн ханган нийлэлтүүд чинь хувийн хэвшлийн нуруун дээр үүрүүлээд л, тэгээд л хаячихсан юм байна лээ шүү дээ. Төр ерөөсөө туслалцаа, дэмжлэг үзүүлдэггүй, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлдэггүй, хөнгөлөлттэй эх үүсвэрийн дэмжлэг үзүүлдэггүй. Улаан буудай тариалж байгаа хүмүүст маш их дэмжлэг үзүүлдэг, хөнгөлөлт үзүүлдэг, түлш шатахуун нийлүүлж байгаа компаниудад хямд эх үүсвэрийн дэмжлэг үзүүлдэг, хөнгөлөлт үзүүлдэг. Эмийн ханган нийлүүлэлтээр тийм асуудал байхгүй. Ер нь бол төрийн зохицуулалтын гадна хаячихсан юм байна лээ. Тийм учраас би бол эм гэдэг үндэсний аюулгүй байдлын асуудал. Стратегийн чухал бүтээгдэхүүн. Тийм учраас төр оролцох юмандаа ч оролцох ёстой, хоёрдугаарт төр дэмжлэг үзүүлэх юмандаа ч дэмжлэг үзүүлэх ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа. Ийм чиглэлээр хандаж хуулийг оруулж ирнэ гэж.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэр сэргээн засалтын төвтэй холбоотой асуудал дээр нэг зовлон байгаа байгаа юм аа. Харьяаллын асуудлыг ер нь манай Байнгын хороо авч үзвэл яасан юм. Одоо Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгаа байхгүй юу. Тэгээд эртүүд та 5 дахь өдөр ярихдаа ярьж байсан. Урсгал зардал байхгүй гээд. Манайх Даатгалын ерөнхий газар гэрээ байгуулаад Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт өгөөд явж байгаа юм байна лээ. Тэгээд өөр сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгаа асуудлыг чинь би тэгнэ, ингэнэ гэж хэлэх хэцүү. Тэгээд шинэ сайд нь удахгүй томилогдох байх. Тэгээд шинэ сайдтай нь бид нар хамтраад ажлын хэсэг гаргаад ойрмогхон үзье. Тэгээд ямар дэмжлэг тустай байж болох нь вэ гэдэг асуудал байгаа юм. Тийм учраас энийг та бүхэн байнгын хороо анхаараад яахгүй юу даа. Намайг Хөдөлмөрийн сайд байхад ашиглалтад орж байсан. Энэ чинь 2018 онд орсон уу, 2019 онд орсон

бил үү. Тэгээд л тэр төсөв муутай, боловсон хүчин муутай, сэргээн засах чиглэлийн, хөдөлгөөн засал чиглэлийн мэргэжилтэн муутай тийм л газар л байсан л даа. Одоо бол өөрчлөлт ороогүй болов уу гэж би бодож байна. Тэгээд нөгөө 2 асуудлыг нь Эрдэмбилэг дарга хариулчих.

**П.Анужин:** 3 номерын микрофонд Эрдэмбилэг дарга гүйцээж хариулъя.

**Ц.Эрдэмбилэг:** Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Эмийн үнийг тогтоох асуудал дээр сайд маань тайлбар хэлсэн. Энэ дээр нэмэлт хийхэд манай яам дээр ажлын хэсэг байгуулагдаад бид бүхэн ажиллаж байгаа. Энэ дээр үнийг тогтворжуулах, бууруулах тал дээр хэрхэн яаж ажиллах вэ гэдэг дээр янз бүрийн хувилбар, тооцоолол хийгээд явж байна. Ер нь бид бүхэн Засгийн газрын хуралдаанаар эм ханган нийлүүлэх чиглэлээр төрийн өмнөөс худалдан авалт хийх ийм Улсын төсөвт үйлдвэрийн газар байгуулах асуудлыг Засгийн газраар танилцуулсан байгаа. Ер нь ковидын үед бид нарт сайн туршилага байгаа. Жишээлбэл Ковидын үед яг эмчилгээнд шаардлагатай байсан Ремдесивир гэсэн энэ тарианы нэг ампул нь зах зээл дээр 160 мянгаар зарж байсан. 160 мянгаараа ч олддоггүй. Тэгээд нэг хүний курс эмчилгээ нь бол 5-6 ампулыг тарьдаг. Бараг 1 сая гаруй төгрөгийн эм, эмчилгээ байсан. Энэ дээр бид нар Гадаад харилцааны яамтайгаа хамтраад Энэтхэгт үйлдвэрлэж байгаа тэр үйлдвэрээс нь Жубилан Мед гээд үйлдвэрээс нь шууд худалдан авалтууд хийгээд үзэхэд 1 ампулыг 38 мянган төгрөг болгож буулгаж бол чадсан. Тэгээд 4 дахин буулгасан гэсэн үг. Тэгэхдээ энэ шиг бид бүхэн ийм төрийн улсын төсөвт үйлдвэрийн газраар байгуулаад энэ том том эмийн үйлдвэрлэгч компаниудтай Засгийн газрын өмнөөс, төрийн өмнөөс гэрээ хэлэлцээр хийгээд нийт жилд худалдан авах эмийнхээ тоог гаргаж байгаад хэлэлцээр хийх юм бол нэгж эмийн үнийг

бууруулах боломжтой юм байна гэсэн ийм судалгаа гарч байгаа. Гэхдээ төр хувийн хэвшилээр ингээд яваад ирсэн энэ тогтолцоогоо төр дундуур нь орох юм бол аюултай. Тийм учраас бид нар бол одоо ярилцаж байгаа хувилбар дээр бол төрийн өмнөөс гэрээлэх үнийг нь буулгах хэлэлцээрийг нь бол энэ байгууллагаараа хийгээд, манай аж ахуйн нэгжүүд эм ханган нийлүүлэх байгууллагууд нь бид нарын гэрээлсэн үнээр нь оруулж ирэх, ингээд зах зээлдээ нийлүүлэх энэ чиглэлийн хувилбар нь хамгийн оновчтой юм гэсэн ийм хувилбарууд яригдаж байгаа.

**П.Анужин:** Жаргалмаа гишүүний асуулт дээр нэмж хэлэхэд, өнгөрсөн 7 хоногт та бид хамтдаа бас Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд Хүүхдийн сэргээн засах төв дээр ажилласан. Тус төв дээр ажиллахад бол би яг Чинзориг сайдын хэлсэнтэй ижил санааг энэ яамнууд уулзаж харьяаллын асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хороо дээр ярих шаардлагатай гэдэг чиглэлийг өгсөн байгаа. Тэгээд ирэх 7 хоногийн Байнгын хорооны хурлаар энэ Хүүхдийн нөхөн сэргээх төвийн харьяаллын асуудал яг хаана байх нь зөв юм бэ гэдгийг ярих чиглэл өгсөн байгаа. Ирэх 7 хоногт орж ирэх учраас энэ асуудал илүү тодорхой яригдана гэж харж байна. Жаргалмаа гишүүн тодруулъя.

**Б.Жаргалмаа:** Яг үнэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн асуудал дээр бид нар статусын асуудлыг яаралтай шийдвэрлэхгүй бол тэнд олон хүний амь нас, эрүүл мэндийн асуудал байгаа шүү гэдгийг хэлье. Үнэхээр даатгалаараа санхүүжнэ гэдгээр хүлээгдээд тэнд эмчилгээ авах боломжгүй байгаа. Тэнд ажиллаж байгаа эмч, ажилтнуудын өөрсдийн сэтгэлээр нь ажиллаж байгаа ийм нөхцөл байдлыг бид нар яаралтай шийдвэрлэх шаардлагатай байгаа шүү гэдгийг хэлье.

Нөгөө талаар харьяалах хүнгүй буюу эцэг эх, асран хамгаалагчгүй, өнчин. Тэгсэн хэр нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асуудлыг бид нар цаашидаа яаж шийдвэрлэх юм бэ. Энэ дээр бас яг Нийгмийн бодлогын байнгын хорооноос чиглэл гаргах шаардлагатай байгааг бид нар дахиад онцлоод хэлье гэж бодож байна.

Миний 2 асуултад хариулсангүй. Нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн үйл ажиллагаа өрхийн эрүүл мэндийн төв дээр байдаг. Зөвхөн өрхийн эрүүл мэндийн төв очсон үйлчлүүлэгч биш нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулах дээр нь бид нар оношны хамааралтай гэдэг жагсаалтад оруулаад урамшууллыг нь өгвөл яасан юм гэдэг нэг асуулт.

Хоёрдугаарт нь Улсын эмнэлэгт ажилдаг хэр нь хувийн эмнэлэгтэй хэчнээн эмч байдаг юм бэ. Нууц биш бол энийг хэлээч гэж.

**П.Анужин:** 1 номерын микрофонд хариулт өгье. Өөрийгөө танилцуулаад хариулаарай.

**С.Төгсдэлгэр:** Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Төгсдэлгэр. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ сургалт сурталчилгааны хувьд бол ер нь нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ бүх нийтийн үйл хэрэг байдаг. Манай салбарт хэрэгжүүлж байгаа иргэдийн эрүүл мэндийн боловсролыг сайжруулах үйл ажиллагаа бол учир дутагдалтай байгааг бил нар хүлээн зөвшөөрч, ялангуяа хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааныхаа үр дүнг тэр бүр тооцохгүй явж ирсэн байна гэдгийг хүлээн зөвшөөрөөд энэ иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх стратегийг боловсруулах ажлын хэсэг байгуулаад ажиллаж байна. Энэ бол нэлээн нухацтай ажил хийгдээд яг хүн ам аль сегментэд ямар сувгаар, ямар арга хэрэгслээр эрүүл мэндийн боловсролыг

хүргэх юм бэ гэдэг асуудлыг нэлээн тодорхой болгож өгнө гэж харж байгаа. Гэхдээ яг энэ бүх нийтэд эрүүл мэндийн боловсролыг олгох энэ үйл ажиллагаа дээр Өрхийн эрүүл мэндийн төвүүд, ер нь эрүүл мэндийн байгууллагууд дангаараа бол.../минут дуусав/

**П.Анужин:** Тэр нөгөө юуны асуудал Жаргалмаа гишүүн их тодорхой асуугаад, хариултаа авахгүй байгаагаа хэлээд байна. Нөгөө нөхөн сэргээх төв дээр хуулийнхаа дагуу 18 нас хүртэл байгаад, тэгээд цаашаа энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд чинь нөгөө энгийн асрах газар руу ч явах боломжгүй. Өнөөдөр нийслэлийн хэмжээнд одоо нэг охин маань эргээд оччихсон байгаа. Тэгээд нийслэлийн хэмжээнд 20-иод хүүхдийн ийм асуудал байгаа. Энэ асуудлыг Байнгын хороо анхаарлаа тавьж, ирэх 7 хоног, түүний дараагийн 7 хоногийн асуудлаар энийг тодорхой оруулж ирэхээр бид нар төлөвлөгөөнд тусгасан байгаа гэдгийг Жаргалмаа гишүүнд хэлье. Буланы Бейсен гишүүн асуулт асууна. Санал давхар явж байгаа шүү Бейсен гишүүн ээ.

**Б.Бейсен:** Эмнэлгийн салбарт ажиллаж байсны хувьд өнөөдрийн тулгамдаж байгаа асуудлыг Чинзориг сайд сайн гаргасан байна. Тэгэхдээ нэг дутагдал байна энэ дээр. Эмч, эмнэлгийн ажилчдын цалингийн гүйцэтгэлийн санхүүжилтийн асуудал байна л даа. Хот, хөдөөд ялгавартай гаргахгүй бол 3 дугаар шатлалын эмнэлгийнхэн цалин өндөр авч байгаа нь үнэн. Өндөр өртөгтэй юугаар ажиллаж байгаа. Сая хөдөө сумуудаар явсан. Аймгуудаас судалгаа авсан. Зарим эмнэлгүүд дээр яваад юу авлаа. Ерөөсөө ийм хэмжээний цалин авч байгаа юм байхгүй шүү зарим нь. Энийг цалингаа голчихсон эмч, сувилагч нар гадагшаа явж байна. Хомсдол өсөж байна. Тийм учраас одоо энэ эмнэлгүүдээр сувилагч, нарын эмч нарын хомсдол хэр байна. Асрагч нарын. Тэр талаар нэгдүгээрт хариулна уу. Энэ цалингийн сүлжээний юу болохоор чинь

нэгдүгээрт Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор ТҮ-ийнхэн цалинжиж байгаа. Мөн 2022 оны 107 дугаар тогтоолоор ТҮ-ийнхэн цалинжиж байгаа. Үүгээрээ хөдөөд ийм олгоод байгаа. Нэмэгдэл байхгүй, тэгээд цалин хүрэхгүй. 30 ажил ажилласан ч гэсэн 1 сая 400, 1 сая 200 л авч байна. Зарим нь 900 авч байна. Жижүүрт гараад нэмээд авч байгаа шүү дээ. Зарим нь тэр нь хүрэхгүй байна. Тийм учраас энийг ялгавартай хандахгүй бол болохгүй нь ээ. Үүний гол юу анхан шат, зарим дунд шатны эмнэлгүүдийн тоног төхөөрөмж дутагдалтайгаас хот руу чирэгдүүлсээр хотын эмнэлгүүдийн ачаалал ихсэж байна. Өнөөдөр гэхэд 1 дүгээр эмнэлгийн эрүү нүүр дээр нэг хүн үзүүлэх гэсэн чинь, хагалгаа хийлгэхэд 11 сар хүртэл очер нь дүүрсэн байна шүү дээ. Энэ асуудал дээр анхаараад тоног төхөөрөмжөөр сум өрхийг хангах тал дээр анхаарахгүй бол болохгүй нь. Бид нар жилийн эцсээр уг нь урсгал засвар, тоног төхөөрөмж дээр бид нар чинь 166 тэрбум тавиулсан. Тэрийг хасаад хаячихсан байна. Сая сайдаас асуусан чинь. Бид нар чинь анхаараагүй юм байна. Уг нь төсөл дээр нь орсон юм. Дараа нь төсөв дээр нь хасаад хаячихсан байна. Ийм л асуудлууд байж байна. Нөгөө талаар Эрүүл мэндийн даатгалын шалгуур үзүүлэлт дээр сумууд дээр сая явахад ерөөсөө аймгийн төвийн зарим хувийн эмнэлгүүд дээр уушигны хатгааг яах аргагүй эмчилж байна. Гэтэл рентген аппаратгүй гэдгээр шалгуураасаа хасагдсан. Одоо манайх чинь хүйтэн, эрс тэс амьсгал уур амьсгалтай. Тэгээд хатгаа их тусдаг ийм газар. Тэгээд хатгаа эмчилдэг. Тэгсэн мөртөө юугаа авч чаддаггүй. Тэгээд эмээ зарцуулаад хаячихдаг ийм байгаа юм байна. Энийг шалгуур үзүүлэлт дээр нь анхаараад яахгүй бол тоног төхөөрөмжийн хангалтын асуудал хэцүү байгаа шүү дээ. Сумууд дээр мөн алсын түргэн тусламжаар явж байгаа улсуудын нөгөө даатгалаас олгох юмыг чинь 35 юм уу, 70 километр хүрэхгүй бол олохгүй гэдэг асуудлаар

тэгээд ихэнхдээ ард иргэд өөрсдөө бензин хийгээд явдаг юм байна. Энэ дээр анхаарахгүй бол үнэхээр болохгүй. Бодит юм шүү. Та нар асуугаарай хөдөөнийхнөөс.

Дараа нь эмийн асуудал байна. Аптек, эмийн асуудал дээр онцгой анхаарахгүй бол үнэхээр болохгүй нь ээ. Эмийн үнэ өндөр байна. Хөнгөлөлттэй эм авч чадахгүй байна. 500 хэдэн эм гэхээд 200 хүрэхгүй л эм байгаа шүү дээ. Жишээлбэл тэр даралтын эм нь 19 төрлийн эм байгаа. Хөнгөлөлттэй эм дотор. Азотрин гэхэд 10 хэдэн төрлийн эм байгаа. 200 хэдхэн эм байгаа та нар хараарай. 500 хэд гэж байгаа мөртөө дотроо өөр өөр кодтой эмүүд байж байгаа. Би нэг минут нэмээд авъя дарга аа.

**П.Анужин:** Бейсен гишүүнд нэмэлт 1 минут өгье. Гүйцээгээд асууя.

**Б.Бейсен:** Эмийн асуудал дээр анхаарахгүй үнэхээр хэцүү байна. Эм нь хүрэлцэхгүй байна. Эмнэлгүүдээр тоног төхөөрөмж байхгүй байна. Ер нь анхаарахгүй бол эрүүл мэндийн салбар 100 жил болоход ухарчхаад байна шүү дээ. Сум дээр эх төрөхгүй байна. Аймаг руу явж байна. Хуучин сумд эмнэлгүүд дээр олгой хагалгаа ордог байсан. Мэргэжлийн хомсдолтой тэгээд аймаг руу явж байна. Хот руу явж байна. Энэ ачааллыг бид нар нэлээн бодохгүй бол болохгүй нь ээ. Нөгөө талаар эмийн үйлдвэр дээр Монгол Улсын Засгийн газар анхаарах ёстой. 30-хан төрлийн эмийг дотооддоо үйлдвэрлэдэг витамин энэ тэр. Эм үйлдвэрлэж чадахгүй гаднаас авч байна. Энэ нь улсын аюулгүй байдалтай холбоотой. Эмийн үйлдвэр лаборатори дээр очсон. Юмнууд нь дутагдалтай байж байна. Энийг Эрүүл мэндийн яам бас Нийгмийн бодлогын байнгын хороо, Засгийн газарт оруулаад шийдүүлэхгүй бол Монгол Улсын аюулгүй байдалтай холбоотой асуудал биш шүү дээ. Энэ дээр анхаармаар юм. Мөн

гадаадад эмчлүүлж байгаа өвчтөнүүдийн талаар.../минут дуусав/

**П.Анужин:** Эрүүл мэндийн сайд Чинзориг хариулна. Сая асуултад нь амжаагүй гадаадад өөрсдийнхөө зардлаар Монгол улсад эмчлэгдэх боломжгүй ийм тохиолдлуудыг манай иргэд чинь өөрсдийнхөө зардлаар ихэнх голдуу яваад байгаа. Тэгэхээр энэ дээр дэмжлэг тусалцаа үзүүлэх тухай бодлого байна уу гэдгийг үүн дээр та хариулт өгөөрэй. Нэмээд өгчхөөрэй.

**С.Чинзориг:** Бейсен гишүүний асуултад хариулъя. Цалинтай холбоотой юм дээр өөрчлөлт оруулна Бейсен гишүүн ээ. Би түрүүн хэлсэн. 107 дугаар тогтоолоор төсвийн ерөнхийлөн захирагчид эрх олгосон юм байна лээ. Энэ хүрээндээ доод жишигээс дээгүүр төсөвт багцдаа багтаагаад цалин тогтоох эрхийг нь олгосон. Энэ эрхийг Эрүүл мэндийн яам бид өмнө нь хэрэгжүүлээгүй явсан юм байна лээ. Энийг хэрэгжүүлнэ.

Хоёрдугаарт тэр ур чадварын нэмэгдэл олгох шалгуурыг оновчтой болгож журмыг нь баталж мөрдүүлнэ ээ.

Гуравдугаарт тэр сумын эрүүл мэндийн байгууллагууд төсвийнхөө үлдэгдлийг захиран зарцуулах эрхгүй болчихоод байгаа юм. Төсвийн хуулиараа. Төсвийн тухай хуульд нь би өөрчлөлт яаралтай оруулъя. Тэгээд ийм 3 өөрчлөлт оруулах замаар эрүүл мэндийн салбарт ажиллагсдын цалин хөлстэй холбоотой асуудал нэлээн боловсронгуй болгох шаардлагатай. Энэ асуудлыг шийдээгүй учраас үндсэн цалингаа хөдөлгөөгүй дандаа урамшуулал хэлбэрээр бас цалинг нь нэмчихсэн ийм асуудлууд байгаа юм байна. Ер нь жаахан цэгцэд нь оруулна гэж бодож байна.

Тоног төхөөрөмжтэй холбоотой асуудал үнэн. Ер нь бол гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой асуудлыг яг бүрэн хэрэгжүүлбэ гэвэл би хуучин ч



гэсэн ярьдаг л байсан. Гарааны ижил тэгш нөхцөлийг л бүрдүүлж өгөх хэрэгтэй л дээ. Тоног төхөөрөмжтэй холбоотой асуудал, оношилгоо, шинжилгээ, эмчилгээний тоног төхөөрөмж, боловсон хүчний нөөцийг ижил түвшинд хүргэж байж л энэ санхүүжилт авах ийм боломж нь бүрдэнэ. Энэ боломжийг нь бүрдүүлж өгч чадахгүй л бол үр дүнгүй болно.

Хоёрдугаарт. Нөгөө талдаа гол нь ерөөсөө эрүүл мэндийн байгууллагыг удирдаж байгаа хүний тэр менежменттэй холбоотой асуудал их байгаа юм. Энэ жилийн төсөв дээр нэг ч төгрөгийн тоног төхөөрөмж байхгүй. Нэг ч төгрөгийн их засварын төсөв батлаагүй юм байна лээ. Тийм учраас бол энэ жил баахан хий, хуурайлаад ярих л юм болчихоод байна. Тоног төхөөрөмжтэй холбоотой асуудал дээр.

Эмийн асуудал дээр нэлээн онцгой анхаарал хандуулна. Ялангуяа бид тэр нэгдсэн худалдан авалтын тогтолцоо руу орох хэрэгтэй байна. Хоёрдугаарт төр эмийн тодорхой хэсгийг худалдан авдаг байх ийм бүтэц тогтолцоо руу орох хэрэгтэй байна. Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй үнээр олгож байгаа эм, улсын нөөцийн эм, тариа тэгээд төрийн эрүүл мэндийн байгууллагуудын хэрэгцээнд хэрэглэгддэг эмийг нийлүүлээд үзэх юм бол нийт импортын эмийн зах зээлийн 30 орчим хувь байгаа юм. Энэ хувийг нь төр өөрийн бүтцийн байгууллагаар дамжуулан шууд худалдан авалт хийдэг байх ийм тогтолцоо руу ч гэсэн орох нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байгаа. Ийм чиглэлээр хууль тогтоомжийн өөрчлөлт оруулж ирнэ. Тийм учраас гишүүд нэлээн ойлголттой болж байгаад дэмжих талаар ажиллавал их сайн байна гэж би бодож байна.

Хоёрдугаарт тэр шалгууртай холбоотой асуудлыг бид нар нэлээн өөрчилнө. Нэлээн өөрчлөлт хийж байгаа гэдгийг хэлье. Ялангуяа тэр яаралтай

тусламжийг нэлээн тодорхой болгох хэрэгтэй байна. Сумд адилхан бид нар хатгаа эмчилж байгаа гэтэл сум, аймаг, төрөлжсөн эмнэлгүүд ялгамжтай байна гэдэг асуудлууд байгаад байдаг. Энийг ч гэсэн бид нар нэг тийш нь тодорхой болгож цэгцэлнэ гэсэн ийм тохируулгууд нэлээн хийгдэнэ. Ингээд 5 сарын 1-ээс мөрдүүлэхээр ажиллаж байгаа гэдгээ дахиж хэлье.

**П.Анужин:** Баярлалаа  
Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууна.

**Ж.Чинбүрэн:** Богинохон хугацаанд ярих учраас нэлээн хурдан ярихгүй амжихгүй. Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хамгийн чухал зүйл бол бид үр дүнд суурилсан санхүүжилт өгч байгаа. Энэ бол сайн ажилласан, сайн хүмүүсийг эмчилсэн эмнэлгүүд санхүүжилтээ авна гэдэг үндсэн концепц. Тийм учраас реформын явцад дунд хугацаанд сайн ажиллаж чадахгүй, муу менежерүүдтэй эмнэлгүүд ялгагдаж, сайн менежерүүдтэй болох шаардлагатайг энд харуулж байгаа нэг том үзүүлэлт шүү. Би бол Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын нэг зарчим зөв санагдаж байгаа зүйл бол чадамжийг нь харж тухайн бүтээгдэхүүнүүд дээр гэрээлж байгаа юм. Энэ бол их чухал зүйл. Чадахгүй байгууллага чадна гэж хэлээд, эмчилнэ гэж хэлээд мөнгө авдаг биш, чаддаг тоног төхөөрөмжтэй байж байж хийх ёстой. Тухайлах юм бол сая Бейсен гишүүн хатгааг рентген аппаратгүй гэж байна. Орчин үеийн айл гэртээ угаалтуургүй айл, гал тогоогоо хийгээд гэр бүл байна гэж байхгүй шүү дээ. Яг тэрэнтэй адилхан заавал рентген аппараттай байх ёстой. Тэр ч утгаараа бид 2020 оны энэ хуульд өөрчлөлт оруулахдаа 21 оны төсөвт 260 тэрбум төгрөг өрсөлдөх чадварыг сайжруулах зорилгоор тавьж өгсөн. Энэ хүрээнд би бүр өөрөө зориудаар Засгийн газраар, Эрүүл мэндийн яамнаас 260 тэрбум төгрөгийн зарцуулалтыг асууна. Асуулга

явуулна шүү. Энд харин Эрүүл мэндийн яам бэлдээрэй. Анхан шатын тусламж, үйлчилгээний дутуу санхүүжилтийг сайжруулах зорилгоор Нийгмийн бодлогын байнгын хороо бид санхүүжилтийг 2 дахин нэмчихсэн. Үүний үр дүнд Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн цалинг та бүхэн харах юм бол 2.3 гэсэн дундаж цалин гарсан байна. Энэ бол бид үр дүнгээ өгсөн байна. Харин сумдын асуудал хүн ам цөөтэй газар үнэхээр үнэн, бодитой асуудал. Харин санхүүжилтээ цалингаа нэмж чадахгүй байгаа сумын эрүүл мэндийн төвийн дарга надад хүсэлтээ илгээлээ. Сүхбаатар аймгийн Асгат сумын эрүүл мэндийн төвийн дарга нь бид цалингаа нэмсэн чинь аудитаас надад торгууль тавьчихлаа би яах ёстой юм бэ гэж байгаа юм. Хууль, эрх зүйн юу нь байж байгаа шүү дээ. 2022 оны Засгийн газрын 107 дугаар тушаал байж байгаа шүү дээ. Цалингаа нэм гэгчихсэн. Тэгэхлээр энүүгээрээ нэмж болж байгаа шүү. Тийм учраас аудитын байгууллагууд ийм буруу зүйл гаргаж болохгүй шүү.

Дараагийн сэдэв. Эмийн чанарын асуудал байна. Би өөрөө эмийн ажлын хэсгийг ахалсан, тэгээд бүх саналаа буцаагаад өгсөн. Жаргалмаа гишүүн хэлж байна. Нэг үнээр зарах ёстой үнэн байхгүй юу. Яагаад нэг үнээр зарахгүй байгаа юм гэхээр бид олигополь систем байгаа буюу бөөний худалдаа эрхэлж байгаа байгууллагууд өөрийнхөө жижиглэн худалдаагаар хямдхан үнэ өгдөг, бусад худалдаанд авах юм үнэтэй заруулдаг. Нэг ёсондоо өрсөлдөх чадвараа хоорондоо өрсөлддөг ийм муу тогтолцоо байгаа. Энийг бид хуулиараа засахаас өөр аргагүй. Эрүүл мэндийн сайдаас харин зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг шинэчилсэн хувилбараа баталсан уу гэдгийг асуумаар байна. Нэгдсэн худалдан авалт бол үнэхээр яг зайлшгүй шаардлагатай эмийн юун дээр хийх ёстой. Эмийн бодлого дээр бид нэг зүйлийг анхаарах ёстой. Бид дандаа чанар гэж яриад байдаг. Өнөөдөр та бүгдийн Эрүүл мэндийн яамнаас

барих гэж байгаа эмийн хуулийн гол санаа бол чанар, 2 дахь чухал зүйл үр дүн байхгүй юу. Тэр эм чинь уугаад хүний өвчин эдгэрсэн үү, тэр бактерийг устгасан уу. Тэгвэл одоо Монгол Улс зах зээл дээрээ үр дүнг хянадаг эм эмнэлгийн хэрэглэлийн хяналт зохицуулах газартай болсон. Энэ газар үнэхээр ажлаа хийж чадахгүй байна. Тийм учраас даргатай болго, бид нарын хуульд оруулж өгч агентлаг байгуулсан үүний үр дүнг гаргаж ирээрэй гэж Эрүүл мэндийн сайд хэлмээр байна. Би нэг минутаа нэмээд авъя.

Дараачийн нэг сэдэв энэ эрт илрүүлдгийн асуудлыг бид ярьж эхэллээ. Сайдын ярих зүйл дотор эрт илрүүлэг заавал байх ёстой байсан. Эрүүл мэндийн яамныхан та нар яагаад энэ сэдвийг оруулж өгөхгүй байгаа юм. Бид анх удаа 60 хэдэн тэрбум төгрөг батлаад өглөө. Өнгөрсөн жил 5 сарын 1-ээс хийлээ. Өнөөдөр та нар 900 мянган хүн үзчихлээ гээд тоо яриад байх юм. Үгүй шүү дээ хэдэн хүнийг үхэх өвчнөөс аварсан тухай.. /минут дуусав/

**П.Анужин:** Чинбүрэн гишүүн нэмэлт 1 минут өгье.

**Ж.Чинбүрэн:** Тийм учраас өнөөдөр та бүгдийн илрүүлсэн гээд байгаа 900 мянган хүн дотор яг амь насыг нь авч одох байсан өвчнөөс би тэдийг нь аварчихсан юм гэдэг тоог яриач. Ийм өвчнүүдээр эрт илрүүлгээ хийгээч ээ сайд аа. Тэгэхгүй баахан хэрэгтэй, хэрэггүй хүмүүсийн ходоодны архаг үрэвслийг үзээд бид яах юм. Яг амь нас авч явж байгаа тэр шигдээс, харвалт, хорт хавдар энэ тухай үзлэг хийдэг. Энэ мөнгийг зөв, эдийн засгийн хувьд өгөөжтэй зарцуулмаар байна шүү дээ. Энэ дээр анхаарлаа хандуулаарай. Энийг бүүр зориуд хэлье гэж бодож байна.

**П.Анужин:** Асуултад эрүүл мэндийн сайд хариулъя.

**С.Чинзориг:** Яах вэ гүйцэтгэлийн санхүүжилт зөв нь зөв л байх. Гэхдээ шулуухан хэлэхэд болохгүй юм зөндөө байгаа. Энийг засъя, тохируулга хийе гээд л ингээд л явж л байна л даа. Болж байгаа би юу гэж ингээд л эсэргүүцээд байгаа юм шиг тохируулга хийх гээд суугаад байх вэ. Ялангуяа нийгмийн эрүүл мэндийн асуудал анхан шатын тусламжийн асуудал хүндрээд байх юм. Чинбүрэн гишүүний хэлээд байгаа бол төрөлжсөн эмнэлгүүдийн түвшинд болж байгаа асуудал. Энэнээс чинь шалтгаалаад төвлөрөл маш их хүчтэй явагдаж байна. Энэнээс нь шалтгаалаад нөгөө талдаа сөрөг юм нь анхан шатны эмнэлгүүд чинь боловсон хүчингүй болчихоод байгаа ийм сөрөг юмнууд ч байгаа юм аа. Тэгэхээр энийг бид нар зөв маш зөв гээд нэг талаас нь ингээд хамгаалаад байх биш, нөгөө талаасаа болж байгаа, болохгүй байгаа юмыг нь тал талаас нь ярьж байгаад зөв голдиролд нь оруулах ёстой гэж бодож байна.

Би 3 сарын 1-ээс эхлээд тэр эмийн жагсаалтыг шинэчилсэн байгаа. Ер нь бол тэр эмийн хөнгөлөлтийг өмнө нь үзүүлж байсан тэр хөнгөлөлтийн хэмжээнд нь хүргэж нэмэгдүүлье гэсэн ийм чиглэл өгөөд ажиллаж байгаа.

Бид эрт илрүүлэг урьдчилан сэргийлэхтэй холбоотой юмыг ярихгүй байгаа биш маш их ярьж байгаа. Ерөнхий сайд газар дээр нь очиж эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгтэй танилцсан. Үүний дагуу тодорхой хэмжээгээр хүүхдүүдийн дунд шүдний цооролт өндөр байгаа учраас “Шүд” төсөл, хөтөлбөр шүдний эм эрүүл мэндийн байгууллагуудтай уулзалт Ерөнхий сайд зохион байгуулсан. Засгийн газар дээр эрт илрүүлэг, урьдчилан хэрэглэх үзлэгийг танилцуулсан. Тодорхой хэмжээгээр ирэх оноос “Шүд” хөтөлбөр хэрэгжүүл гээд тодорхой үүрэг өгсөн. Цаашидаа эрт илрүүлэг, урьдчилан хэрэглэх үзлэгийг компаничилж явуулаад байвал үр дүнгүй байна гэдэгтэй би санал

нэг байна. Тодорхой хэмжээгээр зорилтот чиглэл рүү, зорилтот бүлэг рүү чиглэсэн ийм чиглэлийн урьдчилан сэргийлэх үзлэг явуулах ёстой гэж бодож байна.

Хоёрдугаарт би яамныхаа нэг чиглэлийг байнга хэлж байгаа юм. Ингээд бид нар мэдээллийн сантай болчихлоо. Эрт илрүүлэг явуулаад гээд тайвширч болохгүй. Хүүхдүүдийн чинь дунд шүд цооролт асар өндөр байна. Насанд хүрэгчдийн дунд хоол боловсруулах тогтолцооны өвчин өндөр байгаа бол 2023 онд энэ чиглэлүүд рүүгээ бид нар эрүүл мэндийн тусламж үйлчилгээг голлох, тэргүүлэх чиглэл болгож энэ чиглэл рүү бид эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чиглүүлэх ёстой гэдэг ийм чиглэлээр үйл ажиллагаа явуулах ёстой гэсэн ийм чиглэлүүд өгч ажиллаж байгаа гэдгийг хэлье.

**Ж.Чинбүрэн:** Туваан гишүүн асуулт асууна.

**Ц.Туваан:** Аль болох давхардуулахгүйг хичээнэ. Гүйцэтгэлийн санхүүжилт дээр асуудал байна. Сумд анхан шатад гэж байгаа шүү. Өрхийг нь орхичихъё. Сумд түрүүн тэр тоон дээр 96.4 гээд хувь гарч байна лээ. Бараг л 100 хувь тэгээд л улсынхаа юунаас явж байгаа. Үүний нэг баталгаа нь бол яг ковид дуусаад, эргээд харсан чинь сумын эмч нар ерөөсөө яг бахь байдгаараа байгаа. Хуучнаараа. Нөгөө Эрүүл мэндийн даатгалын байцаагчийн ажлаа хийсээр л байна. Нөгөө хэдэн эрүүл мэндийн даатгал төлсөн хэдэн хүнээ очиж үзэж, өнхрүүлж байгаад л 20 хувийн гүйцэтгэлээ бичээд, тэгээд нөгөө цааш нь явуулаад санхүүжилтээ авдаг энэ тогтолцоо чинь яг хэвээрээ байна. Тэгэхээр гүйцэтгэлийн санхүүжилт гэдэг юмыг үгүйсгэж байгаа юм биш. Тэгэхдээ сум дээр энэ асуудлыг өөрчилж гэдэг ийм саналыг хэлчихъе.

1 иргэний санхүүжилтийг бид нар нэмсэн. 2 дахин нэмсэн. Тэгэхдээ энэ

дээр ерөөсөө айхтар том юм байхгүй шүү дээ. Хувилж барьсан юм байхгүй. Яг 5000 орчим төгрөг л нэг иргэн дээр нэмэгдчихээд байгаа шүү дээ. Энэ чинь цөөн хүн амтай сум дээр бол бодитой өөрчлөлт байхгүй байхгүй юу. Тэгэхээр энийг хэдүүлээ анхааръя. Засгийн газрын 107 хэрэгжихгүй байна гээд яг сая тэр нөгөө юу акт тавьсан. Төв аймаг дээр бүр тодорхой 2, 3 сум дээр нэмчихсэн чинь акт тавиад ингээд асуудал үүссэн. Тэгэхээр энэ асуудлыг анхаарч байгаад Эрүүл мэндийн сайдад баярлаж байна. Тэгэхдээ тэр цалин нэмэгдүүлэх дээр ганц эмч нарынхаа асуудлыг битгий аваад явчхаарай. Сувилагч, эмч эмнэлэг дотор чинь өөр ажиллаж байгаа зөндөө хүмүүс байгаа шүү. 30 хувь гээд л ярьж байна. Өөр бас нэмэгдүүлэх шийдвэрүүдийг засаад явах юм байна. Энэ үндсэн цалин нэмэгдэхгүй байхад чинь бас нэг айхтар хортой зүйл нь тэтгэвэрт гарч байгаа хүн дээр бүр маш хортой шүү дэ. Тэтгэврийг чинь үндсэн цалингаас боддог байхгүй юу. Тэгэхээр бусад урамшууллаас нь бодохгүй учраас багш, эмч 2 тэтгэвэрт гарлаа гэхэд хоорондоо маш их зөрөөтэй тэтгэвэр бодогдоно шүү. Тэгэхээр энэ арга хэмжээг Эрүүл мэндийн яамныхан маань яаралтай аваарай гэдгийг хэлье.

Ур чадварын нэмэгдэл энэ тэр чинь Боловсролын яамныхан аль хэдийн хийгээд ингээд явчихсан. Урьд нь би нэлээн ярьсан. Тэгэхээр Чинзориг сайд бас цалин, ур чадвар дээр нэлээн анхаарч ажиллана гэдэгт нь баярлаж байна.

Резидент. Төв аймаг өнөөдрийн байдлаар 4 сум эмчгүй байна. Өөр цаашаа эмчгүй болох сумдын тоо хаалга тогшоод байж байгаа. Тэгэхээр энэ дээр би асуусан резидентийн бодлого чинь яг ямар хууль, эрх зүйгээр зохицуулагддаг юм бэ. Энэ дээр бүр нарийн хариулт авмаар байна. Юу гэхлээр төгсөөд шууд резидент болоод явчихдаг, дээр нь цалинтай болгочихсон чинь бүр шал дордсон. Одоо яах вэ, эртээд тэр Эрдэмбилэг хариулж л байна лээ. Тэгээд

бүүр эмчгүй байгаа газар чинь тэгээд яах юм бэ. Энэ чинь төгссөн дээд мэргэжлийн эмч нар хуучин ажиллаад л байсан шүү дээ. Тэгэхээр энэ асуудал дээр бүүр нэг ийм хуульд ийм өөрчлөлт байдаг юм гэдгийг нь хэлчхээрэй.

Шүд бүр замаа алдсан. Шүдний кабинеттай ор нэрийн төдий кабинеттай сумууд ганц нэгхэн байна. Шүдний өвчлөл бүр замаа алдсан. Тэгэхээр энэ дээр бид нар нөгөө нийгмийн эрүүл мэнд гэдгийнхээ хүрээнд урьдчилан сэргийлэх байдлаар бусад сайн жишээтэй орнуудын туршилагыг хэрэгжүүлэхгүй бол шүдний өвчлөл чинь хойноос нь эмчлээд ч дийлдэхээргүй хэмжээнд оччихсон. Тэгэхээр энэ дээр Боловсролын сайдтай юм уу ямар бодитой бодлогын бодлогын яам шүү дээ. Бодлогын зорилт юу байна. Хөтөлбөр хэрэгжүүлээд араас нь үзээд яваад байх юм уу, яах юм гэдэг дээр асуулт асууя. 1 минутаа нэгмөсөн авчихъя даа.

**П.Анужин:** Туваан гишүүн асуултаа гүйцээж асууя.

**Ц.Туваан:** Цахим эрүүл мэнд дээр үнэхээр харамсаж байна. Амандаа орсон шар тосыг хэлээрээ түлхчхээж байгаа байхгүй юу. Зөндөө л хэлсэн. Болж байгаа л гээд байсан хаана байгаа юм тэр чинь одоо. Ингээд хайран юмыг алдаад, бүх юман дээр маш том чөдөр тушаа гай болно наадах чинь.

Эм дээр тэр нэгдсэн худалдан авалт нэгдсэн худалдан авалт руугаа ор ор. Одоо тэгээд ремдесивир дээр 4 дахин багасгаад ирж байсан бол тут чинь 75 хувийн нэмэгдэлтэй зараад байна л гэсэн үтэй утга нэг шүү дээ. Тэгэхээр энэ асуудлаа авч хэрэгжүүлэхгүй бол ахмадуудын хамаг тэтгэврийн хамгийг нь үнэтэй эм чинь хамаад дууслаа. Тэгэхээр энэ эм асуудлаар.

Энэ түргэн тусламж дээр оношнуудаа тавьж өг. Бодитойгоор

даралт ихэссэн нэг хүн дуудлага өгөх боломжгүй болчихсон. Эмч нар орон нутаг дээр худлаа дуудлага бичээд л бүрдүүлэлт хийж байна шүү дээ. Бусад оношнуудаа тавьж өг л дөө. Ингээд тэд нарыгаа бүр ийм.../минут дуусав/

**П.Анужин:** Түргэн тусламж гэснээс би нэг нэмэлт асуулт хамтатгаад хариулчхаарай. Манай дүүргийн эмнэлгүүдээс ирээд байгаа юм. Улаан, шар, ногоон эрэмбэ эрчимт эмчилгээний оношны хамааралтай бүлгийг дүүргийн эмнэлгүүдээс санхүүжүүлэхгүй байгаа. Тийм учраас нөгөө түргэн тусламжаар яаралтай ирсэн иргэн чинь ямар ч тусламж авах бололцоогүй ийм болчихоод байгаа. Тэгээд яам хариултаа өгсөн юм байна лээ. Энийг шийдэх ямар ч боломжгүй гэж. Тэгэхээр шийдэхгүй гээд ингээд тас ийм юм яриад байгаа яг асуудал нь юу юм бэ. Бүхэл бүтэн дүүргийн улаан, ногоон бүсийн өвчтөн авахгүй байна гэж яг юу гэсэн, ямар зохицуулалт юм бэ гэдгийг нэмээд хариулчхаарай. Эрдэнэбилэг дарга хариулах уу.

**Ц.Эрдэнбилэг:** Туваан гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээрт нь сая сумын гүйцэтгэл нэг иргэний тарифыг 2 дахин нэмэгдүүлсэн нь 5000 төгрөгийн л гэж байна. Энэ бол ийм тооцоо байгаа шүү. 2 дахин нэмэгдүүлээд нэг иргэнд ноогдож байгаа санхүүжилтийг нь 60 мянгаар нэмэгдүүлсэн байгаа. Тэгэхээр 60 мянгыгаа манай анхан шатынхан юу гэж ярьдаг вэ гэхээр 12 сардаа хуваагаад нэг иргэнд сард 5000 гээд ингээд багаар яриад байгаа юм. Энэ бол нийт тухайн анхан шатын байгууллагын Эрүүл мэндийн төвд хамааралтай тэр засаг захиргааны иргэдийн бүх хүмүүсийг үзэхэд нэг иргэнд ноогдож байгаа 5000 байхгүй юу. Тэгэхээр бид нар эргүүлээд юу шаардах ёстой вэ гэхээр хэрэв та нар 5000 гэж голж байгаа юм бол та нар нийт хорооныхоо бүх иргэдэд очиж үйлчилсэн үү гэвэл хүчин чадлаасаа

хамаараад чадахгүй. Тэгэхлээр энэ 5000 гэдэг тоо бол тийм тоо гаргаад байгаа юм. Би зөв тайлбарласан уу, үгүй юу. Тэгэхээр нэг иргэнд 60 мянгыг жилд нэмж олгож байгаа. Тэрийгээ 12 сардаа хуваангуутаа нэг иргэнд 5000-ыг өгч байна. Энэ их бага гэж тайлбарлаад байгаа юм шүү. Тэгэхлээр энэ бол бүх хүндээ хүрч байна уу, үгүй юу гэдэг өөр асуудал байгаа.

Үндсэн цалинг нэмэхгүй байх нь хор хөнөөлтэй, учир холбогдолтой гэдэг дээр санал нэг байгаа. Тэгээд энэ дээр сайд маань түрүүн хариулсан. 107 дугаар тогтоолоор бид нар төсвийн үндсэн захирагч нар маань төсвийн шууд захирагч нар руугаа бид нар удахгүй чиглэл хүргүүлнэ. Өөрийнхөө төсвийнхөө хүрээндээ ажилчдынхаа цалинг нэмэх асуудлыг зохион байгуулах чиглэлийг бид нар хүргүүлэх гэж байгаа. Дээрээс нь төсвийн тухай хуулийн тэр, сум, тосгоны эрүүл мэндийн газруудын тэр төсвийг нь төсвийн ерөнхийлөн захирагч нь буцааж төвлөрүүлнэ гэдэг энэ заалтыг өөрчилж хуулийн өөрчлөлт оруулснаар энэ үндсэн цалинг нэмэх гарцаа бид нар бий болгохоор ажиллаж байгаа.

Резидентийн бодлогын хувьд их асуудалтай байгаа. Төгсөлтийн өмнөх сургалтыг төгсөлтийн болон төгсөлтийн өмнөх сургалт бакалавр, магистр, докторыг Боловсролын сайдын эрхлэх хүрээнд Боловсролын хуулиар зохицуулагддаг. Төгсөлтийн дараах сургалт буюу резидентийн сургалтыг Эрүүл мэндийн сайдын багцын хүрээнд шийддэг юм байгаа. Тэгсэн мөртөө одоо манай дээр яаж байна вэ гэхээр их, дээд сургуулиуд маань оюутныхаа элсэлтээрээ санхүүждэг учраас тэр их, дээд сургуулиуд оршин тогтнохын тулд оюутныхаа тоог нэмдэг яагаад гэвэл төлбөрийг нь нэмчихье гэхээр улс төрийн ийм асуудал болдог учраас оюутныхаа тоог нэмээд өнөөдрийг хүртэл эрүүл мэндийн салбарын ажилчдын ирээдүйн албан хаагчдын тоо нь боловсролын

салбар явчихсан эрүүл мэндээсээ биш. Тэгэхээр энэ дээр бодлого алдагдсан. Яг 2026 он гэхэд бэлдэж гарах эмчийн тоо 14 их, дээд сургуулиудаас нийтдээ 8 орчим мянган эмч 2026 онд бэлдэж гарах гэж байна. Яг адилхан сувилагч 4000 хүрэхгүй ийм сувилагч бэлдэж гарах гэж байна. Тэгтэл манай улсад эмч сувилагчийн харьцаа 1 эмч олон улсад 4 сувилагчтай ингэж жиших ёстой байхад нэг эмнэлэг 1.15 сувилагч гээд тэгээд 2026 онд энэ тоо маань дахиад даблаар буурах ийм хандлагатай байгаа юм. Тэгэхээр энэ дээр манайх яг бодлого алдагдчихсан явж байгаа. Резидентийн сургалт Эрүүл мэндийн хөгжлийн төвөөр дамжаад эмнэлэгт резидент явагдаж байна. Их, дээд сургуулийн гэдгээрээ АШУУИС бас резидентийн сургалт явуулж байна. Оны өмнө бид бүхэн цөм хөтөлбөртэй байх ёстой гээд резидентурын сургалтын бүх хөтөлбөрийг эмнэлгийн ч тэр, сургуулийн ч тэр резидентийн хөтөлбөрийг нэг амжилт нэг болгож чадсан байгаа. Ингээд баталсан байгаа.

Цахим эрүүл мэнд бол ба дээр улаан эрэмбэ. Энэ бол эрчимт эмчилгээ яаралтай тусламж дээр дотор нь бид нар бас хүнд, хөнгөний зэргээс нь улаан, шар, ногоон гээд өнгөөр эрэмбэлдэг байгаа. Тэгээд энэ бол нөгөө дүүргийн эмнэлгүүд маань хүчин.../минут дуусав/

**П.Анужин:** Хариултаа гүйцээе. 3 номерын микрофон.

**Ц.Эрдэмбилэг:** Улаан, ногоон, шар эрэмбээр хүнд, хөнгөний зэргээр нь бид нар ингэж ангилдаг байгаа. Даатгалын гол үндсэн зарчим тухайн түүрүүн Чинбүрэн гишүүн маань маш тодорхой хэлсэн. Тухайн чадамж дээр нь тулгуурлаж даатгалын байгууллага гэрээлж байгаа. Яагаад гэвэл цаана нь иргэн даатгуулагчийн амь нас, эрүүл мэнд чухал учраас чадамжтай эмнэлэгтэй нь гэрээлж тусламж үзүүлнэ. Гэтэл дүүргийн эмнэлгүүд дээр яалт ч үгүй хүнд хүн ирсэн юм чинь бид

нар энэ тусламжаа үзүүлсэн гээд нэхэмжилж байгаа. Тэрийг нь Даатгалын ерөнхий газраас хянаад олгохыг нь олгож байгаа. Ер нь тэгэхдээ цаашидаа онош ахиулах, эрэмбэ ахиулах үйл явц их газар авч байгаа. Нэхэмжлэлийн шалгуур гарч байгаа учраас бид нар ажлын хэсэг байгуулаад цаашидаа өнгөөр эрэмбэлдэг энийгээ байхгүй болгоод дүүргийн эмнэлгүүд дээрээ ерөөсөө А, Б гэдгээр нь л тусламжийг нь хяная. Өнгөөр бол эрэмбэлэхээ больё гэсэн энэ чиглэл рүү ажиглаж байгаа юм.

**П.Анужин:** Өөрчлөлт орох юм байна гэж ойлголоо зөв үү. Ойлголоо. Батсүхийн Саранчимэг гишүүн асуулт байхгүй байна. Сарангэрэл гишүүн асуулт асууна. Түүрүүн нэг минут өгчихсөн учраас байхгүй байна.

**Д.Сарангэрэл:** Баярлалаа. Эрүүл мэндийн салбарын өмнө тулгамдаж байгаа асуудал, өнөөгийн нөхцөл байдал, мөн тулгамдаж байгаа асуудлын шийдлийн талаар цогц саналаа оруулж ирж байгаа Чинзориг сайдад юуны өмнө талархаж байна.

Хоёрдугаарт салбарын өмнө тулгамдаад байгаа асуудлууд мөн иргэдийн хүсэн хүлээж байгаа асуудлуудыг мөн шийдэлтэй нь, нөхцөл байдалтай нь оруулж ирж байна л даа. Тухайлбал, эмийн үнэ, чанар, хөнгөлөлттэй эмийн хувь хэмжээг нэмэгдүүлнэ, эмийн үнэ, чанарын асуудлыг хувийн хэвшилтэйгээ хамтарч шийдвэрлэх, эрүүл мэндийн салбарын ажилтнуудын нийгмийн асуудал болон цалин мөнгө, урамшуулалтай холбоотой асуудал дээр манай Эрүүл мэндийн яам, сайд тодорхой саналтай байгаа юм байна. Тийм учраас би энэ асуудлуудаа орхиё гэж бодож байна. Тулгамдаж байгаа асуудлаа мэргэжлийнхээ Байнгын хороогоор оруулаад, гишүүдийнхээ санаа оноог аваад явах нь чухал л даа. Тэгээд би зарим нэг шийдэл дээр санал хэлэх гэсэн юм.

Хувийн хэвилийн байгууллагууд, эм ханган нийлүүлэх байгууллага хувийн эмнэлгүүд, мөн энэ гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотойгоор шийдлүүдийг харж байхад зарим нэг ухралт байна уу гэж бодогдож байна. Хуучин тийм төрийн үйлчилгээ рүүгээ эргүүлж оруулах гээд байгаа нэг тийм зарим нэг элементүүд цухалзаад байна л даа. Тэгэхээр тэгж ухралт хийхээсээ илүүтэй одоо тулгамдаад байгаа асуудлуудыг хэрхэн яаж өөрчлөх вэ, зохицуулах вэ, тохиргоо хийнэ гэж та нар маань яриад байна. Энэ дээрээ илүүтэй суувал ямар вэ гэсэн нэг ийм санал байна. Тухайлбал гүйцэтгэл дээр Өрхийн эрүүл мэндийн төв, сумын эрүүл мэндийн төвүүдийг 100 хувь төсвөөс санхүүжүүлжээ гэж байна. Тэгэхээр энэ анхан шатын тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагууд маань яг хуучин хэвдээ үлдэх гээд байгаа юм. Нөгөө эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарт өөрчлөлт оруулах, гүйцэтгэлийн санхүүжилт гэдэг чинь өөрөө эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай үзүүлэх, идэвх санаачилга мотивацыг бий болгоно гэж гүйцэтгэлийн санхүүжилт рүү шилжүүлсэн. Тэгэхээр энэ дээр та нар маань цаашидаа ингээд ямар бодлого барих вэ. Энийг төсөв рүү шилжүүлж байна. Тэгэхдээ саяын эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хуучин байснаасаа өөрчлөгдөх тэр чиглэлд ямар арга хэмжээ авах вэ гэдэг нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт нийгмийн эрүүл мэндийн туслам үйлчилгээний хуулийн тухай бид нар гишүүн болгон ярьж байна. Мэдээж хэрэг урьдчилан сэргийлэх, эрт оношлох, эрүүл мэндийн боловсрол сургалт, мэдээлэл гэдэг цогц асуудал л даа. Энэ асуудал яагаад олон жил яваагүй гэвэл нийгмийн эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэх хүний нөөц, санхүүжилт, байр савныхаа асуудлыг бэлтгэж байж, бэлтгэж байх нь их чухал болоод байгаа юм. Хууль гарчихдаг хэрэгжихгүй байх тийм нөхцөл

үүсэх вий энэ дээр та нар маань одоогоор ямар бодож байгаа асуудал байна гэж.

Гуравдугаарт эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим асуудлууд байна. Дэвшилүүд байгаа ч гэсэн. Хавдрын эмнэлэг, хүүхдийн эмнэлгийн тусламж үйлчилгээ. Тухайлбал Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв дээр байгаа очер дараалал тэр бухимдал их хүнд байна. Энэ дээр жоохон зохион байгуулалт хийх, мэдэхгүй хувийн хэвшилтэй ажиллах юм уу нэг тийм арга хэмжээ авч, ямар нэгэн шийдэл гаргахгүй бол иргэдийн бухимдал энэ чиглэл дээр нэлээн их шүүмжлэл их өндөр байгаа. Та нар маань энэ дээр ер нь яаж ажиллаж гэсэн ийм байр суурьтай байгаа юм бэ. Ингээд би гол 3 асуудал дээрээ хариултаа аваад, тэгээд үргэлжлүүлээд тодруулга хийе гэж бодож байна. Баярлалаа.

**П.Анужин:** Сарангэрэл гишүүний асуултад Эрүүл мэндийн сайд Чинзориг хариулъя.

**С.Чинзориг:** Яах вэ, би ингээд 5 сарын 1-ээс та бүхэндээ танилцуулсан тохируулгыг дахиж нэлээн хянаад Сангийн яамтай яриад, Сангийн сайдтай нэлээн урьдчилж ярьсан. Үндэсний зөвлөлөөр оруулаад 5 сарын 1-ээс мөрдүүлж эхэлье гэсэн ийм бодолтой байгаа. Гэхдээ энэ дээр нэлээн дахиж сууж, нягтлах юмнууд бий. Би түрүүн хэлэхдээ Сарангэрэл гишүүн ээ, сумын эрүүл мэндийн байгууллага, эмнэлэг, өрхийн эмнэлэг нийт төсвийнхөө 93-96 хувийг улсын төсвөөс авч байна. Тэр 4-6 хувийг л Эрүүл мэндийн даатгалын сангаас тусламж үйлчилгээ үзүүлснийхээ төлөө даатгалын сангаас авч байна. Төсвийн маань бүтэц ийм болчихсон учраас цаашидаа 100 хувь төсөв дээр авч явах уу, яах вэ гэдэг асуудлыг судалж үзээд тэр нөгөө Эрүүл мэндийн тухай хууль, Даатгалын тухай хуулиуд өөрчлөлт оруулах асуудал дээрээ авч үзэх үү, яах вэ гэдэг ийм санал л байгаа юм. Одоо 5 сарын 1-ээс хэрэгжүүлэх өртгийн

дахин тооцоолол тарифыг өөрчлөх замаар сумын эрүүл мэндийн байгууллагуудыг хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжийг нь бүрдүүлье гэдэг бол яг гүйцэтгэлийн санхүүжилтийг тохируулга хийгээд одоогийн байгаагаараа явуулна л гэсэн үг. Ер нь цаашидаа ийм төсөв маань бүтэц нь ийм байгаа учраас ер нь өрх сумын эмнэлгийг улсын төсөв дээр авах уу, 100 хувь явуулах уу, үгүй юу гэдгийг цаашидаа анхаарч үзвэл яасан юм бэ гэсэн миний санал л байгаа юм. Яг ингээд 5 сарын 1-ээс энэ арга хэмжээг хэрэгжүүлэх гэж байгаа гэсэн үг хараахан биш. Ер нь бол 100 хувь төсвийн чинь бараг л ч 93-96 хувийг улсын төсвөөс санхүүжилт авдаг, нийгмийн эрүүл мэнд анхан шатын тусламж үйлчилгээгээ голлодог ийм байгууллага байгаа учраас гүйцэтгэлийн санхүүжилт чинь тэнд бол хэрэгжихэд үнэхээр хэцүү байна шүү дээ. Тэгээд хүчээр л бид нар арга ядахдаа нөгөө газар нутгийн коэффициент гэдэг хүртэл юм гаргаж ирээд л алслагдсан хүн ам цөөтэй сумдууд бид нар гүйцэтгэлийн санхүүжилт олгох гээд тохируулга хийх гэж байгаа юм гээд л сууж байна шүү дээ. Тэгэхээр ер нь цаашидаа ийм хүндрэлтэй асуудал байгаа учраас энийг ер нь бусад тэр хууль тогтоомжуудынхаа боловсронгуй болгох, шинэчлэх хүрээндээ авч үзвэл яасан юм бэ гэдэг ийм санал байгаа юм гэж.

Нийгмийн эрүүл мэндийн тухай асуудал дээр бид нар нэлээн анхаарах зайлиггүй шаардлагатай болсон юм байна лээ. Ер нь бол эрүүл мэндийг дэмжих асуудал чинь 2 талтай нэг нь нийгэм эрүүл мэнд, нөгөө нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ гээд. Тэгээд энэ асуудлыг нэлээн орхигдуулж явсан юм байна лээ. Харин та Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль санаачилга гэж байснаа Засгийн газар энэ суурь харилцааг зохицуулсан анхдагч хууль учраас Засгийн газраас санаачлах нь зүйтэй гээд ингээд энэ хуулийг санаачлах эрхийг Засгийн газарт

шилжүүлсэн. Бид их талархаж байгаа. Тэгээд удахгүй энэ хуулийн төслийг оруулж ирнэ. Зүгээр боловсон хүчний нөөц, шинээр орон тоо, бүтэц шаардахгүйгээр одоогийн байгаа бүтэц, орон тоо төсөвтөө багтаагаад Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлээд аваад явах ийм боломж нь байгаа юм байна гэж бид үзэж байгаа. Тийм учраас энэ хуулийн төслийг яамдаас санал авах түвшиндээ явж байгаа. Ингээд Засгийн газарт оруулаад Их Хурал руу хаврын чуулганд багтаагаад оруулж ирэх ийм чиглэлээр ажиллаж байгаа юм.

Тэр 3 дахь асуудал нь юу гэлээ. Манайхан хариулчих. Эрдэмбилэг зөвлөх.

**П.Анужин:** 3 номерын микрофонд Эрдэмбилэг дарга хариулт өгье.

**Ц.Эрдэмбилэг:** Сарангэрэл гишүүний асуултад хариулья. Очер дараалал их байна. Энийг яаж зохицуулах вэ гэдэг дээр. Энэ дээр бол бид бүхэн өнгөрсөн хугацаанд нөгөө төвлөрлийг сааруулах ажлыг бодлогоор хийж ирсэн. Яасан бэ гэхээр гол нөгөө өнгөрсөн хугацаанд бид нар хөрөнгө оруулалтаа клиникийн лавлагаа шатлалын төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүддээ хөрөнгө оруулалтаа илүү ихээр шийдээд, орон нутгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн анхан шатны эмнэлгүүдийнхээ тоног төхөөрөмжийн шинэчлэл дээр төдийлөн хөрөнгө зарцуулж байгаагүй. Өнгөрсөн хугацаанд бас ковидын нөхцөл байдал бол эрүүл мэндийн салбар маш чухал гэдгийг ойлгуулж, манай Их Хурлын гишүүд маань бас дэмжсэний ачаар манай эрүүл мэндийн салбар урьд хойчид байгаагүй хэмжээний хөрөнгө оруулалтыг шийдүүлж чадсан. Үүний хүрээнд бид нар орон нутаг руу илүү чиглэсэн хөрөнгө оруулалтыг хийсэн. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалтыг нь орон нутаг руу чиглүүлснээр тэнд гүйцэтгэлээрээ тусламж үйлчилгээгээ үзүүлэх ийм



чадавхыг бий болгож байгаа. Ингэснээр хотын төв рүү чиглэх төвлөрлийг сааруулах чиглэлийн бодлогыг ингэж уялдуулж явж байгаа. Тэгэхээр орон нутагтаа дүүргийн эмнэлгүүд, эрүүл мэндийн төв эмнэлгүүд дээрээ хөрөнгө оруулалтаа шийдсэнээр ЭХЭМҮТ рүү явах урсгалыг сааруулна гэсэн ийм бодлогыг хөрөнгө оруулалттай нь уялдуулж явуулж байсан. Түрүүн сайдын хариулт дээр нэмж хэлэхэд сайдаас үүрэг даалгавар өгөөд бид бүхэн ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байгаа. Бүх харьяа байгууллагууд дээр сайдын албан даалгавар өгсөн. Энэ дотроо бас анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг гүйцэтгэлийг нь дэмжих, тусламж үйлчилгээний төрлийг нь бүр зааж өгөх, тодорхой болгох. Ингэснээрээ тэр анхан шатны сум, өрхийн эмнэлгүүд маань тэнд лавлагаа шатлал руугаа илгээлгүйгээр өөрсдөө чадах хэмжээ дээрээ тусламж, үйлчилгээ үзүүлж иргэн даатгуулагчийг юу гэдэг юм хүндрэл учруулахгүйгээр, хүртээмжтэй анхан шат дээр нь эмчлэх ийм тусламж үйлчилгээг илүү хөгжүүлэх энэ чиглэл дээр бодлого боловсруулж ажилла гэсэн ийм ажлын хэсгийг байгуулаад бид бүхэн ажиллаж байгаа. Тэгэхээр цаашдаа бид нар анхан шатынхаа тусламж үйлчилгээг нь төрөлжүүлнэ, нэр төрлийг нь зааж өгнө. Ингэснээрээ гүйцэтгэлээрээ санхүүжих санхүүжилтийг нь ч нэмэгдүүлнэ. Дээрээс нь төсвөөс ч гэсэн дэмжинэ гэсэн ийм бодлого байгаа.

**П.Анужин:** Сарангэрэл гишүүн тодруулъя.

**Д.Сарангэрэл:** Эрдэмбилэг дарга би тантай санал нэг байгаа. Яг хүн амын дунд ковид гарсан хүнд үед манай тухайн үед ажиллаж байсан сайд нар манай эрүүл мэндийн салбарынхан сайн ажилласан. Би бол Мөнхсайхан сайд, Энхболд сайд нарыг үнэлдэг. Үнэхээр энэ хүнд үед эрүүл мэндийн салбараа удирдаж, ард иргэдийнхээ эрүүлийг хамгаалах үйлсэд тодорхой хувь нэмрээ

оруулсан ийм сайд нар. Үүнтэй санал нэг байна. Миний нөгөө гол сая Өрхийн эрүүл мэндийн төв болон сумын эрүүл мэндийн төвийн тухайд бид нар анхан шатны эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулж байж, нөгөө лавлагаа шатын ачааллыг саармагжуулна гэдэг ийм концепцтой байгаа шүү дээ. Тэгэхээр энэ санхүүжилт төсвөөс 100 хувь болгох саналыг шууд шийдвэрлэхгүй. Тэгэхдээ тодорхой санал орж ирж байна. Ингэхээр бид нарын нөгөө чанарыг сайжруулах гээд байгаа асуудалтай маань зөрчилдөх юм биш байгаа. Зэрэгцээ алтернативын ямар арга хэмжээ авахаар төлөвлөж байгаа вэ гэдэг л тодруулга байгаа юм надад.

**П.Анужин:** 3 номерын микрофонд Эрдэмбилиг дарга хариулъя.

**Ц.Эрдэмбилэг:** Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийг бас боловсруулж байгаа. Энэ хууль олон жил гацаж байгаагийн гол шалтгаан нь бид нарт яг нийгмийн эрүүл мэндээс тусламж үйлчилгээг хэн, хаана, яаж үзүүлэх вэ гэдэг энийгээ бид нар зохицуулгаа шийдээгүй байгаа. Сарангэрэл гишүүн маань түрүүн яг хүний нөөц, санхүүжилт, байр савны асуудал гээд аягүй чухал зүйлийг хэлсэн. Тэгэхээр бид нар тэр нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх дэд бүтцээ бий болгоогүй байж байж хууль батлаад явуулбал энэ маань өрөөсгөл байх байх гэж. Ингээд өнгөрсөн хугацаанд бид бүгдийн нэг зорьж хийсэн юм маань энэ Нийгмийн эрүүл мэндийн төв маань өөрөө өөрийгөө авч явах, оршин тогтнох, гүйцэтгэлээр өөрийгөө санхүүжүүлэх боломжийг бүрдүүлэх үүднээс бүх аймгуудад эрүүл мэндийг дэмжих төвүүдийг тус бүр нь 1.8 орчим тэрбум төгрөгөөр шийдвэрлэсэн. Ингэснээр тусламж үйлчилгээ урьдчилан.../минут дуусав/

**П.Анужин:** Эрдэмбилэг дарга асуултад гүйцээгээд хариулъя.

**Ц.Эрдэмбилэг:** Тэгэхлээр аймаг болгон дээр бид нар аймаг, дүүрэг болгон дээр бас эрүүл мэндийг дэмжих төвийг нь барилгатай нь, тоног төхөөрөмжтэй нь, тэгээд 1.8 орчим тэрбум төгрөгтэй нь шийдвэрлээд, ингэснээрээ энэ дээрээ манай ирээдүйн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх төвүүд маань баазлаад, үүгээрээ гүйцэтгэлээрээ санхүүжилтээ олоод, өөрөө өөрийгөө санхүүжүүлээд хөгжих энэ нөхцөлийг нь 2022 онд бүрдүүлсэн байгаа. Үүний ч үндсэн дээр одоо яг бүх нийтийг хамарч байгаа урьдчилсан сэргийлэх, эрт илрүүлгээ үүгээрээ явж байгаа. Үүгээр санхүүжилтээ, гүйцэтгэлээрээ олж байгаа. Тийм учраас бид нар тэгэхдээ Эрүүл мэндийг дэмжих төвийг бол тухайн эмнэлгийнх нь амбулаторид нь харьяалуулаагүй. Тусдаа, бие даасан байдлаар цаашидаа Нийгмийн эрүүл мэндийн төв болж явах гэдэг үүднээс нь амбулаториос нь заавал ч үгүй тусдаа байшин савд засвар хийж ор гэдэг ийм шаардлага тавьж байгаа нь энэ байшин савыг нь шийдэж байгаа асуудал юм байгаа юм.

**П.Анужин:** Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар бид Эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудал, гүйцэтгэлийн санхүүжилт ер нь эрүүл мэндийн анхан шатаас авхуулаад нэгжүүдэд хэрхэн хэрэгжиж байгаа талаар тодорхой мэдээлэл сонслоо. Зөвхөн мэдээлэл сонсоод зогсохгүй тодорхой асуудлууд дээр Эрүүл мэндийн яам цаашидаа авч хэрэгжүүлэх бодлого, гарц гаргалгааны талаар маш тодорхой өнөөдөр сонслоо. Ийм учраас бид өнөөдрийн мэдээлэлтэй холбогдуулан Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төсөл, Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх чиглэлийг хуралдааны тэмдэглэлээр өгөхөөр тогтоож байна.  
17.32 цаг.

**Байнгын хорооны 2022.04.12-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор байгуулагдсан Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг сонсох**

Өнөөдөр хэлэлцэх асуудлынхаа дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. Энэ маш чухал асуудал байгаа. **Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, дүгнэлт гаргах ажлын хэсгийн тайланг бид хэлэлцэнэ.**

Тайланг Улсын Их Хурлын гишүүн, уг ажлын хэсгийн ахлагч Балжиннямын Баярсайхан хийнэ. Гишүүд хүүхэд хамгааллын асуудал орж ирж байна. Ажлын хэсгийн гишүүдийг урьж байна. Балжиннямын Баярсайхан гишүүнийг урьж байна.

**Б.Баярсайхан:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүргийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Баярсайхан. Гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар, Жаргалмаа, Одонтуяа, Оюунчимэг, Саранчимэг, Туваан нарын бүрэлдэхүүнтэйгээр ажиллалаа.

Ажлын хэсэг 11 сарын хугацаанд нийслэл, 9 дүүрэг, 4 аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, түр хамгаалах байр, Ерөнхий боловсролын сургууль, Сургуулиудын дотуур байр, Хүүхэдэдэйн театр, Хүүхдийн төв номын

сан зэрэг соёл, хөгжлийн байгууллагууд, сургалт хүмүүжлийн тусгай байгууллага дээр газар дээр нь очиж үйл ажиллагаатай танилцсан.

Нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, дүүргүүдийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хэлтэс, Завхан, Өвөрхангай, Архангай аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Төв аймгийн Баяндэлгэр, Сэргэлэн сумын гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газруудын үйл ажиллагаатай газар дээр нь биечлэн очиж танилцлаа.

Үүнээс гадна хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөр, төрийн бус байгууллагууд, Монголын хуульчдын холбооны хүүхдийн эрхийн хороо зэрэг байгууллагуудын төлөөлөл, хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг хуульч нар, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид зэрэг нийт 30 гаруй байгууллагын төлөөлүүдтэй уулзалт хийсэн. Ажлын хэсгийн зүгээс хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах эрхэд тулгамдаж байгаа асуудлыг та бүхэнд товчлон танилцуулъя. Үүнд:

Төрөөс хүүхдийн эрхийг хангах, хүүхэд хамгааллын бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулах, салбар хоорондын уялдаа холбоог хангах, төр, хувийн хэвшлийн харилцаа хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлж, шаардлагатай төсөв, хууль тогтоомжийг батлан хэрэгжүүлсэн байна. Гэвч эрх нь зөрчигдсөн, хүчирхийлэлд өртсөн, зам тээврийн осолд орсон, гэмтэж бэртсэн, амь насаа алдсан хүүхдүүдийн тоонд дорвитой өөрчлөлт гарсангүй. Хийгдсэн ажлууд төдийлөн үр дүнтэй биш байна. Өнөөдөр Монгол Улсын хүүхэд хөгжил, хамгааллын бодлого алдагдсан, хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгааг хэд хэдэн статистик мэдээллээс

харж болно. Жил бүр дунджаар зам тээврийн ослын шалтгаанаар 2000, гэр буюу ахуйн хүрээнд 35000 хүүхэд гэмтэж, бэртэж байна. Өсвөр насандаа жирэмсэлж үр хөндүүлсэн 600 гаруй охид байна. Зөвхөн хүүхдийн тусламжийн 108 утсанд 110 мянган гаруй дуудлага ирж байна. Жил бүр 300 гаруй охид бэлгийн хүчирхийлэлд өртөж байна. Улсын Их Хурлаас 2018-2022 онд жил бүр 8 тэрбум төгрөгийг хүүхэд хөгжил, хамгаалал, гэр бүл, залуучуудад зориулахаар улсын төсөвт тусгаж баталсан. Хүүхэд хөгжил хамгааллын зардлыг 2016 онтой харьцуулахад даруй 8 дахин нэмэгдүүлсэн боловч Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын төсвийн гүйцэтгэлийн тайлан биелэлт хүрсэн үр дүн, ажлын үр дүн тодорхойгүй байна.

Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг хорооны хамтарсан багаар дамжуулан үзүүлдэг. Гэвч хамтарсан багт ажиллаж байгаа нийгмийн ажилтны цалин хөлс Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтны цалингаас 2 дахин бага байна. Үүнээс шалтгаалж манай улс мэргэжлийн хүний нөөцийн дутагдалд орж 38.4 хувь буюу 268 нь мэргэжлийн нийгмийн ажилтан, 61.1 хувь буюу 429 нь мэргэжлийн бус нийгмийн ажилтан байна. Хүүхэд гэр бүлийн чиглэлээр мэргэжсэн нийгмийн ажилтан, хуульч, өмгөөлөгч, сэтгэл зүйч бэлтгэх орон тоог зохистой түвшинд хүргэн нэмэгдүүлэх шаардлагатай байна. Хамтарсан багийн ажлын ачаалал их, материаллаг нөөц дутагдалтай, төсөв байхгүй. Мөн эдгээр хүмүүсийн албан тушаалын тодорхойлолт тодорхойгүй байна.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний дараа гэр бүлтэй нь ажиллах үйлчилгээ тодорхойгүй. Уг салбарт мөн л хүний нөөц дутагдалтай. Үүнээс шалтгаалж хүүхэд хамгааллын үйлчилгээнд

хамрагдсан хүүхэд, түүний гэр бүл лд нь дахин хяналт хийж чадахгүй байна. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдэд үзүүлэх хөгжил хамгааллын үйлчилгээ тодорхойгүй, төсөв хөрөнгөгүй, гэрч, холбогдогчдод чиглэсэн үйлчилгээ дутагдалтай байна. Ялангуяа бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд урт хугацааны хамгааллын нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, тэдгээрийн сэтгэл санааны гэм хорыг тооцох, арилгах бодлого стандарт, аргачлал байхгүй байна. Нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны үйл ажиллагаа явагдаж байгаа боловч үйлчилгээний чанар хангалтгүй, хүүхдийн бие махбод болон сэтгэл зүйн үндсэн хэрэгцээг хангахгүй, хөгжил боловсролын үйлчилгээ үзүүлж чадахгүй байна.

Тусгай хэрэгцээтэй болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогт тохирсон үйлчилгээ үзүүлэх бодит нөхцөл бүрдээгүй байна. Уучлаарай би энд ажлын хэсгийн дүгнэлт танилцуулаад байна. Гишүүд ээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил хамгаалал эрхийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, тусгай хэрэгцээтэй болон сэтгэцийн өөрчлөлтөд орсон хүүхдүүдэд эмчилгээ хийх, үйлчилгээ үзүүлэх хүний нөөц материаллаг бааз дутагдалтай байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын барилга нь 1970 онд ашиглалтад орсон. Барилгын насжилт газрын онцлогоос шалтгаалж барилгын зарим хэсэг нурсан байна. Үүнтэй хамааралтайгаар үйл ажиллагааг зогсоосны улмаас халуун усанд орох, бие засах зэрэг хүүхдийн ариун цэвэр, эрүүл ахуйн наад захын хэрэгцээ хангагдахгүй байна. Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн 2012, 2018, 2020 оны актаар барилгын Үйл ажиллагааг зогсоох шийдвэр гарсан ч өдийг хүртэл асуудлыг шийдвэрлэх дорвитой алхам хийгдээгүй байна.

Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаа хүүхдүүдийн үндсэн эрх хангагдахгүй, маш хүнд нөхцөлд хүмүүжиж байна. 18 насанд хүрч халамж, асрамжийн төвөөс гарч байгаа хүүхэд залуусын 40-50 хувь нь мэргэжил эзэмшиж, ажлын байртай болж чаддаггүй. Өөрийн гэсэн өмчгүй, орон гэргүй, хамаатан садны дэмжлэггүй төрийн үйлчилгээ авч чаддаггүй. Эдгээр хүүхдүүд гэмт хэрэг зөрчилд холбогдох, хараа хяналтгүй байдлаар амьдарч байгаад анхаарал хандуулж, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нар одоогийн хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Хүүхдийн номын сан, Хүүхэлдэйн театр, Хүүхдийн урлан бүтээх төв, Хүүхдийн зуслан зэрэг хүүхдийн гэсэн соён гэгээрүүлэх, хүүхэд хөгжлийн чиг үүрэгтэй байгууллагуудын үйл ажиллагааг төрөөс бодлогоор дэмжих шаардлагатай байна. Эдгээр байгууллагуудад барилга байгууламж, засвар үйлчилгээ, хүний нөөцийн асуудал тулгамдсаар байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт байгууллага бүр хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх үүрэгтэй байхаар тусгасан.

Иймд хуулийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хүүхэд хамгааллын бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж гаргаж, байгууллагуудад хүргүүлэх ажил хэт удааширч байна.

Хүүхдүүд сургуулийн орчинд үе тэнгийн дээрлэлт, хүчирхийлэлд өртөж цахим орчинд хүүхдийн эрх зөрчигдөх тохиолдол маш их байна. Тиймээс цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг олон улсын сайн туршилага, жишигт тулгуурлан боловсруулах, нэн яаралтай батлуулах шаардлагатай байна.

Төрөөс тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж байгаа телевиз, өргөн нэвтрүүлгийн зай болон цахим орчинд хүүхдийн эрүүл мэнд, хөгжил, төлөвшил, хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлэхүйц агуулгатай бусдыг гүтгэх, доромжлох, зохисгүй үг хэрэглэх, жендерийн ялгаварлан гадуурхалт, согтууруулах ундаа, шашны харгис урсгал, зан үйл, хүүхдийн эрүүл мэндэд зохисгүй хоол хүнс, сурталчилсан контент, кино зар сурталчилгааны сөрөг нөлөөллөөс хүүхдийг хамгаалах, зарим төрлийн контентыг хязгаарлах бодлого үйл ажиллагааны хэрэгжилт тодорхойгүй байна.

Цахим орчин телевизээр гарч байгаа нэвтрүүлэг нийгэмд үзүүлэх нөлөөнөөс гадна хүүхдийн зан төлөвшилд үзүүлж байгаа нөлөө маш их сөрөг байгаа учраас үүнийг бодлогоор нэн даруй зохицуулах шаардлагатай байна.

Эцэг эх болон хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийг хариуцлагажуулах, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх бодитой механизм бүрдүүлэх шаардлагатай байна. Мөн Нийгмийн ажлын тухай хууль манай Монгол Улсад байхгүй. Нийгмийн ажлын тухай хуулийг нэн даруй бид нар батлуулах шаардлагатай байна.

Гэр бүлийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиудад нэн яаралтай нэмэлт, өөрчлөлт оруулах, Эрүүгийн хууль, Зөрчлийн хуулиуд дэд заасан хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчилд оногдуулах ялын бодлогыг чангатгах шаардлагатай байна.

Монгол Улсын Засгийн газраас гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлд онцгой анхаарч ажиллах болно гэдгээ хоёр 7 хоногийн өмнө илэрхийлсэн. Үүнд Улсын Их Хурлын гишүүний зүгээс үнэхээр баяртай байна. 2025 онд Монгол Улсад хүүхдийн

байгууллага үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ой болох гэж байна.

Өчигдөр 20 гаруй төрийн бус байгууллагуудтай уулзахад зан чанарын доголдол, хүүхдийн зан чанарын төлөвшил, эцэг эхийн хүүхдээ үл хайхрах байдал, эцэг эхийн зан чанарын төлөвшил, эцэг эх байх хариуцлага, ёс суртахуун дээр нөлөөллийн ажлууд хэдий чинээ хийгээд хийгээд үр нөлөөгүй байна гэдгийг онцлон хэлж байсан.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд ажлын хэсгээс Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, хүүхэд хөгжлийн асуудлаар Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд Хяналтын сонсголыг зохион байгуулах, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2016-2022 оны санхүүгийн тайланд аудит хийлгэх, илэрсэн зөрчилд хариуцлага хүлээлгэх шаардлагатай гэж үзэж байна. Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа. Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Баярсайхан.

**П.Анужсин:** Ажлын хэсгийн тайланг танилцуулсан Балжиннямдын Баярсайхан гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн гишүүд хүрэлцэн ирсэн гишүүдийг та бүхэнд танилцуулна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд Зулхар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга Чинзориг, Баярмаа тус яамны Гэр бүл бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга, Тунгалагтамир тус яамны Хүн амын хөгжлийн газрын дарга, Азжаргал Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн, Бадрахбаяр Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газрын дарга, Нямсүрэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга, Нямсүрэн дарга байгаа юм уу. Ирсэн

байна. Түрүүн ирээгүй байсан шүү. Төгсдөлгөр Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын түр орлон гүйцэтгэгч, Нямгэрэл Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга, Доржхуяг Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын ахлах шинжээч, Батбаяр Соёлын дэд сайд, Наранцэцэг Соёлын яамны Соёлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Нямдорж Цахим хөгжил харилцаа холбооны яам Хуулийн хэлтсийн дарга, Хунан Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, комиссын гишүүн. Мөнхнасан Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн газрын дарга, Өлзийхутаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Чинбат мөн төвийн Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Бадамцэцэг Сүхбаатар дүүргийн Хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын хэлтсийн дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй. Ард талд нь байгаа юм байна. Би гүйцээгээд танилцуулъя. Болормаа Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, дэд хурандаа. Хаана байна. Ирсэн байна. Батзориг Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Гэр бүлийн хүчирхийлэл хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа. Ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирсэн байна.

Баярсайхан гишүүний ахалсан ажлын хэсгийн тайлантай холбогдуулж асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Даваажанцаны Сарангэрэл гишүүнээр тасалж байна. Асуулт асууя. Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууна.

**С.Одонтуяа:** Баярлалаа. Тэгээд ажлын хэсгийн даргын тайланг сонслоо. Ажлын хэсгийн ахлагч дээр л хамаг ачаалал өгдөг юм л даа. Тэгээд амаргүй

ажил. Эндээс хэд хэдэн юм асуух гэсэн юм. Энэ тайлан дээр улсын төсвөөс 2022 онд хүүхэд харах үйлчилгээний зардалд 2.1 тэрбум төгрөг зарцуулна гээд, 2023 онд бүүр буурчхаж байгаа байхгүй юу 1.5 болоод. Тэгэхээр хүүхэд харах үйлчилгээний юм чинь харин улам нэмэгдэх ёстой юм биш үү. Энэ төсөв нь яагаад ингээд буурчхаждаг юм бол. Тэгээд ер нь энэ хүүхэд харах үйлчилгээний хууль чинь өөрөө ач холбогдол нь хамгийн чухал хууль гэдгийг л манайхан мэдмээр байна. Цэцэрлэгт хүн бүхэн хүүхдээ өгч чадахгүй, гэр нь хол айл байна, хүргэж өгч чадахгүй хүн байна, орж чадахгүй хүн байна, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй айл байна. Тэгэхээр энийг яагаад ингээд ач холбогдлыг нь улам унагаагаад л Боловсролын яам руу ч нэг шидэж байх шиг. Тэгээд энэ чинь бүр улам цөөрөөд бараг уствал яах юм бэ. Энэ чинь л гол хүүхдийг аюулаас хамгаалах, нөгөө түлэгдэхгүй байх, гадаа гараад хөлдчихгүй байх, тэр хажууд байгаа гэрт байгаа хүнд хүчирхийлэлд өртчихгүй байх, зодуулахгүй байх энэ чинь л гол хүүхэд харах үйлчилгээ байхгүй юу даа. Хүүхэд хамгаалж байгаа. Тэр ээж чадахгүй шүү дээ ганцаараа. Гараад нэг ажил хиймээр байдаг, гараад нэг газар жоохон ч гэсэн мөнгө төгрөг олчих ажил хиймээр байдаг. Тэгээд л тэр хүүхдийг яах аргагүй л гэрт үлдээж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хуулийн ач холбогдлыг ингээд улам унагаагаад байдагт би үнэхээр бүр эрс дур дургүйцдэг. Байнга энийгээ хэлдэг, илэрхийлдэг. Тэгээд л хүүхэд ингэлээ гишүүд дуугарсангүй гээд энэ чинь хуулийг нь батлаад хуульд нь хэдэн төгрөг өгчихөд чинь юу нь болохгүй байна.

2 дахь асуудал. Сая би хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн аав ээжүүдтэй уулзсан дүүргийнхээ. Тэгэхээр аутизмтай хүүхдүүд маш их нэмэгдсэн. Тэгээд эд нартай ажиллах ийм багш нар их дутагдалтай байна. Багш нар ерөөсөө аутизмтай, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллаж

чадахгүй байна гэсэн юм байгаа. Тэгэхээр энэ дээр багш нарыг сая Чинзориг сайд 3 яамны нэлээд чухал зүйлүүд хийсэн. Энэ дээр орох нь уу яах нь вэ. Тэгээд хөгжлийн бэрхиээлтэй хүүхдэд нөхөн сэргэх үйлчилгээ авч чадахгүй байна. Танай тэр нөгөө Баянгол дүүргийн 20 дугаар хороонд байгаа Сонсголонгийн гүүрний тэндэх чинь аягүй холдоод байна. Очоод ихэнх үйлчилгээ нь хийгдэхгүй байна. Ажиллах хүн олдохгүй гээд тэр юу чинь бараг тэгж байгаад сөнөчих юм биш биз дээ. Ерөөсөө үйлчилгээ нь муудчихсан байна гэж байгаа юм. Тэгэхээр энэ асуудал байж байна. Одоо сургуулийн орчны бас хүчирхийлэл дээр бид нар ажиллахгүй бол би сая Боловсролын сайдаас мэдээлэл авсан. Тэр чинь зүгээр талийтал ерөөсөө дабль, триплдээд өсчихсөн байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ чиглэлээр яг ямар ажлууд хийх гээд байна вэ, хийсэн байна вэ гэдгийг асууя.

Тэгээд яах вэ энэ чиглэлд оруулах би нэг саналаа бэлдчихлээ л дээ. Энийгээ яг тэр чиглэлийн тогтоол хэлэлцэх үед хэлье.

Дээрээс нь хүүхдийн эрхийн байцаагч гэж бид нар чинь Хүүхэд хамгааллын хуулийн гол цөм нь байсан байхгүй юу. Одоо бид нар юм болохоор л Хүний эрхийн Комисс гэдэг биз дээ. Хөөе Хүний эрхийн Комисс аль вэ тэнд оч, эд нар очоод ажлаа тогтоо. Гэтэл яг нөгөө хүүхдийн эрх зөрчигдчихөөр яг дахиад л хүний эрх юм уу эсвэл бүр хүүхдийн эрхээр мэргэшсэн байцаагчид гээд байгаа шүү дээ. Тэгэхээр тэр дээр нь нэг яамны ажилчид болгоод л хаячихсан ч байж байх шиг. Яаж энэ чинь тэгэхээр чинь явахгүй шүү дээ. Тэгэхээр энэ асуудал чинь юу болсон бэ. Энэ хэдийг асууя.

**П.Анужин:** Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд Зулпхар хариулъя. 1 номерын микрофоныг өгөөрэй.

**С.Зулпхар:** Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн

амар амгаланг дахин айлтган мэндчилье. Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Манай холбогдох агентлагийн дарга нар бас энэ дээр нэмж хариулна. Улсын төсвөөс хүүхэд харах үйлчилгээтэй холбоотой таны хэлдэг төсөв харьцангуй багассан. Гэхдээ хүүхэд үзэж эргэлт хамрагдалтыг бол нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор энэ зохицуулалт хийгдсэн гэдгийг хэлье. Хүүхдүүдийн ялангуяа жишээ нь төв суурин газрууд дахь үзэж эргэлт хамрагдалт нэмэгдсэн учраас ийм байдлаар өнгөрсөн жилийн төсөв батлагдаж, энэтэй холбоотой зохицуулалтууд хийгдсэн.

2 дахь асуудал. Хөгжлийн бэрхиээлтэй хүүхдүүд тэр дотроо аутизмтай хүүхдүүдэд тусламж дэмжлэг. Тэрнээс гадна эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээрх ажилтан, мэргэжилтэн хүний дутагдал угаасаа байгаа. Энэ чиглэлээр манай 3 яам хамтарсан байдлаар ажлын хэсэг байгуулчихсан бид ингээд 1 сараас хойш ажиллаж байгаа юм. Гэхдээ урьд нь ч гэсэн хийгдэж байсан ажил. Энэ чиглэлээр жишээ нь хөгжлийн бэрхиээлтэй хүүхдүүдийн эцэг эхийг өөрсдийг нь сургаж бас энэ чиглэлээр мэргэшүүлэх, цаашилаад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бол яг ЖАЙКА-ийн төсөл хэрэгжиж байгаа. ЖАЙКА-ийн төслийн хүрээнд хөдөлгөөн засал, хөдөлмөр заслын чиглэлээр сургалтуудыг явуулаад 2 жилийн хугацаанд манай үндсэн төв болон шинээр байгуулагдаж байгаа 6 төв дээр ажиллах улсуудаа бэлдээд явж байгаа. Энэ бол эрсдэлтэй байдлаар бүх төвүүд дээр 2-3 хүнийг бэлдээд явж байгаа ийм ажил бол байгаа. Энэ бол гарцаа байхгүй жишээ нь дутагдалтай мэргэжил. Гэхдээ суралцах хүн тэр болгон олдоод байдаггүй, өвөрмөц ажил байгаа юм.

Хөгжлийн бэрхиээлтэй хүүхдийн Сэргээн засах хөгжлийн төв гэсэн манай байгууллага байгаа юм. Яг хүчин чадлаараа бид 250 хүүхдийг байнгын

байдлаар, 250 хүүхдийг өдрөөр үйлчлүүлэх байдлаар өдөртөө 500 хүүхдэд үйлчлэх ёстой юм байгаа юм. Энд яг хүний нөөцийн бэрхшээл гарсан. Тэр нь нэгдүгээрт тэр газар жосоохон зайдуухан, хоёрдугаарт цалин хөлс нь харьцангуй бага байна гэсэн ийм бэрхшээл гарсан. Бид бүхэлд нь энд ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдын цалин хөлсний асуудлыг салбарын болон төрийн албан хаагчдын цалин хөлсний бодлогын хүрээнд энийг авч шийднэ гэсэн ийм тооцоолол байгаа. Салбар нь өөрсдөө бас ажиллах хүмүүсийн тооцооллыг бидэнд ирүүлж байгаа. Энэ дээр 2 зүйл хувилбар яригдаж байгаа юм. Тэнд ажиллаж нэг хэсэг хүмүүс нь эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудтай адилхан байдлаар цалинжъя гэсэн ийм хүсэлтэй байдаг. Нэг хэсэг нь боловсролын байгууллага юм. Тэнд 3 янзын үйлчилгээ үзүүлдэг л дээ. Нийгмийн засал, эрүүл мэндийн түвшинд засал, тэрнээс гадна боловсролын үйлчилгээ үзүүлдэг учраас энэ чиглэлээр бид саналаа 3 талаасаа нэгтгэнэ гэсэн ийм бодолтойгоор манай хамтарсан ажлын хэсэг ажиллаж байгаа гэдгийг хэлье. Энд хүүхдүүдийг авч өөрсдийг нь авчирч үйлчлүүлэх ийм автобус бид авахаар ийм ажил хийгдэж байгаа. Тендер нь зарлагдаад автобус нь бэлэн болох юм бол хүүхдүүдээ очиж авдаг, тэгээд буцаагаад хүргэж өгдөг ийм байдлаар байхгүй бол ирж чаддаггүй ийм бэрхшээлүүд байгаа гэдгийг хэлье.

Сургуулийн орчинтой холбоотой хүчирхийлэл салбар дундын шинжтэй. Гэхдээ энэ дээр бид Боловсролын яам санаачилсан байдлаар бид оролцсон байдлаар ажил эхлүүлж байна. Өөрөөр хэлбэл сургуульд үе тэнгийнхний хүчирхийлэл, дээрэлхэлтэй холбоотой асуудлыг хэн нэгэн байгууллага гэхээс илүүтэй хүүхдүүд нь өөрсдөө энэ асуудалд орж шийддэг ийм хэлбэрийн санаачилга хийсэн. 3 дүүргийн 3 сургууль дээр 2 аймаг дээр энэ ажил эхэлсэн. Бид энэ туршилагыг тулгуурлаад энийг түгээн дэлгэрүүлж ажиллах ёстой юм байна

гэсэн ийм ойлголттой байна. Бусад асуудал дээр ялангуяа хүүхэд харах үйлчилгээтэй холбоотой зүйл дээр манай Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын дарга нэмж хариулна.

**П.Анужин:** Хариулт дээр нэмж нэг хариулт авъя. Зулхар сайд аа, хүүхдийн сэргээн засах төв дээр цалингийн асуудлаас гадна, удирдлагын асууд байгааг мэдэж байгаа юу. Удирдлага тогтворгүй, удирдлага чинь тэр хамаг хамт олноо бутаргаад байгааг та нар мэдэж байгаа юу. Юм болохоор л цалин гээд ярьдаг. Яг үнэндээ удирдлагын менежмент тэнд алдагдаад, танай яамны харьяа нь танай яам руугаа хуваагдаад, эмч нар нь дотроо эмч гээд ингээд хэдэн бүлэг байж байгааг та бүхэн мэдэж байгаа юу. Энэ асуудал дээр бид нар чиглэл өгчихсөн байгаа. Өмнө нь Сэргээн засах төв дээр манай Байнгын хороо ажилласан. Өнгөрсөн 7 хоногт. Ирэх 7 хоногт та нар сонсоно. Ямар учиртай энийг ингээд улс төрийн томилгоо оруулаад та нар бүхэл бүтэн төвөөр тоглоод 11.8 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрх ашгаар тоглоод яваа юм бэ. Энийг хариулах хүн хамтатгаад хариулаадах.

Зулхар сайд 1 номерын микрофонд удирдлагын асуудлаар чинь бүх юм болж байгаа. Энэ талаар та тодорхой хариулт өгөөрэй.

**С.Зулхар:** Таны асуудаг зүйл үнэн. Өнгөрсөн 7 хоногт та Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв дээр ажилласан. Үүний дагуу та бидэнд чиглэл өгсөн. Энэ чиглэлийн дагуу танд хариу хүргүүлэхээр бэлэн болгосон байгаа. Энэ 7 хоногт танд хүргүүлэе гэсэн ийм байдлаар бид ажиллаж байгаа. Удирдлагын түвшинд тогтворгүй байдал 2020 оноос хойш яг дутагдсан. Дотооддоо удирдлагуудын албан хаагчдаа зөв удирдах, зөв сонгон шалгаруулж, сэдэлжүүлэх гэдэг ч юм уу ийм ажлууд хийгдсэн. Тэрнээс гадна хамт олон дотроо хуваагдсан ийм асуудлууд ирсэн. Гомдол бидэнд 3 удаа



ирсэн. Энэ 3 удаатай холбогдуулаад тодорхой түвшинд удирдлагуудын түвшинд хариуцлага тооцож байсан зүйл бий. Тэр битгий хэл тухайн байгууллагын удирдлагыг сольсон тохиолдол байгаа гэж байгаа юм. Тэгэхээр одоо бол энэ мэргэжлийн удирдлага байх ёстой. Тэрнээс гадна тэр ажлыг сайн мэдэхээс гадна хамт олныг бүрэн жишээ нь удирдаад явах ийм хүнийг бид томилно гэсэн ийм чиглэлтэй байгаа гэдгийг танд хэлье ээ. Хүүхдийн эрхийн байцаагчтай холбоотой Одонтуяа гишүүний асуудал байгаа юм. Хүүхдийн эрхийн байцаагч манай жишээ нь хүүхэд хамгааллын чиглэлээр, хүүхдийн эрхийн зөрчлийн чиглэлээр мэргэжсэн хүмүүсийг байцаагч болгодог ийм бидний сайн туршлагауудын нэг гэж үзэж байгаа юм. Олон улсын байгууллага, Төрийн бус байгууллагууд хүүхэд хамгааллын чиглэлээр, хүүхэд хөгжлийн чиглэлээр байгууллагууд бол өнгөрсөн хугацаанд яг ийм байх ёстой гэдэг ийм чиглэл өгсөн. Тэгээд салбарын байцаагч нар маань уг нь 54 байцаагч байсан. Өнөөдрийн байдлаар 41 байцаагч байна. Улсын байцаагч мэдээж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нь байдаг. Тэгээд ахлах байцаагч нар ажил хариуцсан хүмүүс. Тэгээд яг ажил хариуцсан анхан шатан дээрээ бол байцаагч нар нь үйл ажиллагаа явуулдаг. Тэгэхлээр энэ байцаагч нарыг нэгдүгээрт тэр чиглэлээр мэргэжсэн, тэгээд хүүхдийн эрхийн зөрчил гарах юм бол газар дээр нь ажиллаад тэнд үнэлэлт, дүгнэлт өгдөг. Шаардлагатай нөхцөл тэр асуудлыг шийдвэрлүүлэх ийм асуудлыг шийдээд явдаг ийм нөхцөл байгаа юм. Тэгэхлээр энэ чиглэлээр бид улсын хүүхдийн эрхийн байцаагч нараа цаашдаа ч гэсэн ажиллуулна гэсэн бодолтой байгаа. Энэ дээр нэг зүйл мэдээлэл болгоход хүний эрхийг хангах Үндэсний хороо гээд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэд байгуулагдсан. Энэ байгууллага маань бид хамтраад хүүхдийн эрхийг хангалттай холбоотойгоор асуудлыг авч үзэх гэсэн ийм санал солилцсон. Хүний

эрхийн Үндэсний комисс бас энэ дээр тухайлан энэ асуудалд хамтран оролцоод, бид тушаал гарсан байж байгаа. Ирэх 7 хоноогоос авхуулаад хүүхдийн эрхийн байцаагч нар нь оролцсон байдлаар бүх шатад, бүх салбарт хүүхдийн эрхийн хангалтыг давхар бид нээлттэй хяналт шалгалт хийгээд явахаар байгаа. Энэ хүрээнд Баярсайхан гишүүний гишүүнээр ахлуулсан ажлын хэсгийн гаргасан санал, зөвлөмжүүдийг давхар харгалзаад явна гэсэн ийм чиглэлтэй байгаа.

**П.Анужсин:** Одонтуяа гишүүний түрүүний асуусан асуулт дээр Байнгын хорооны зүгээс нэмж хариулахад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нөхөн сэргээх төв өөрсдийнхөө хүчин чадлаар хангалттай ажиллаж чадахгүй байгаа талаар. Энэ нөхөн сэргээх төв маань энэ яамны харьяанд байх ёстой юм уу, ер нь харьяалал нь яах вэ гэдэг талаар бид Байнгын хороо дээрээ авч хэлэлцэх гэж байгаа юм. Төсөвт нь болдог юм уу, эрх мэдэлд нь болдог юм уу. Та нар өөрсдийнхөө яамнаас тавьдаггүй. Тэгчхээд танай яамны зүгээс хийгдэж байгаа юу ч байхгүй. Та нар зүгээр л газар, агентлаг булаацалдаж байгаа хоорондоо. Түүнээс биш та нар тэр иргэдийн хүүхдүүдийн эрх ашгийн төлөө хуруу, хумсаа огт хөдөлгөхгүй байгаа гэдгийг хэлчихье. Тэгээд ирэх 7 хоногт харьяаллын асуудал яригдана. Бид нар төлөвлөгөөнд оруулсан байгаа. Тэгэхээр дэд сайд та харьяаллын асуудал болоод менежмент, удирдлагын асуудал яг ямар алдаа гарсан юм гэдгийг ирэх 7 хоногт Байнгын хороонд тайлагнана.

Одоо Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууя.

**М.Оюунчимэг:** Ажлын хэсэг хүүхэд хамгааллын асуудлын нухацтай хариуцлагатай ажилласан. Энийг хэлье. Тэгээд хамгийн гол нь энд тусгагдсан зөвлөлүүд тэр байна. Сая Баярсайхан гишүүн маань тодорхой тайлбар, мэдээллүүдийг өгсөн байх. Энэ дээр нөгөө

чиглэл дээр ч тусгагдсан байгаад байгаа юм. Яг зайлшгүй шаардлагатай юмнууд дээр. Бид 2016 онд би жишээ нь Улсын Их Хурлын гишүүн болоод бид нар Нийгмийн бодлогын байнгын хороон дээр асуудал ярихад хүүхдийн байцаагчийн орон тоог нэмэхгүйгээр энэ ажил ер нь явахгүй гээд хэлж байсан. Санхүүжилт нь 600 сая төгрөг байж байгаад танагдаад ороод ирчихсэн, санхүүжилтээ ч шийдэж чадаагүй байсан. Харин 2016-2020 оны Улсын Их Хурлын эмэгтэй гишүүд бид нар төсөв хэлэлцэх болгонд нэгдэж, тэмцэж байж хүүхэд хамгааллын төсвийг яг гаргаж ирсэн тооцоогоор нь 2017 онд 1 тэрбум 600, 2018 онд 6 тэрбум дараа нь 2020 онд 8 тэрбум гээд ёстой нээрээ тооцоолол судалгаатай нь НҮБ-ын Хүүхдийн сан бүх юмтай харьцаж байж, төсөв хэлэлцэх үед лобби бүлгүүд байгуулж байж бид 2019, 2020 оны яг төсөв дээр нь энэ мөнгийг суулгаж өгсөн. Дээрээс нь хүүхдийн байцаагч үнэхээр шаардлагатай байна. Хүүхдийн байцаагч гэдэг байхгүй болчихсон гээд, Нямдорж сайд тухайн үед Хууль зүй, дотоод хэргийн сайдад 130 хүүхдийн байцаагчийн орон тоог хүртэл оруулж өгсөн юм. Тэгээд ингээд хүссэн санхүүжилт, хүний нөөцийг нь бид шийдээд байгаа хэр нь хүүхэд хамгааллын, хүүхдийн хүчирхийлэл буурахгүй байгаад байна шүү дээ. Буурахгүй битгий хэл нэлээд харгис шинжтэй болж эхэлж байна л даа. Тэгээд судалгаануудыг нь та нар маань хүүхдийн байгууллагууд хийж байгаа байх. Шалтгаан нь юу байна гэхээр тэр эрх зүйн орчныг нь, бүрдүүл гэхээр бүрдүүлдэг, санхүүжилтийг нь шийд гэхээр шийддэг. Гэхдээ энэ чинь өөр зүйл байгаад байна шүү дээ. Тийм учраас бид нар энэ чиглэлдээ Анужин дарга аа, тодорхой болгох хэрэгтэй байна. Одоо жишээлбэл 2 дээр байгаа. Хариуцсан нийгмийн ажилтныг бэлтгэх гэхээр нөгөө нэг хороо, дүүргийн нийгмийн ажилтан болчихдог. Тэгэхээр яг нийгмийн ажилтан байх уу эсвэл хүүхдийн байцаагчийн орон тоо одоо

надад Нямгэрэл дарга тэнд сууж байна. 2 зүйл дээр хариулт өгөөдхөөч. Бидний тэр баталсан 130 хүүхдийн байцаагч маань хангалттай байна уу. Эд нар маань хаана ажиллаж байна. Цагдаагийн хэлтсүүдээр ажиллаад байна уу эсвэл гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх баг дотроо ажиллаад байна уу. Гэр бүл, хүүхдийн хамгааллынхан чинь тэр гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх баг дотроо л байгаад байдаг юм байна лээ шүү дээ. Тэрнээс нийгмийн ажилтан чинь өөр үүрэг гүйцэтгээд яваад байдаг. Жишээ нь хороо, дүүрэг дээр харахад. Бараг бүх юм руу л ордог, тэгээд цалин багатай. Сүүлийн үед бүр энд ажиллах хүн ч байхгүй болчихоод байгаа гэж ярьж байгаа. Тэгээд бид нарт манай жишээ нь Чингэлтэй дүүргийн хороодоос хүртэл тийм хүсэлтүүд ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр эсвэл хүүхдийн байцаагчийн орон тоог энэ дээр нэмэх гэж бүр хүүхдийн байцаагч гэж оруулсан нь бараг зөв болох уу. Тэгэхээр энэ нь Хууль зүй, дотоод хэргийн яам дээрээ шийдэгдэх үү. Төсөв хэлэлцэх үед энэ задаргаагаар орох хэрэгтэй. Тэгэхгүй бол одоо ингээд ерөнхий тусгачхаад, нийтээр нь 17.6 тэрбум гэхээр ийм санхүүжилт хөрөнгө мөнгө гээд л дахиад хүүхдийн юм танагдчих учраас энийг задаргаатай оруулж байж үр дүнд хүрдгийг бид 2016-2020 оны хугацаанд мэдсэн л дээ. Тийм учраас энийг задалж бүгдээрээ оруулъя гэж бодож байна.

Тэгээд саяын тэр 3 настай хүүхдийн жишгээс л харахад тэр хаалттай хаалганы цаана хүүхдийн хүчирхийлэл бүр дэндүү болж байна шүү дээ. Хамтран амьдрагч, эцэг эх, ах дүү, төрөл төрөгсөд Хэнтийд болсон хэргийг та нар хар. Тэгэхээр энэ нь өөрөө юу байна гэхээр Гэр бүлийн хуулиар энэ шийдэгдэхгүй юм байна лээ шүү дээ. Тийм ээ Нямгэрэл дарга аа. Тэгэхээр энийг Эрүүгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад хүүхдийн хүчирхийлэл дээр хөнгөлөлт байхгүй болгоод яг л ийм асуудал гарвал ийм хатуу хариуцлага хүлээх юм байна гэдэг тийм заалтуудыг

нь оруулж ирээд, тэгээд энийгээ л бид нар ядахдаа хаврын чуулганаараа эхний ээлжид тодорхой юм хийх хэрэгтэй байна. Тэгэхгүй бол бид яриад л байдаг. Хүүхэд гарсны дараа хэдэн эмэгтэй гишүүд рүү нь ханддаг, тэгээд бид нар ингэх хэрэгтэй, тэгэх хэрэгтэй гээд л оруулдаг. Тэгээд энэ нь яах вэ дандаа төсөвтэй уядаг учраас төсөв баталтал шийдэгдэхгүй. Одоо жишээ нь 2023 оны төсөв батлагдсан юм чинь өнөөдөр энд яригдаад байгаа юмнууд маань 2024 оны төсөв баталтал мөнгө төгрөг байхгүй, сайд нарт багцад нь энд тусгагдсан мөнгө ороогүй гээд энэ асуудал.../минут дуусав/

**П.Анужин:** Оюунчимэг гишүүн асуултаа гүйцээж асууя.

**М.Оюунчимэг:** Тэгэхээр тодотгол хийвэл өөр хэрэг байх. 2 ч варианттай асуудалд бид хандах ёстой. Хэрвээ тодотгол хийвэл ийм зүйлийг бид эхний ээлжид шийдье. Энд 17.9 тэрбумаасаа гээд задаргааг нь гарах. 2-т нь Нямгэрэл дарга Эрүүгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслөө хэзээ оруулж ирэх вэ. Нямбаатар сайд бол энийг эхний ээлжид үүгээрээ асуудлыг шийдье. Харин Гэр бүлийн тухай хөгжлийн тухай хууль буцаад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтайгаа нийлж байгаад эргэж ярих, тодотгох, бүр нарийвчлах асуудлууд байгаа. Энэ өөрөө нөгөө процессын асуудлууд учраас цаг авах зүйл байж магадгүй гэж хэлж байна лээ л дээ. Тэгэхээр яг Хууль зүй, дотоод хэргийн яам дээр энэ хуулийн төслийг өргөн барих, энэ заалтыг чангатгах асуудлууд ямар явцтай байна. Та нар маань хаврын чуулганаар энийг хэлэлцүүлэх бололцоо байна уу. Энэ дээр нэг тодорхой хариултыг авахыг хүсэж байна. Тэгээд бүгдээрээ яг энийг тодорхой болгоод эзэнжүүлээд явъя. Тэгэхгүй бол тэр гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх баг энийгээ дийлэхгүй болчихсон байна лээ.

**П.Анужин:** Оюунчимэг гишүүний асуултад Хууль зүй, дотоод хэргийн яам Нямгэрэл дарга хариулъя.

**Л.Нямгэрэл:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Эхний ээлжид хүүхдийн байцаагчийн талаар асуулаа. Улсын хэмжээнд нийтдээ 215 гэр бүлийн хүчирхийлэл болон хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр яг чиглэлийн байцаагчид ажиллаж байна. Энэ цагдаагийн албан хаагчид. Үндсэндээ цагдаагийн байгууллагын бүтцэд яг өмнө Нямдорж сайдыг байхад шинээр бий болж одоо бол 214 албан хаагч ажиллаж байгаа. Тэгээд ер нь бол хүүхдийн эрхийн зөрчил яг 100 хувь хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой асуудлыг 100 хувь энэ цагдаагийн албан хаагч нар хариуцаж байгаа. Гэхдээ яг энэ хүүхэд хамгааллын асуудал дээр гэмт хэрэг зөрчилтэй холбоотой асуудал болохоос биш яг хүүхэд хамгааллын асуудлыг яг 100 хувь ингээд харахаар нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ болон бусад холбогдолтой асуудал дээр манай цагдаагийн алба хаагч нар чиг үүрэг биш. Ганцхан гэмт хэрэг зөрчилтэй холбоотой асуудал дээр л үндсэн чиг үүргийнхээ ажлыг хийж байгаа. Цагдаагийн байгууллагад одоо байж байгаа хүүхдийн асуудал хариуцсан алба хаагчид бол ажлаа хийж байгаа. Бид үндсэндээ хүүхдийн асуудал дээр цагдаагийн алба хаагч нарыг мэргэшүүлэх, зөвхөн энэ хүүхдийн асуудал хариуцсан, гэр бүлийн хүчирхийлэл хүүхдийн асуудал хариуцсан алба хаагчид гэхээс гадна мөн мөрдөн шалгах чиг үүрэг бүхий мөрдөгчдийг бас хүүхэд хохирсон болон хүүхэд оролцсон гэмт хэрэг дээр хохирогч төвтэй хандлагыг төлөвшүүлэх гэх мэт олон ажлуудыг цагдаагийн алба хаагч нарыг чадавхжуулах ажил хийж байна. Зүгээр энэ дээр харин нэг зүйлийг нэмж хэлэхэд яг хүүхдийн асуудал хариуцсан нийт 214 цагдаагийн алба хаагчийн 80 орчим хувь нь эмэгтэй хүмүүс байдаг юм. Тэгэхээр яах вэ үндсэндээ ажлын байранд ажиллаж байгаа тогтвор суурьшилтай

холбоотой асуудлууд байдаг учраас үндсэндээ ер нь нэг ингээд 1 жил 2 жилийн хугацаанд 40-50 хувь нь өөрчлөгддөг шинэчлэгддэг. Тийм учраас байнгын цагдаагийн алба хаагч нарт зориулсан сургалт зайлиггүй хэрэгтэй. Бид нар яг үндсэндээ бол энэ ажлыг хийгээд явж байна л даа. Тэгэхдээ энэ дээр нөгөө яг энэ ажлын байран дээр тогтворгүй байгаатай холбоотойгоор зарим нэг асуудал байгаа. Гэхдээ сая яг таны асуудаг дээр яг цагдаагийн алба хаагч нарыг хүүхэд хамгааллын асуудлыг бүрэн хариуцуулна гэдэг дээр би яг үнэхээр цагдаагийн алба хаагч нарын хуулиар хүлээсэн чиг үүрэг нь өөр. Тэгэхээр бид салбарууд л хоорондоо хамтарч ажиллаж байж үндсэндээ хүүхэд хамгааллын асуудлыг бүхий л орчинд нь хамгаалах ажил илүү үр дүнд л хүрнэ л гэж би өөрийн зүгээс хэлэх байна.

Таны тантай таны 2 дахь асуултад хариулъя. Эрүүгийн хуульд сая гарсан энэ 3 настай хүүхдийн хүчирхийлэлтэй холбоотой асуудал бол олны анхааралд өртсөн. Тэгэхдээ хууль зүй, дотоод хэргийн яам дээр ажиллаж байгаа Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр байнгын ажлын хэсэг ажиллаж байгаа. Тэгээд үндсэндээ сая бас энэ хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа хүчирхийлэлтэй холбоотой Эрүүгийн хуульд байгаа ял, эрүүгийн хариуцлагыг чангатгах асуудал дээр судалж байна. Ялангуяа Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2016 оны 12 дугаар сард батлагдаад, 2017 оны 2 дугаар сар сарын 1-ээс хэрэгжиж эхлээд 5 жил бүрэн хэрэгжсэн. Тэгээд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль дээр хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийж байна. Үүнтэй холбоотойгоор бид бас энэ хүчирхийлэлтэй холбоотой Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульдаа оруулах нэмэлт өөрчлөлт, түүнийг дагаад Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд орох нэмэлт, өөрчлөлтийн талаар үндсэндээ судлаад ингээд судалгааны ажлууд хийж байна. Тэгэхдээ

судалгааны ажил гэдэг маань зөвхөн хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнээс гадна тодорхой кэйсүүд дээр нийтлэгээр байна уу эсвэл яг энэ дээр ямар асуудал байна. Нөгөө талдаа бас олон улсын туршиллагуудыг үзэх хэрэгтэй байна. Тэгээд дээрээс нь.../минут дуусав/

**П.Анужин:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулъя.

**М.Оюунчимэг:** Уг нь Нямгэрэл дарга туршилагатай хүн Олон жил хүүхэд хамгаалал дээр ажиллаж байгаа. Салбар хоорондын уялдаа байхгүй гээд ажлын хэсгийн дүгнэлт гарсан. Энэ бол үнэн шүү дээ. Тэгээд салбар хоорондын уялдаа чухал гээд ярьж байх биш, харин салбар хоорондын уялдаан дээр ийм эрх зүйн үгийг нь чангалахгүй болохгүй. Анализ, судалгаа гарлаа гээд ярьж байх ёстой хүн чинь судалж байна, анализ хийж байна, туршилт явж байна гээд байх юм. Сая тэгвэл Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн заалтыг нь тэгвэл та нар маань оруулаад ир л дээ. Нэг кэйс биш шүү дээ. Хүүхдийн хүчирхийлэл хүүхэд сая тэр сургууль дээр ярьж байна. Одоо хаалганы цаана ямар айхтар хүүхдийн хүчирхийлэл үйлдэгдээд байна. Тэгэхээр өнөөдрийг хүртэл ингээд судалгааны баг ажиллаад л байгаа гэж ярьж болохгүй шүү дээ. Тэгвэл Эрүүгийн тухай хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулж ирээд, эсвэл эрүүгийнх дээр хэт чангатгах гээд хэт чанга байна гэж үзээд байгаа Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн яг заалт дээр нь бид энэ санкцыг нь чангатгахаар ингээд барихад бэлэн боллоо гээд уг нь сууж байх ёстой шүү дээ. Бид нар уг нь зөндөө л хэлээд байх юм. Тэгээд яг яам дээрээ оччихоод ингээд гацаад байж болохгүй л дээ. Тийм учраас энэ чиглэл дээр хугацаатай үүрэг өгөх саналтай байна.

**П.Анужин:** Оюунчимэг гишүүний хэлж байгаатай санал туйлын нэг байна. Энэ чиглэл дээр хугацаатай үүрэг гэдгийг хүлээж авч байна. Энэ бол маш зөв өө. Бид нар хэдий болтол ингээд нэг нь

асуусан болж, нөгөө нь хариулсан болж бүхэл бүтэн Их Хурлын ажлын хэсэг гарчхаад байхад чинь та нар ажлын хэсгийн тайлан дээр ийм хариулт өгөөд суух юм бэ. Тэгэхээр Оюунчимэг гишүүний хэлж байгаа саналыг хугацаатай үүрэг өгнө гэж маш чухал санал. Одоо Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууя.

**Ц.Туваан:** Чиглэл өгөх тухай байнгын хорооны тогтоолын төсөл хэлэлцэж байгаа. Энэ дээр нэг нэмж тодруулах 3 асуулт байна. Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль гээд бараг хэрэгжиж байгаа, хэрэгжихгүй нь мэдэгдэхгүй болж байна. Тэгэхээр энэ дээр яг түрүүн гишүүд төсөв нь буурсан гэж байна. Энэ дээр юу хариулт өгсөнгүй. Би ойлгосонгүй юу. Тэгэхээр яг энэ гүйцэтгэл дээр хэдэн төгрөг зарцуулсан юм 2022 онд. Хэдэн байгууллага гэдэг юм уу, хуулийн этгээд рүү хэдэн төгрөгийн юу өгсөн юм бэ. Хэдэн байгууллага ажилласан юм бэ энэ дээр гэдэг нэг тодорхой хариулт авчихъя. Хоёрдугаарт хүүхдийн асуудлууд орон нутаг дээр их хүнд болж ирж байна шүү. Юу хүнд болж байна гэхлээр яг тэр хичээл орж байгаа хүүхдүүд дээр нарийн мэргэжлийн тухайлах юм бол хөгжмийн багш, дуу хөгжмийн багш гэдэг мэргэжилтэн маш их дутагдаж байна. Сумын клубт ч тэр, сургууль ч тэр, цэцэрлэгт ч тэр. Энэ дээр ямар бодлого байна. Соёлын яам хэлэх юм уу. Боловсролын яам хэлэх юм уу. Бодлого нь танай 2-ын дунд үлдчихээд байна уу. Энд нэг хариулт авъя.

Хүүхдийн асуудал дээр Боловсролын яам хариулаадхаач. Энэ сургуулийн номын сангийн шинэ ном худалдан авах төсөв хэд байна жилдээ. Яг тодорхой тоо хэлээдхээч. Сумын клубийн номын сангийн шинэ ном худалдан авах төсөв хэд байна. Энийг хэлээдхээч. Цэцэрлэг дээр ч мэдэхгүй бараг байхгүй дээ. Тэгэхээр энэ асуудал дээр нэлээн анхаарах шаардлага байгаа. Хүүхдүүд дэлгэцийн хамаарал маш их

болж байна. Тэгэхээр яг энэ дээр гаргах юм чинь хүүхдүүдийг тэр дугуйлан, секц, хөгжим, ном гээд ийм зүйлүүд байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр орон нутаг дээр яг бодлого бол ондоо болж ирж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв дээр ажилласан. 1 дэвшилттэй юм олж харсан нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсролын яам тэгээд Эрүүл мэндийн яам энэ 3 хамтраад 1 аргачлал боловсруулж байгаа. Хөтөлбөр маягийн юм боловсруулж байгаа цогц. Энийг их олзуурхаж хүлээж авч байгаа. Тэгэхээр энэ бол салбар хоорондын уялдаа гэдэг дээр хөтөлбөр боловсруулагдах юм байна. Энэ дээрээ их сайн анхаарч ажиллаарай. Тэнд нээрээ хөгжлийн бэрхшээлтэй хөөрхий тэр хүүхдүүд чинь бол маш их асаргаа, сувилгаа, маш их анхаарал хандуулах хэрэгтэй. Тэгээд манайд эхэлж байгаа. Тэгэхээр энэ дээр бичиг баримт хэзээ боловсруулагдаж дуусах вэ. Энэ дээр маш сайн анхаараарай. Тэгээд байнгын хорооны түрүүний асуудал дээр харьяаллын асуудал. Энэ дээр би бол гэгээлэг юм харахгүй байгаа. Энэ дээр дахиад л зодолдоно. Юу гэхээр Хөдөө аж ахуйн салбар дээр Хөдөө аж ахуйн мэргэжлийн хүрээлэнгүүдийн асуудал гээд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороогоор ороод л яваад байдаг, ороод л яваад байдаг, тэгээд шийдэгддэггүй. Яг энэ шиг л юм болох байх гэж би харж байна.

Бид нар мэдсэн ч мэдээгүй юм шиг яваад байгаа нэг асуудал. Хүүхдүүд чинь хоолны асуудал. Цэцэрлэгийн хүүхдийн хоолны асуудал, сургуулийн хүүхдийн үдийн цай хөтөлбөр. Энэ чинь юмны үнэ нэг дахин нэмэгдчихээд байхад та нар ингээд нүдээ аниад яваад байж болохгүй. Засгийн газар шийдвэр гаргасныг та нар мэдэж байгаа юу. Яг онтой давхиуулаад тогтоол гаргачихсан байгаа шүү дээ. 1 минутаа авчихъя. Тэгээд энэ ямар тогтоол гэхээр ерөөсөө шуудхан хэлэхэд

бол цэцэрлэгийн хүүхдийн хоолны мөнгийг эцэг эхээс нь.../минут дуусав/

**П.Анужин:** Туваан гишүүн асуултаа гүйцээгээд асууя.

**Ц.Туваан:** Тодорхой хувийг эцэг эхээс гаргуулах гэдэг асуудал яригдахаар салбарын яаманд чиглэл өгсөн ийм Засгийн газрын тогтоол гарсан. Энэ тогтоолыг чинь дагасан хэрэгжилт нь хаана явна. Боловсролын яам энэ дээр нэг хариулаадхаач. Энэ дээр танай яаманд Энх-Амгалан сайдад үүрэг өгсөн Засгийн газрын тогтоол гарсан. Ямар концепцоор энэ асуудалд хандах гэж байна. Тодорхой хувийг эцэг эхээс авах нь зөв гэж үзэж байгаа юу, эсвэл буруу гэж үзэж байгаа юу. Тэгээд ер нь хүүхдийн хоол тэжээлийн хомсдолд маш их орж байгаа юм. Олигтой чанартай хоол идэж чадахаа больсон байгаа. Тэгээд энэ дээр бид нар есийн тосны үнэ 5500, 11 мянга болчихсоныг мэдсээр байж байж, нүдээ аниад чихээ таглаад л алхаад байгаа шүү дээ. Энэ дээр хариулт авъя.

**П.Анужин:** Хүүхэд харах үйлчилгээнээс авхуулаад хариулна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. Дэд сайд Зулпхар хариулна. Дараа нь Боловсролын яам бэлдэж байгаарай. Байнгын хорооны зүгээс Туваан гишүүний асуусан асуултад хариулахад 3 яамдын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан хөгжлийн цогц хөтөлбөр ирэх 7 хоногт бараг Боловсролын байнгын хороо, манай байнгын хороо 2 хамтраад сонсохоор бид нар төлөвлөгөөнд оруулж байгаа шүү. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хариулъя.

**С.Зулпхар:** Туваан гишүүний асуултад хариулъя. Хүүхэд харах үйлчилгээг хүүхэд хөгжил, хүүхэд хамгаалал цаашилаад өрхийн насанд хүрсэн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих гол үндсэн аргачлалуудын нэг гэдэг үүднээс Улсын Их Хурал тухайн үед Нийгмийн бодлогын байнгын хорооноос тухайлан дэмжиж, энийг төсвийг

баталж байсан. Төсөв хэдийгээр 500 сая гаран төгрөгөөр багасаж батлагдсан ч гэсэн энд хамрагдах хүүхдийн тоо багасаагүй. Нөгөөтээгүүр хүүхэд харах үйлчилгээтэй холбоотой стандартын дагуу нэгдүгээрт бид нар сургалт зохион байгуулаад, хоёрдугаарт энд сургалтад хамрагдсан хүмүүсээ үнэлээд хүүхэд харах үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудаа аттестатчилаад ингээд зохион байгуулж байгаа. Өнөөдрийн байдлаар 17 аймгийн 7 дүүргийн 213 хүүхэд харах төв үйл ажиллагаа явуулж байна. Үүнд 589 хүүхэд харагч ажиллаж байна. 2392 хүүхдийг хүүхэд харах үйлчилгээнд хамруулж байгаа юм. Нөгөөтээгүүр хөгжлийн бэрхшээлтэй 127 хүүхдийг тухайлсан байдлаар хүүхэд харах үйлчилгээнд хамруулах ийм зохион байгуулалт хийгээд явж байна. Сангийн яамтай бид ярилцсан. Яагаад гэвэл энэ бол бид хаврын төсөвтэй уялдсан байдлаар хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулж байгаа хэлбэр юм. Ирэх хичээлийн жил 9 сард эхлэхэд бид энэ асуудлыг тухайлсан байдлаар ач холбогдолтой юм байна. Энийг бид үргэлжлүүлэх ёстой юм байна гэдэг ийм хүсэлтийг тавьсан. Сангийн яамнаас энийг дэмжих боломжтой гэсэн ийм нааштай хариу өгсөн байгаа гэдгийг хэлье. Үр дүн их сайн гарч байгаа. Бас энэ дээр нэг зүйлийг ярих ёстой. Хүүхэд харах үйлчилгээтэй холбоотой хууль байгаа юм. Энэ хуулийг бид ахиад нэмэлт өөрчлөлт оруулах ийм шаардлага байна гэж ойлгосон. Яагаад гэвэл хүүхэд харах үйлчилгээний стандарт өөрөө шинэчлэгдсэн, сайжирсан гэж хэлэх ёстой. Энэтэй уялдсан байдлаар дахин зохицуулалт хийх ийм шаардлага гарч байгаа.

**П.Анужин:** Зулпхар сайд нэмээд хариулъя. Шаардлага гарч байгаа гэж байна. Хүүхэд харах үйлчилгээ асуудал болсоор явна шүү дээ. Тэгээд хуулийн төслийн боловсруулалт эд нар хийгдэж байна уу. Яг та нар харччаад зогсчихсон юм уу, юмаа хийж байгаа юм уу.

**С.Зулпхар:** Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дээр ажлын хэсэг гарсан. Сайдын тушаалаар. Тэгээд бид Хүүхэд харах үйлчилгээний хэрэгжилтэд үнэлгээ хийчихсэн байгаа юм. Тэгээд энэ үнэлгээ дээр тулгуурласан байдлаар бид хуульд өөрчлөлт оруулах юм байна гээд саналаа боловсруулаад бэлэн болгосон байгаа.

**П.Анужин:** Соёлын яам ном, хүүхдүүдэд хандсан соён гэгээрлийн асуудлын талаар Соёлын яам хариулт өгье. 4 номерын микрофоныг өгөөрэй.

**М.Батбаяр:** Байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Туваан гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Хүүхэд хамгааллын хуулийн хэрэгжилтийн хүрээнд хөгжсөн хүүхэд хамгаалагддаг гэж манай хүүхэд хамгааллын салбарын мэргэжилтнүүд хэлдэг. Тийм учраас Соёлын яамны зүгээс аль болохоор хүүхдийг хөгжүүлэх орчин, орон зайг бий болгох бодлого, эрх зүйн болон бусад барилга байгууламжууд мөн орчныг бий болгох талаар ингэж ажиллаж байна. Сумын соёлын төвд хөгжмийн багш тогтвор суурьшилтай ажиллуулах асуудал чухал байгаа. Хөгжмийн багш байхгүй гэж хэлэхгүй. Сургуульд. Тийм учраас одоо бидний зорилго бол цалин хөлсний асуудлыг нь нэгдүгээрт бусад салбарын цалин хөлстэй соёлын салбарын ажилтнуудыг тэгшитгэх энэ тооцоо судалгаа гарсан.

2 дугаар асуудал нь төвөөс алслагдсан байдлыг нь харгалзан 5 жилийн нэмэгдэл олгох асуудлыг манай салбарын мэргэжилтнүүд асар их хүлээлттэй байгаа. Энийг энэ 2 дугаар улиралд багтаан шийдвэрлэхээр болсон байгаа. Тийм учраас нэгдүгээрт нь цалин хөлсний хувьд бусад салбартаа жишиглэж тогтвор суурьшилтай ажиллуулах асуудлыг чухалчилж авч үзэж байгаа. Хоёрдугаарт нь мэдээж боловсролын яамтайгаа салбарт шаардлагатай байгаа боловсон хүчнийг бэлтгэх. Мөн түүнчлэн одоо ажиллаж

байгаа хүмүүсийг богино хугацаанд мэргэшүүлэх замаар бэлтгэж байгаа.

Хоёрдугаарт нь хуучин 2018 оноос өмнө сумын соёлын төвд номын баяжилт төвөөс Боловсрол, шинжлэх ухааны яамнаас хийдэг байсан. Төсвийн тухай хуультай холбоотойгоор орон нутагт 2018 оноос шилжсэн. Ингэснээр тодорхой бодлого алдагдсан юм бий. Харин тэгвэл 2022 онд сум бүрд 500 мянган төгрөгийн номын баяжилт хийж байгаа. Тэр дотроо хүүхдийн номын баяжилтыг хийж байгаа. Цаашидаа ч энийг үе шаттайгаар хэрэгжүүлж явна.

**П.Анужин:** Боловсролын яам 1 номерын микрофонд хариулт өгье.

**Б.Гантулга:** Боловсрол, шинжлэх ухааны яам Ерөнхий боловсролын бодлогын удирдлага зохицуулалтын газрын дарга Гантулга байна. Гишүүний асуултад хариулъя. Багшийн дутагдлын асуудал. Энийг яаж нөхөж байн. Дуу хөгжмийн багш гээд. Өнгөрсөн хичээлийн жилээс эхлээд бид бүхэн багшийн дутагдлын асуудлыг нөхөх талаар тодорхой арга хэмжээ авч, чиглэлүүдийг боловсруулж багш бэлтгэх сургуулиудад болон ерөнхий боловсролын сургуулиуд аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргэсэн байгаа. 1200 багшийн дутагдалтай байна гэсэн тоо энэ хичээлийн жилд гарсан. Энэ дотроос дуу хөгжмийн багш нь 83 багш дутагдалтай гэсэн ийм тоо гарсан байгаа. Энийг шийдвэрлэх чиглэл нь болохоороо бид бүхэн ахмад багш нарыг үргэлжлүүлэн ажиллуулах, мөн төгсөх курсийн 4 дүгээр курсийн оюутнуудыг дадлагажигч багшаар ажиллуулах, мөн Боловсролын ерөнхий хуулийнхаа төсөлд болохоороо эрэлттэй байгаа мэргэжлээр багш бэлтгэх сургуульд суралцагчдад төрөөс дэмжлэг үзүүлэх гэсэн энэ заалтыг хуулийн төсөлдөө оруулсан байгаа.

Сургуулийн ном номын сангийн асуудлаар болохоор яг энэ онд болохоороо улсын төсвөөс 2.8 тэрбум

төгрөг төсөвлөсөн байна. Эргэлтийн хөрөнгө буюу сурах бичгийн түрээсийн төлбөрөөс 3.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлж зарцуулахаар төлөвлөсөн байгаа. 1-5 дугаар ангийн сурагчдад сурах бичгийг 100 үнэ төлбөргүй төрөөс жил болгон тэр дундаа 1 дүгээр ангийн сурагчдын сурах бичгийг жил болгон шинээр хэвлэж, хүргэж байгаа. 2-5 дугаар ангийн сурагчдад болохоороо 4 жил тутамдаа шинэчилж сурах бичгийг хүргэж байгаа. Түүнээс дээш ангийн сурагчдыг 40 хувьд нь жил болгон нөхөн хангалтыг хийж байгаа. Цаасан сурах бичгээс гадна [medlee.mn](http://medlee.mn) гээд Боловсролын цахим платформдоо сурах бичгээ PDF хэлбэрээр байршуулсан байгаа. Тэндээс хүн болгон аваад ашиглах боломжтой байгаа. Бид бүхэн сурах бичгээ 1-5 дугаар ангийн сурах бичиг сургалтын хөтөлбөр шинэчлэгдэхтэй холбоотойгоор шинэчлэгдэн боловсрогдоно. Дижитал хэлбэрээр түүнийгээ байршуулахаар платформыг хөгжүүлж байна. 6-12 дугаар ангийн сурах бичгийг бид нар мөн дижитал хэлбэрт шилжүүлэхээр тодорхой төсөв тавиад Боловсрол ажлын судалгааны хүрээлэн бол үүн дээр ажиллаж байна.

Хүүхдийн хоолны зардал дээр сургуулийн үдийн хоолны мөнгө 1500 төгрөг байгаа. Харин дотуур байрны мөнгийг бага, дунд анги дээр 4000 болгож, ахлах ангийг 4300 төгрөг болгож нэмэгдүүлсэн байгаа. Энийг мөн бид нар боловсролынхоо хуулийн төсөлтэй болохоороо тодорхой хувийг өмнөх Боловсролын хуульд ч байгаа. Хүүхдийн хоолны тодорхой хувийг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжиж гаргана гээд. Энэ хууль одоогоор яг энэ хуулийн заалт хэрэгждэггүй. Бид бүхэн шинэ орсон хуулийн төсөлдөө бас энэ заалтаа дахин оруулаад явж байгаа.

**П.Анужин:** Туваан гишүүн тодруулъя.

**Ц.Туваан:** Тэр нэмээд нөгөө сургуулийн номын сангийн нөгөө төсөв, уран зохиолын ном, хүүхэд унших номын

төсвийг би асуусан. Жилд хэд хэд байдаг вэ. Одоо яг хэд байгаа вэ. Тэгэхээр сурах бичиг рүү орчихлоо. Түүрүүний асуултад тэр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам тэр 2022 оны гүйцэтгэлээ нэг хэлээдхээч. Түүрүүнээс хойш 2 гишүүн асуулаа. Тэгээд тоо нь тийм нууц байдаг юм уу. Хэлэхгүй байна.

Дээрээс нь тэр дотуур байрны хүүхдийн хоолны зардал чинь бага анги нэмэгдээгүй шүү. Таны үгэнд сая буруу гарчих шиг боллоо. Эсвэл би буруу сонсон уу. Дунд анги дээр 4000 болгоод, ахлах анги дээр 4300 л болгосон юм байна лээ. Тэгээд бага ангийн хүүхдүүдийн хоолны 3500 чинь хэвээрээ л байна лээ. Тэгэхээр энийгээ тодорхой яг цаасаар хэлчхээч.

**П.Анужин:** Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. Зулхар сайд яг гүйцэтгэлийн тоог л хариул. Оршил илүү юм хэрэггүй. Гүйцэтгэл яасан юм бэ. Тэрийг тодорхой хариулъя.

**С.Зулхар:** 2022 онд 1.1 тэрбум төгрөг батлагдсан. Хүүхэд харах үйлчилгээнд. 176 хүүхэд харах төв үйл ажиллагаа явуулж, 454 хүүхэд харагч ажилласан. Үүнд 2200 хүүхдийг хамруулсан байна гэж байгаа юм. 2023 онд бол энэ тоо нэмэгдсэн. Хүүхэд харагч болон төвүүдийн тоо нэмэгдсэн. Гэхдээ өнгөрсөн жил яг жишээ нь багтаасан төсөвтөө бүгдийг нь зарцуулсан гэсэн үг. Энэ жил бидний төсөв бол дутуу байгаа. Гэхдээ намар бид энийг дахиж энийг нэмж, хүүхэд харах үйлчилгээг үргэлжлүүлнэ гэсэн ийм байдлаар Сангийн яамтай санал солилцсон байгаа.

**П.Анужин:** Боловсролын яам. Номын төсөв. Сурах бичиг яриагүй, номын төсөв. Бага ангийн хүүхдийн дотуур байрны нэг хүүхдэд ноогдох үдийн хоолны зардал нэмэгдсэн үү. Энэ ярьж байгаа тоо чинь үнэн юм уу. Яг энд тодорхой тоо.

**Б.Гантулга:** Сургуулийн номын сангийн баяжилт дээр уран зохиолын



ном сурах бичгээс бусад номын төсөв гэж төсөв төсөвлөгдөөгүй. Бага ангийн дотуур байрны хүүхдийн хоолны зардал 4000. Бага, дунд ангийнх 4000 болсон. Ахлах ангийнх 4300 болсон. Манай яамны зүгээс эцэг эхээс тодорхой зардлыг гаргуулна гэдгийг дэмжиж байгаа.

**П.Анужин:** Боловсролын ерөнхий хуульдаа тусгасан гээд түрүүн хариулсан. Мэдэж байгаа юмнуудаа тодорхой хариулмаар байна. Одоо Даваажанцаны Сарангэрэл гишүүн асуулт асууна.

**Д.Сарангэрэл:** Улсын Их Хурлын гишүүн Баярсайхан хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын асуудлаар тууштай ажиллаж байгаа. Өнөөдөр ч гэсэн үүний нэг илрэл нь хүүхдийн эрхийн хүүхэд хамгааллын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсэгт ахлагчаар ажиллаж, өнөөдрийн нөхцөл байдлыг ингээд б,Байнгын хороондоо оруулж хэлэлцүүлж байна. Энэ их чухал, олон асуудлыг гаргаж тавьсан байна. Засгийн газар болон бусад холбогдох байгууллагуудад үүрэг чиглэл өгсөн тогтоол Байнгын хорооноос гарах юм байна. Энэ бол чухал ажил. Тэгэхдээ нэг анхаарах ёстой зүйл байгаад байгаа юм. Бид нар мэдээж хэрэг тулгамдаж байгаа асуудлуудаар мэргэжлийн Байнгын хороо тодорхой чиг үүрэг өгөх асуудлыг аль болох шуурхай шийдвэрлэх чиглэлд анхаарна. Тэгэхдээ өнөөдөр хүүхдийн эрх байнга зөрчигдөж байгаа. Хүүхэд эрүүл мэнд, амь насаараа хохирч байгаа энэ явдлууд бол ерөөсөө цөөрөхгүй, их хүнд байна. Тэгэхээр үүний үндсэн шалтгаан нь их чухал. Тэгээд үндсэн шалтгааныг бид нар бүгд мэдэж байгаа шүү дээ. Ажилгүйдэл, ядуурал, архидалт гээд олон асуудал байна л даа. Тэгээд үндсэн шалтгаан нь энэ. Нэгэнтээ манай улсын хувьд 3 хүний 1 нь ядуу, нөхцөл байдал хүнд байна шүү дээ. Тэгээд энэ нөхцөл байдлыг илаарьштал бид нар хүүхдийн эрхийн асуудлыг ярихгүй гээд орхих ямар ч эрх байхгүй. Энийг хариуцаж байгаа байгууллагууд байна, төр нь байж байна.

Тэгээд манай улс шиг ийм нийгэм эдийн засгийн нөхцөл байдал нь ийм байгаа улс орнуудад хүүхдийн эрхийг хэрхэн яаж хамгаалдаг юм бэ. Ямар арга хэмжээ авдаг юм бэ. Энэ тал дээр ажил хариуцаж байгаа хүмүүс та нар маань нэг хариу хэлээч. Энэ их чухал байна. Бид нар ийм ижил төстэй орнуудын энэ чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж чадаж байгаа юу гэдэг 1 дүгээр ийм асуудал байна.

Хоёрдугаарт бид нар их олон удаа ярьсан. Бид нар иргэдтэйгээ, ирээдүйн аав ээжүүд өөрөөр хэлэх юм хүүхдүүдтэйгээ ажиллах шаардлагатай. Ирээдүйд байгаа нөхцөл байдлыг давтуулахгүйн тулд засаж залруулахын тулд одооноос ажиллах ёстой. Энэ чиглэлээр ажиллах ёстой газар нь хамгийн түрүүнд мэдээж хэрэг Боловсролын яам, Соёлын яам. Иргэд рүү чиглэсэн би тухайлбал хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон сошиал орчинд ерөөсөө эерэг хандлага болон бодит үйл ажиллагаануудыг ерөөсөө олж харахгүй байна. Энэ чиглэлээр ажиллаж байгаа зүйл байна уу. Ажиллах юм уу, үгүй юм уу. Энэ их чухал байна даа. Тэгээд ингээд хүүхэдтэй холбоотой, хүүхдийн эрх зөрчигдсөн эрүүл мэнд, амь настай холбоотой асуудал гарахаар гэнэтхэн цочоод тэгээд дор бүрдээ мэдэгдэл хийгээд, сошиал орчинд хүмүүсийн янз бүрийн өөр өөрсдийнхөө байр суурийг илэрхийлдэг ийм талбар болгож хувиргаж байна л даа. Тэгээд ийм нөхцөлүүдэд бид нар яах ёстой вэ. Тэгээд л нэг асуудал гарахаар нь зэрэг бүгдээрээ баахан эмгэнэхээд, тэгээд дараагийн гарах тэр эмгэнэлийг хүлээгээд байж байх юм уу. Энэ нөхцөл байдалд энэ ажил хариуцаж байгаа яам, Тамгын газар, мэргэжлийн байгууллагууд та нар маань ямар бодолтой байна. Хариулт авъя даа.

**П.Анужин:** Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд Зулхар хариулна.

**С.Зулихар:** Сарангэрэл гишүүний асуултад хариулъя. Хүүхэд хамгааллын асуудал хүүхэд хөгжлийн асуудлыг хөгжиж байгаа улсууд хөгжилтэй улсууд аль аль нь нийтлэг байдлаар хангаж ирсэн ийм туршилагыг бид өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд олон улсын байгууллагуудын дэмжлэг, туслалцаа, зөвлөгөөний хүрээнд, манай өөрсдийн үндэсний байгууллагуудын судалгаанд тулгуурлан зохион байгуулж байгаа. Нэгдүгээрт мэдээж хэрэг эрх зүйн орчин тодорхой байх ёстой. Энэ чиглэлээр тодорхой эрх зүйн орчин бүрдэж байгаа гэж ойлгож болно. Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль гэдэг ч юм уу.

2 дахь гол асуудал бол энийг хэрэгжүүлэх байгууллагууд юм байгаа юм. Байгууллагатай холбоотой зүйл дээр бид засаг захиргааны нэгжээр дамжсан зохион байгуулалтад энд ордог. Энэ бол яг хүүхэд хамгаалал, хөгжлийн байгууллагуудын түвшинд ярьж байгаа юм. Гэхдээ хүүхэд хамгааллын асуудал бол салбар дундын шинжтэй учраас сургууль энд ордог. Цэцэрлэг энд ордог. Цаашилаад байгууллагууд бас ордог. Хөдөлмөрийн тухай хуулийг та бүхэн мэдэж байгаа. Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3 дахь заалт бол ажил олгогчоос өөрт нь хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх ийм үүргийг олгосон байдаг. Энэ үүднээс нь аваад үзэх юм бол нэг оролцогч тал нь өөрөө ажил олгогч нар байна гэдгийг. Гол зүйл би Сарангэрэл гишүүн байнга ярьдаг. Нэг зүйл дээр бид тодорхой юм байгаа юм. Ер нь олон нийтийг соён гэгээрүүлж, гэр бүлийн түвшинд бол соёлыг нэвтрүүлэх асуудал байгаа юм. Баярсайхан гишүүнээр ахлуулсан хүчирхийллийн эсрэг лобби бүлгийн хувьд ч гэсэн энийг байнга ярьдаг. Тэгэхээр энэ дээр хэвлэл мэдээлэл 4 дэх засаглалын хүрээнд байнга оролцох ёстой байдаг. Өөрөөр хэлбэл хүүхэд хамгаалалттай холбоотой. Тэрнээс гадна хүүхэд хамгааллын чиглэлээр сайн туршилагыг олон нийтэд түгээн

дэлгэрүүлэх чиглэлээр ажиллах ёстой байдаг. Энэ дээр мэдээж хэрэг бид хамтарч ажиллах ийм шаардлага байдаг гэсэн ийм ойлголт байгаа юм.

Сургуулийн орчинд гарцаа байхгүй хүүхэд хамгааллын асуудал яригддаг. Энийг боловсролын байгууллагууд дангаараа хэрэгжүүлэх ажлууд биш. Энэ дээр эцэг эхчүүдийн анхаарал нийгмийн өөрийнх нь анхаарал халамж, нийгмийн анхаарал тавих асуудал яригддаг учраас нийгмийг бүхэлд нь мэдлэгжүүлэх асуудал яригдах ёстой гэж ойлгож байгаа юм.

Манайд хийгдэж байгаа олон улсын туршилага гэж хэлж болох зүйл тэр 108 утас байгаа. 108 утас дээр өнгөрсөн жилийн байдлаар 111 мянга гаран ийм дуудлага ирсэн. Энэ дуудлага бол яг хүүхэд хамгаалалттай холбоотой, хүүхэд зөвлөгөө авахтай холбоотой их чухал зүйл байгаа юм. Гарцаа байхгүй шаардлагатай үед дэмжлэг, туслалцаа үзүүлэх нэг цэгийн үйлчилгээ, түр хамгаалах байрууд ч гэсэн бидэнд шаардлагатай гэдэг нь өнгөрсөн хугацааны туршилагаас харагдаж байна. Өнөөдөр яг 34 ийм нэг цэгийн үйлчилгээ түр хамгаалах байр үйл ажиллагаа явуулж байна. Тэгэхээр бидний хувьд жишээ нь салбар дундын шинжтэй энэ асуудал нийгмийн бүхий л бүрэлдэхүүн болсон байгууллагууд хамтарч байж энэ асуудлыг ард нь гарах юм байна гэдгийг бидний хувьд ойлгож байгаа.

**П.Анужин:** Соёлын яам, Боловсролын яам саяын асуусан асуултад хариулт өгье. 4 номерын микрофонд Соёлын яам хариулт өгье.

**М.Батбаяр:** Сарангэрэл гишүүний асуултад хариулъя. Соёлын яамны зүгээс хүүхэд хамгаалах чиглэлээр, хүүхдийг хөгжүүлэх чиглэлээр, соёл урлагаар дамжуулж хүүхдийн хүмүүжил, нас насанд тохирсон хүмүүжлийг олгох чиглэлээр олон ажлууд зохион байгуулж байгаа. Түүн дээр контент, цахим орчин

дахь ажлууд нэг хэсэг нь. Энэ дээр би хамгийн сүүлийн жишээ хэлэхэд Соёл урлагийг дэмжих сан гэж байдаг. Соёлын яамнаас соёл урлагийг хөгжүүлэх, сурталчлан таниулах, нийгмийн соён гэгээрлийг бий болгох хэмжээнд жил болгон төсөв хуваарилж л сангийн төслүүд шалгаруулдаг. Энэнийхээ 2022 оны нийт санхүүжилтийн 50 хувийг хүүхдэд зориулсан төслийг санхүүжүүлсэн. Энэ дотор нийт 19 төслийг хүүхдийн уран бүтээл, контент бүтээхэд зарцуулсан. Энэнийхээ тайланг хүлээж аваад байн. Мөн түүнчлэн хүүхдэд зориулсан орон зайг бий болгох талаар олон ажлуудыг хийж байна. Музей, номын сан, галерейг үүгээр дамжуулаад. Тухайлбал музей маш олон чиглэлээр боловсролын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ёстой. Тэгвэл сая шинээр ашиглалтад орсон Чингис хаан музейн тухайд нийтдээ 6 музейн боловсролын хөтөлбөр одоогоор хэрэгжиж байна. Мөн түүнчлэн сая музейн нээлттэй өдрийг 5 өдрийн туршид зохион байгуулсан. Нийтдээ улсын хэмжээнд 174,512 хүн үйлчлүүлснээс 5 өдрийн туршид үүнд 80,991 хүүхэд үйлчлүүлсэн. Мөн түүнчлэн соёлын бүтээлч сарыг сүүлийн 2 жил нэлээн өргөн далайцтайгаар 11 дүгээр сарыг бүтэнд нь зарцуулж олон ажлуудыг зохион байгуулж байгаа. 2022 оны хувьд соёлын бүтээлч сараар 21 аймаг, нийслэлд 2063 арга хэмжээ зохион байгуулсан. Үүнд давхардсан тоогоор 1.2 сая хүн соёлын үйлчилгээ авсан. Энэ дотор 277,124 хүүхэд үйлчилгээ авч мөн урлаг, соёлын боловсрол олгох оролцоот хөтөлбөрүүд болон бусад үзвэр үйлчилгээгээр дамжиж үйлчилгээг авсан байна. Дээр нь Хүүхэд, залуучуудын театр ашиглалтад орох гэж байгаа. Сонгинохайрхан дүүрэгт Монгол Улсын хамгийн олон хүн амтай дүүрэгт энэ оны 3 дугаар улиралд багтаж ашиглалтад орно. Хүүхэддэй театр өнөөдөр 1948 оны 7 дугаар сарын 17-ны өдөр сайд нарын зөвлөлийн тушаалаар байгуулагдсан байдаг. 75 жил болж байна. Гэсэн ч Драммын театрын хурлын танхимд өнөөдөр хүртэл үйл

ажиллагаа явуулж байгаа. Энэ жилдээ 30000-45000 хүүхдэд үйлчилдэг. Тэгвэл одоо 2022 оны улсын төсвөөр Хүүхдийн хүүхэддэй театр зурга төсвийн ажил боловсруулагдаад дуусаж байна. Үүнийг 2024 оны улсын төсөвт тусгах ийм зайлшгүй шаардлагатай байгаа. Та бүхэн маань дэмжинэ гэдэгт найдаж байна. Мөн түүнчлэн хүүхдийн номын сан мөн л ялгаагүй 1972 онд хүүхдийн төлөө фондын санхүүжилтээр эхэлж байсныг та бүхэн мэднэ. Одоо ч гэсэн Соёлын төв өргөөд маш жижиг газар үйл ажиллагаа явуулж байгаа. Тэгвэл нийтдээ одоогийн байгаа хүчин чадлаас 5 дахин нэмэгдэх, нийт 4572 метр квадрат талбай бүхий зураг төсөл хийгдээд дуусаж байгаа. 2024 онд улсын төсөвт тусгана гэх мэтчилэн хүүхэд хөгжүүлэх ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулж байгаа. Баярлалаа.

**П.Анужин:** Сарангэрэл гишүүний асуултад Боловсролын яам хариулъя. 1 номерын микрофон.

**Б.Гантулга:** Хүүхэд хөгжил хамгааллын чиглэлээр хийсэн нөлөөллийн ажил гэвэл хүүхэд 2022 оноос 2023 оны хичээлийн жилд хүүхдийн хүмүүжлийн эерэг арга үндэсний сургалтыг 3 үе шаттайгаар багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдийн хүрээнд зохион байгуулсан. Мөн дээрэлхэлтийг зогсоё гэсэн үндэсний хэлэлцүүлгийг мөн зохион байгуулсан. Боловсролын салбарт хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, хамтын ажиллагаа санаачлах шийдэл гэсэн үйл ажиллагааг мөн 1453 цэцэрлэг, ерөнхий боловсролын 848 сургуулийн захирал, эрхлэгч сургалтын менежер, арга зүйч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч, үйлчлэгч, жижүүр зэрэг ажилтнуудын нийт 29.9 мянган төлөөлөгчдөд зохион байгуулсан байна. Мөн түүнтэй зэрэгцээд Боловсролын ерөнхий газар дээрээ яг хүүхэд хамгааллын чиглэлээр цахим сайтдаа ийм модуль боловсруулж 7 хоног тутамдаа эерэг нөлөөллийн ийм постерууд болон бичлэг, ухуулга

сурталчилгааны материалуудыг хүргэж тавьж байгаа. Мөн эрх зүйн бичиг баримтуудыг боловсруулж гаргасан. Тэр Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны орчинд хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам мөн хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам зэргийг батлан ажиллаж байна.

Мөн төсөл хөтөлбөрөөр 260 сая төгрөгийн санхүүжилттэй нөлөөллийн ажлуудыг хийсэн байгаа.

**П.Анужин:** Даваажанцаны Сарангэрэл гишүүн тодруулъя.

**Д.Сарангэрэл:** Аливаа асуудлыг үр дүнтэй болгоход тогтвортой байнгын, урт хугацааны үйл ажиллагаа үр дүнд хүргэдэг юм. Тийм учраас та бүхэн маань энэ тал дээр онцгойлон анхаарах ёстой. 2012-2016 оны Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацааны үед Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын тухай хуулийн ажлын хэсгийг Одонтуяа гишүүн ахалж бид нэлээн дэвшил гаргаж байсан. Тэр үед ярьж байсан асуудал одоо ярьж байгаа асуудал яг бахь байдгаараа байгаа нь хамгийн харамсалтай дүр зураг. Тийм учраас бид нар өнөөдөр Монгол Улсынхаа нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулсан хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхэд хамгаалах энэ бодлогыг явуулахгүй болохгүй нь гэсэн үг. Өөрөөр хэлэх юм бол үндсэн суурь шалтгаантай нь бид нар ажиллах ёстой болжээ. Энийг бол хэдэн жилийн дараа эдийн засаг сайжрахаар ажиллана гэдэг утгаар биш, одоо байгаа боломждоо тулгуурлаад хэчнээн хүнийг ядуурлаас гаргах юм, архидалттай холбоотой чиглэлээр яаж ажиллах юм, нөгөө хүмүүжүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлд хаана яаж ажиллах юм гээд бид нар бага ч хамаагүй эхлэх ёстой болоод байна гэдгийг.../минут дуусав/

**П.Анужин:** Сарангэрэл сайд гүйцээе.

**Д.Сарангэрэл:** Илүүтэй ухамсарлаж энэ асуудалд хандахгүй бол 10 жилийн дараа ч ахиад асуудлаа яриад сууж байх нь ээ. Энэ дээр нөгөө нэг байгууллага хоорондын хамтын ажиллагаа 1 салбарын асуудал биш гээд байгаа чинь энэ байхгүй юу даа. Тэгээд тэгж ажиллахгүй байна. Хангалтгүй байна. Тэгээд та нар минь арай нэг асуудалд жоохон шинэ байдлаар хандаад, жоохон сэтгэлээсээ хандаад, ажлынхаа арга барилыг өөрчлөөч гэдэг ийм саналыг хэлэх гэсэн юм.

Хоёрдугаарт иргэд ялангуяа эмэгтэйчүүдийн зүгээс гэр бүлийн хуулийг хэзээ Улсын Их Хурал хэлэлцэх юм бэ гэдэг асуудлыг байнга тавиад байгаа учраас би Хууль зүй, дотоод хэргийн яам Нямгэрэл даргыг энэ дээр бидэнд хариулт өгөөд орхиоч гэсэн ийм хүсэлт байна. Баярлалаа.

**П.Анужин:** Хууль зүй, дотоод хэргийн яам. 1 номерын микрофонд Гэр бүлийн хуулийг хэзээ оруулж ирэх вэ.

**Л.Нямгэрэл:** Сарангэрэл гишүүний асуултад хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн яам Гэр бүлийн тухай хуулийн үзэл баримтлалыг батлуулаад, төсөл үндсэндээ бэлэн болсон байгаа. Одоо энэ хаврын чуулганд өргөн барих байх. Тэгэхээр ер нь бол бол энэ хаврын чуулганаар хэлэлцэх хуулиуд тодорхой болчихсон байгаа учраас ер нь бол тун яаравчилж байгаа. Тэгээд ер нь бол Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу процессын дагуу бүх хэлэлцүүлгүүдээ хийгээд, саналаа аваад, бүх зүйл бэлэн болсон байгаа.

**П.Анужин:** Баярлалаа. Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах дүгнэлт гаргах ажлын хэсгийн тайлантай холбогдуулж гишүүд асуулт асууж дууслаа. Одоо уг тайлантай холбоотойгоор санал хэлэх гишүүдийн нэрсийг авъя. Балжиннямын Баярсайхан

гишүүнээр тасалж байна. Салдангийн Одонтуяа гишүүн үг хэлнэ.

**С.Одонтуяа:** Ерөнхийдөө нэлээн дэлгэрэнгүй байгаа учраас нэг их санал алга. 2 санал нэмээд биччихлээ.

Нэгдүгээрт хүүхдийн эрхийн байцаагчдын ажил, үүргийн чиглэлийг боловсронгуй болгох, хүүхдийн эрхийн байцаагчдыг нийгэмд таниулах ажлыг эхлүүлэх гээд. Өөрөөр хэлбэл иргэд хүүхдийн эрхийн байцаагч байна гэж мэдэхгүй л байгаа шүү дээ. Тэгэхээр ийм хүүхдийн эрхийн байцаагчид байдаг юм. Эд нар ийм ийм тохиолдолд ингэж ингэж очдог юм. Айл болгон мэдээж дуудаад байхгүй байх. Гэхдээ том том кэйсүүд дээрээ очих ёстой. Иргэд мэдээлэл авах ёстой байхгүй юу. Одоо иргэд яаж байна гэхээр хөөрхий мэддэгээрээ цагдаа руугаа хэлнэ. Нөгөө 108 руугаа хэлнэ. Эсвэл Хүний эрхийн Комисс руу ханддаг. Тэгэхээр яг хүүхдийн эрхийн байцаагч чинь ийм чиг үүрэгтэй юм гээд улам боловсронгуй болгоод, энийг нь нийгэмд таниулах гэдэг нэг заалт оруулсан.

Хоёрдугаарт. 4 дүгээр зүйл дээр 1.4 дээр ийм үг байгаа юм. Асрамж халамжийн төв, түр хамгаалах байр нэг цэгийн үйлчилгээний төвд ажиллах орон тооны сэтгэл зүйч, сэтгэл засалчийг ажиллуулах гэдэг дээр нэмээд дохионы хэлээр ярих чадвартай мэргэжилтнийг бэлтгэх. Хэрвээ тэр тухайн газар нь ийм хүн байхгүй бол онлайнаар тусламж авах боломжийг бүрдүүлэх гэсэн ийм юм байгаа. Өөрөөр хэлбэл энэ механизмаа л бий болгочих гэж байхгүй юу. Одоо тэд нарыгаа бэлдээд тэгээд хэрвээ ингээд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тэр төвд чинь ирэхэд, нэг цэгийн үйлчилгээ дээр чинь ирэхэд тэр хүн нь байхгүй бол шууд онлайнаар тэр хүнтэйгээ ингээд уулзаад ярьчихдаг нэг тийм зүйлийг л хийхгүй бол сая хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ээж аавууд бол энэ дээр маш их санал хэлсэн байгаа. Би энэ 2 саналыг нь томъёолоод бичээд өгчихсөн.

**П.Анужин:** Одонтуяа гишүүний хэлсэн саналыг Байнгын хорооны тогтоолын төсөлд тусгаж байхыг хүсье. Уг ажлын хэсгийг ахалж, хүүхдийн эрх, хүүхдийн эрхтэй холбоотой хуулийн хэрэгжилтэд анхаарал тавьж, үргэлж бас тууштай ажиллаж байгаа Баярсайхан гишүүн маань ажлын хэсгийн тайлан, түүнтэй холбогдуулж гишүүдийн асуусан асуултад хариулсан холбогдох байгууллагуудын хариулттай холбогдуулж таныг үг хэлэхийг хүсэж байна.

**Б.Баярсайхан:** Баярлалаа. Манай хүүхэдтэй холбоотой Их Хурлын Байнгын хорооноос гарах тогтоол нэлээн урт гарна. Тэгээд асуудал нь угаасаа ийм байгаа гэдгийг л илэрхийлж байгаа юм. Тэгээд миний гол яг оношилгоо бол энэ ажлын хэсэг юу гэж дүгнэж байна гэхээр 2016 онд хүүхдийн эрхийг хангах талаар хэд хэдэн хуулиуд, хүчирхийллийн эсрэг хуулиуд гарчихсан байгаад байдаг. Одоо төсөв нь 8 тэрбум төгрөг болчихсон байгаад байдаг. Яг бидний гол хийх ажил энэ бодлого, энэ хууль өнөөдөр хэрэгжүүлж байгаа бодлого яг байгаа онож байгаа юм уу. Энэ төсөв яг хүрч байгаа юм уу. Эндээ үнэлгээ, дүгнэлт хийгээд өгөөч. Энийгээ л үнэлчих. Тэгээд юу нь болохгүй байгаагаа ингээд аваад цаашаа явъя гэхээр энэ ажил ерөөсөө хийгдэхгүй байна. Би энийг ноднин жил л ярьж байсан.

Хүүхдийн хамгаалал гэхээр ганцхан хүчирхийлэлд өртсөн хүүхдийн асуудал биш. Хэл, соёлоо хамгаалах. Одоо Батбаяр сайд аа, би энийг 2 жил дараалан Их Хурлын чуулган дээр асууж байгаа. Өнөөдөр ээжийнхээ хөхийг хөхөж байгаа хүүхэд гар утсаар хөхөө хөхөнгөө гар утас үзээд дандаа гадаад контент үзэж байна. Хэдхэн жилийн өмнө бид нар гадаадад байгаа Монгол хүүхдүүдийнхээ Монгол хэлний асуудалд анхаарч байсан бол хөдөө, орон нутагт хүүхдүүд шууд Yes, No гэж хэлд ороод эхэллээ. Монгол улсын хамгийн үнэт баялаг хүүхэд. Бидний хамгийн үнэт зүйл

хэл соёл. Энэ хэл соёл маань хүүхдүүд маань сурахаа болилоо. Англиар хэлд орж байна гээд. Танай яамнаас хүүхдийн сонирхолд нийцсэн, гар утсанд Монгол контент, нууц товчоо юм уу, Монгол баатруудтайгаа холбоотой ишиг, хурга төл малаа оруулсан ийм сайн контент хийгээд өгөөч гэсэн. Та нар хийж байгаа гэсэн. Өдий болтол хийгдэхгүй байгаа.

Эрүүл мэндийн яаманд эрүүл мэндийн бодлого, хүүхэд хамгааллын бодлого огт байхгүй байгаа. Өнөөдөр жилдээ 600 шахам 12-17 насны охид шүү. 12 настай охид гээд та нар төсөөлөөд үзээрэй. Жирэмсэлж байгаа, хүчирхийлэгдэж байгаа 600 шахам хүүхдүүд абортод орж байна. Өнөөдөр эхний үзлэгийг хийгээд л эмч холбогдох байгууллагуудад мэдээлэх ёстой бол энэ нөгөө салбар хооронд гээд улиг домог болтлоо яриад байгаа ажил чинь хэрэгжихгүй байна. 12 настай хүүхэд ямар байдаг юм бэ. 12 настай хүүхэд жирэмсэлж байна, абортод орж байна. Мөн хүүхдээ төрүүлж байна гээд та нар бодоод үзээч. Яагаад энэ асуудлыг өнөөдөр ингээд байдаг юм шиг бид нар чихнийхээ хажуугаар өнгөрөөгөөд байгаа юм бэ. Тэгэхлээр Эрүүл мэндийн яаманд хүүхэд хамгааллын бодлого заавал хэрэгтэй байгаа. Дахиад нэг зүйл нь хөдөө, сумд мал хариуцсан 5 мэргэжилтэн байхад, хүн, хүүхэд хариуцсан нэг ч хүн байхгүй байгаа. Энийг Нийгмийн бодлогын байнгын хороонд дандаа хүний төлөө хүүхдийн төлөө гишүүд байдгийн хувьд энэ асуудлыг 2024 оны төсөв энэ торон тоог бид нар заавал батлуулах шаардлагатай байгаа.

Зан чанарын асуудлыг бол Олон улсын байгууллагууд ярьж байна. Төрийн бус байгууллагууд, хүн болгон ярьж байна. Ирээдүйд хүүхдээ бид нар ирээдүйд хүчирхийлэлгүй нийгэм байгуулахын тулд одоо хүүхдүүдээ яаж хүмүүжүүлэх юм бэ. Тэгээд сая Сарангэрэл сайдын хэлээд байгаа асуудлууд маш чухал. Тэр архидалт,

ажилгүйдэл, ядуурлын хажуугаар өнөөдрийн эцэг эхчүүдийг соён гэгээрүүлэх, хариуцлагатай эцэг эх байхад бид нар ерөөсөө юу ч хийгээд хэчнээн тэрбум төгрөг зараад шторк хийгээд хэрэгжихгүй байна. Энийг бид нар яаж сайн бодлого болгох юм бэ. Тэгээд 43.3 дахь зүйл, заалтыг гишүүний хувьд Хөдөлмөрийн тухай хуульд оруулсан. Өнөөдөр хүртэл хэрэгжилт нь хангалтгүй. Энэ бол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай шууд холбоотой асуудал байж байгаа. Үүнээс гадна Байнгын хороодын гишүүд маань нийлээд нэг зүйл дээр бид нар яг нэг зүйлийг хиймээр байна. Хүүхдийн байгууллагын удирдлагыг ямар ч улс төржүүлэхгүйгээр, хэн ч, ямар ч нам, засаг солигдсон хүүхдийн байгууллагын удирдлага мэргэшсэн, сэтгэлтэй, чадвартай ийм хүнтэй байх. Өөрөөр хэлбэл хүүхдийн байгууллагуудын удирдлагуудыг улс төрөөс хамааралгүйгээр болгож ингээж цааш нь явахгүй бол Хүүхэд хамгааллын.../минут дуусав/

**П.Анужин:** Ажлын хэсгийн ахлагч Баярсайхан саналаа гүйцээж хэлье ээ.

**Б.Баярсайхан:** Хүүхдийн байгууллагын асуудлыг улс төрийн томилгоогоор биш яг мэргэшсэн хийдэг байхгүй бол бид нар хүүхдүүдээ цаашид нь хамгаалж чадахгүй. Ингээд хүүхдийн эрхийн талаар өнөөдрийн байдлын талаар нээлттэй сонсгол хийхийг хүсэж байна. Тэгээд гишүүдийн үнэтэй саналуудыг хэчнээн урт тогтоол бий болсон ч гэсэн тогтоолын төсөлд тусгуулаад, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээсээ хүсэж байна. Маш их баярлалаа.

18.48 цаг.

### **“Чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл**

**П.Анужин:** Баярсайхан гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн тайланг сонссонтой холбогдуулан Байнгын

хорооны тогтоолоор Засгийн газарт чиглэл өгөх тухай тогтоолын төслийг боловсруулж, та бүхэнд тараасан байгаа.

Тус тогтоолын төслийг та бүхэнд танилцуулсан байгаа. Тогтоолын төсөлтэй холбоотой гишүүдийн саналыг бид нар авч, нэгтгэж боловсруулсан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүд саналаа хэлсэн байгаа. Тэгэхээр Засгийн газарт чиглэл өгөх тухай Байнгын хорооны төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол.

#### Чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6 дахь хэсэг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсгийг үндэслэн Нийгмийн бодлогын байнгын хорооноос тогтоох нь.

1.Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээ хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар чиглэл болгосугай.

НЭГ.Хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд

1/Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгагдсан Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх.

2/хүүхэд, гэр бүлийн асуудал харууцсан нийгмийн ажилтныг бэлтгэх, орон тоог шинээр бий болгох, цалин ерөнхий боловсролын сургуулийн

нийгмийн ажилтны жишигт хүргэх, цалингийн санд шаардагдах 17.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Улсын төсөвт шат дараатай тусгах, Нийгмийн ажилтны тухай хуулийг боловсруулж Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх,

3/Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдийн сэтгэл санааны гэм хорыг үнэлэх, тооцох аргачлалыг яаралтай боловсруулах, хохирогчийн нийгэм, сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээнд үзүүлэх стандартыг тогтоох, хэрэгжүүлж ажиллах,

4/асрамж, халамжийн төв, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвд ажиллах орон тооны сэтгэл зүйч, сэтгэл засалчийг ажиллуулах нөхцөлөөр хангах. Саяын сэтгэл зүйч гэдгийн ард дохионы хэлний мэргэжилтэн нөхцөлөөр хангах онлайнаар тус үйлчилгээг авах боломжийг бүрдүүлэх. Одонтуяа гишүүний хэлсэн санал тусгагдсан байгаа.

5/Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр хамтран баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд, хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал маягт шинэчлэн батлах тухай тушаалын хэрэгжилтийг хангуулах хүрээнд “Тусгай хэрэгцээт хүүхдийн эрт дэмжлэгийн нөхцөл байдлын үнэлгээ”, хүүхэд бүрийг хүчирхийлэлд өртөхөөс өмнө хийх багш, сургууль, цэцэрлэгийн нийгмийн ажилтанд суурилсан “Хүчирхийлэлд өртөж болзошгүй байдлын үнэлгээ”-г боловсруулах ажлын хэсгийг тус 3 яамны төлөөллийг оролцуулан байгуулах, үнэлгээг 2023 оны 3 дугаар улиралд багтаан боловсруулах,

6/Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв дээр сэтгэцийн хурц эмгэг

өөрчлөлттэй хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч нь тогтоогдохгүй байгаа хагас, бүтэн өнчин хүүхдэд үйлчилгээ үзүүлэх бүтэц, орон тоог нэмэгдүүлэх,

7/Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын дэд бүтцэд холбогдсон, ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлтийн дүрэмд нийцсэн шинэ барилгад үйл ажиллагаа хэвийн явуулахад шаардагдах төсөв, хөрөнгийг 2024 оноос эхлэн улсын төсөвт тусгаж, барилгыг 2025 онд ашиглалтад оруулах, шинээр ашиглалтад орох барилгад нүүж орох хүртэлх хугацаанд тус сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад шаардлагатай урсгал засварын зардлыг шийдэх,

8/Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх түр хамгаалах байр нь хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага тусгагдсан хүний үндсэн болон тусгай хэрэгцээг бүрэн хангах, хүүхдэд ээлтэй орчин нөхцөлийг бүрдүүлэх, шаардагдах хөрөнгө, санхүүжилтийг нэмж тусгах,

9/хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийн эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх, хүүхдээс мэдүүлэг авахад зориулж тусгайлан бэлтгэсэн өрөө бий болгох, хүүхдийн эрхийг хамгаалсан бодлогыг хэрэгжүүлж ажиллах, бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдээс мэдүүлэг авахдаа хохирогчтой ижил хүйсийн байцаагчийг ажиллуулах,

10/“Хамтарсан багийн ажиллах үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”-ыг нийгмийн хамгааллын, хууль зүй, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд яаралтай шинэчлэн батлах,

11/Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил, хамгаалал, эрхийн талаарх хууль, тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, хэрэгжилтийг сайжруулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх,

12/Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт заасан байгууллага бүр хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх заалтын хэрэгжилтийг хангуулах хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хүүхэд хамгааллын бодлого, түүний боловсруулалтын талаар зөвлөмж гаргаж байгууллагуудад хүргүүлэх.

ХОЁР.Хүүхдийн тухай хуулийн хүрээнд:

1/Хүүхэд хөгжлийн чиг үүргийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, Хүүхдийн номын сан, Хүүхэддэйн театр, Хүүхдийн урлан бүтээх төвийн барилга байгууламжийг шинэчлэх зардлыг улсын төсөвт шат дараатай тусгаж, шийдвэрлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх үйлчилгээг бүсчилсэн хэлбэрээр ажиллуулах, хүүхдийн хөгжил төлөвшилд хүрч үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэх,

2/цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн нэр төр, алдар хүндэд халдах, гутаан доромжлох, залилах, хүчирхийлэлд уриалах, садар самуун явдлыг сурталчлах зэрэг гэмт хэрэг зөрчлийн үйлдлүүдийг таслан зогсоох, хууль бус үйл ажиллагаатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэн яаралтай авах, хүүхдийн эрхийн байцаагчийн ажил үүргийн чиглэлийг боловсронгуй болгож нийгэмд таниулах ажлыг зохион байгуулах,

3/Хүүхдийг сэрүүн байх цагаар хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэх аливаа төрлийн контент, нэвтрүүлгийг хориглох агуулгатай харилцан ойлголцлын санамж бичгийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Монголын Үндэсний Радио, Телевиз, Харилцаа холбооны зохицуулах хороодтой хамтран 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан харилцан



ойлгоцлын санамж бичгийн хэрэгжилтийг хангах, үр дүнг тайлагнах,

4/Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2016-2022 оны санхүүгийн тайланд аудит хийлгэх, жил бүр хөндлөнгийн хяналт оруулах,

5/Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн цогц үнэлгээ хийж, хэрэгжихгүй байгаа шалтгаан нөхцөлийг тодорхойлох, хэрэгжилтийг хангах зөвлөмж боловсруулж танилцуулахыг Байнгын хороонд 2023 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд танилцуулах,

2.Энэ тогтоолын биелэлтийг Нийгмийн бодлогын байнгын хороонд 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих ажлыг Нийгмийн бодлогын байнгын хороонд даалгасугай.

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П. Анужин.

Бид өмнө нь тогтоолын төслийг та бүхэнд тарааж, танилцуулж гишүүдийн саналыг тусгаж авсан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулж нэмэлтээр санал хэлэх гишүүдийн нэрийг авъя. Оюунчимэг гишүүний нэрийг оруулъя. Нэмэлтээр санал хэлнэ. Оюунчимэг гишүүний нэрийг оруулаарай. Даваажсанцаны Сарангэрэл гишүүн тогтоолтой холбоотой санал хэлнэ.

**Д.Сарангэрэл:** Үндсэндээ тогтоолын төслийг дэмжиж байна. Маш олон чиглэлээр үүрэг, даалгавар өгч байгаа юм байна. Тэгэхээр энийг нэг жоохон арай базах тийм боломж байгаа юу. Эсвэл энэ чигээрээ байх шаардлагатай гэж үзэж байгаа юу. Хоёрдугаарт тогтоолын төгсгөлд тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Анужин даалгасугай.

Байнгын хорооны дарга Анужин гэхээр энэ чинь яаж явдаг билээ. Өөрөө өөртөө. Тогтоолын төсөл тийм байна. Над дээр ирсэн юун дээр байна. Тэгээд энэ чинь өөрөө өөртөө үүрэг, даалгавар өгөөд тэгээд хянана гэвэл жоохон юугүй байх. Анужин-д даалгасугай гээд энд байна. Тогтоолын төсөл надад хамгийн сүүлчийн хувилбарыг өгсөн. Тэрийгээ эргэж харна биз.

**П.Анужин:** Баярсайхан гишүүн хариулъя. Тогтоолтой холбоотой асуулт асуулаа. Үүнийг чиглэл чиглэлээр нь базаж нягтруулах боломж байна уу гэдэг асуултыг асуулаа.

**Б.Баярсайхан:** Би түрүүн яг хэлсэн хүүхдийн асуудал маш их байгаа учраас тогтоолын төсөл хийх ажил бид нарт их байгаад байгаа юм. Уг нь энэ тогтоолын төсөлд тусгагдсан ажлууд аль хэдийн яамнуудын чиг үүрэг, хариуцаж байгаа байгууллагуудын чиг үүрэгт ороод л явж байгаа. Гэхдээ хийгдэхгүй байгаа учраас өнөөдөр нэгдүгээрт, хоёрдугаарт хүүхдийн асуудал ийм хэмжээнд байгаа гэдэг нь л харагдаж байгаа юм. Тэгэхлээр базахаар давхардсан зүйлээ л бид нар нэгтгэнэ үү гэхээс биш энэ ажлууд бүгдээрээ чухал гэж би үзэж байна.

Хоёрдугаарт, ер нь та нар ажиглаад хараарай. Монгол улсад яг хүүхдийн гээд л асуудал ороод ирэхээр дандаа л нэг ард нь хуулийн нэг бүлэг ч гэдэг юм уу эсвэл юу байдаг юм нэг дагалдах маягаар яваад байдаг. Тэгээд бид нар хүүхдээ нэгдүгээрт тавьж, ялангуяа 1990 онд нэгдсэн НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцод нэгдсэн нэг үүрэг байгаа. Аливаа шийдвэр гаргагч нар шийдвэр гаргахын өмнө энэ нь хүүхдийн эрх ашигт сөргөөр нөлөөлөх үү, үгүй юу гэдгийг үнэлэн үзэж байж тэр тухайн шийдвэрийг гаргана. Хүүхдийн эрх ашигийг бүр язгуур эрх ашиг хэмээн үзэж хамгийн дээр тавина гээд бид нар чинь үүрэг хүлээчихсэн улс орон шүү дээ. Тэгэхлээр энэ үүднээсээ өнөөдөр нөхцөл байдал ийм л байгаа болохоор бид нар

хийх ажил нь энэ чинээгээрээ байна гэсэн үг. Дээрээс нь өнөөдөр яригдаагүй, дурдагдаагүй олон ажлууд байгаа. Энэ хурлыг би ганцхан тогтоолын төсөл гаргаад Нийгмийн бодлогын байнгын хорооны ажил дуусна гэж бодохгүй байна. Цаашид энэ чиглэлээр бид нар мөн ажлын хэсэг ажиллаж байх хугацаанд хугацаа хүрээгүй юм уу, очиж амжаагүй газруудаараа Нийгмийн бодлогын байнгын хороогоороо очиж ажиллах ёстой байх гэж би харж байгаа.

**П.Анужин:** Баярсайхан гишүүний хэлсэн саналыг хүлээж авч байна. Мэдээж мэргэжлийн, чиг үүргийн Байнгын хорооны хувьд хүүхэд хамгааллын асуудал, түүнтэй холбоотой хуулийн хэрэгжилтэд Нийгмийн бодлогын байнгын хороо цаашид идэвхтэй анхаарлаа хандуулж ажиллана. Тогтоолын төсөлтэй холбоотойгоор Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн санал хэлнэ.

**М.Оюунчимэг:** Би Сарангэрэл гишүүний хэлсэнтэй санал нэг байна. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол гэдэг чинь хууль, эрх зүйн хүрээнд арай өөр байх ёстой. Энийг базаж цэгцэлж, мэргэжлийн болох хэрэгтэй байна. Тэрнээс энэ чинь Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, салбарын яам, Гэр бүл, хүүхдийн залуучуудын газар нөгөө агентлагийн өдөр тутмын хийх ёстой юмыг бид нар энд ингээд нэг бүрчлэн нуришиж бичих асуудал биш л дээ. Тогтоол хэрэгжих ёстой шүү дээ. Их Хурлын Байнгын хорооны тогтоол хэрэгжих ёстой. Тэгэхээр энэ дээр дахиад Байнгын хороо чамбайруулж ажлын хэсэг маань бас ажлын хэсгийн нарийн бичгийн дарга тэр сууж байгаа. Өмнөх тогтоолуудыг хар. Энэ чинь хэрэгжих ёстой. Тэгээд эхний ээлжид тэр төсөв мөнгөтэй, бүтэц зохион байгуулалттай, томилгоотой ч гэдэг юм уу тэгж эд нарыг цэгцлэх хэрэгтэй. Тэгэхгүй бол энэ дээр ингээд би түрүүн

хэлсэн тэр 17.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг улсын төсөвт шат дараатай тусгах, энэ ганцхан нийгмийн ажилтныг бэлтгэх орон тоотой холбоотой асуудал юм шиг биш. Тэгэхээр энийгээ жосоохон задаргаатай арай Байнгын хорооны түвшиний, Их Хурлын түвшиний жосоохон чадварлаг болгох хэрэгтэй. Тогтоол бол тогтоол шүү дээ. Тэгээд өдөр тутмын хийх ёстой юмнуудыг нь харин энэ хүмүүст тэр чиглэлээр нь үүргүүдийг нь өгөөд, хянаад явчих ёстой. Тэгээд Нийгмийн бодлогын байнгын хороо хяналт тавиад явах биш бид нар хяналт тавих дээр нь хүртэл Улсын Их Хурлын хянан шалгах газар хүртэл байдаг шүү дээ. Ямар газрууд хяналт тавиад явах вэ тэр хэрэгжилтэд хяналт тавихыг Гэр бүл хүүхэд залуучуудын газар чинь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа байдаг бол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь өөрөө тэр харьяалаар явчих гээд энэ тогтоол дээрээ ахлах зөвлөх ярьж байгаад тэр нарийн бичигтэй дахиад ажиллах хэрэгтэй байна. Дэндүү нуриш байна. Тэгэхээр чинь нөгөө хэрэгждэггүй. Бид нар мэднэ шүү дээ. Тэгээд ажиллах хэрэгтэй гэж бодож байна.

**П.Анужин:** Тогтоолын төсөлтэй холбоотой хэлсэн Сарангэрэл гишүүн, Оюунчимэг гишүүн нарын саналыг хүлээж авч байна. Ажлын хэсгийн ахлагч тогтоол дээрээ илүү нарийвчилж ажиллаад ингээд тогтоолын төслөө боловсруулах чиглэлийг өгч байна. Ажлын хэсгийн ахлагч Баярсайхан даргаас Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, хүүхэд хөгжлийн асуудлаар хяналтын болоод нээлттэй сонсгол зохион байгуулах тухай санал дүгнэлтэд хийсэн байгаа. Энэ маань яадаг вэ гэхээр Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 26.4 дэх хэсэгт Улсын Их Хурлын 9-өөс доошгүй гишүүний санаачилснаар хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын

сонсголыг явуулж болохоор заасан байдаг учраас албан бичгээр та Их Хурлын даргад саналаа хүргүүлэх юм бол энд та бүрэн эрхийнхээ хүрээнд асуудалгүй нээлттэй сонсгол болоод хяналтын сонсгол явагдана гэдгийг танд хэлье.

Ингээд 2 гишүүний хэлсэн саналыг тусгаад өнөөдрийн Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэдэг томъёоллоор санал хураалт явуулъя. Байнгын хорооны тогтоолын төсөл 66.7 хувиар дэмжигдэж батлагдлаа.

Хүүхэд хамгааллын чиглэлээр тууштай ажиллаж бүтэн нэг жилийн турш ажилласан тайлангаа Улсын Их Хурлын дэргэдэх Нийгмийн бодлогын байнгын хороонд танилцуулсан Баярсайхан гишүүн танд баярлалаа.

Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан учраас өнөөдрийн хуралдаан өндөрлөлөө. Хуралдаа идэвхтэй оролцсон гишүүд ажлын хэсгийн гишүүд та бүхэндээ баярлалаа.

19.02 цаг.

**Дууны бичлэгээс буулгасан:**  
**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**  
**Э.СУВД-ЭРДЭНЭ**